

АНАГААХ УХААН

ЭРҮҮЛИЙГ ХАМГАЛАХЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ



МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨГӨӨ, ЛЕКЦ, ТОЙМ



ТУРШЛАГА СОЛИЛЦЬЁ



ХОВОР ТОХИОЛДОЛ



ЭРДЭМТДИЙН ДУГНЭЛТ ЗӨВЛӨМЖ



ГАДААД ОРНУУДАД

БНМАУ

ЭРҮҮЛИЙГ ХАМГАЛАХ ЯДМ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ

ПРАКТИКИЙН

УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛ

17 дахь жилдээ

3

1986

Орон бүхний пролетари нар нэгдэгтүн!

БНМАУ

Эрүүлийг хамгаалах Яам
Эрдэм шинжилгээ-практикийн
улирал тутмын сэтгүүл

АНАГААХ УХААН

17 дахь жилдээ № 3 (59) 1986 он

АГУУЛГА

Анагаах ухааны эрдэм шинжилгээний ажлын байдал, цаашдын зорилт 5

ЭРҮҮЛИЙГ ХАМГААЛАХЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Ш. Жигжидсүрэн — Анагаах ухааны дифференциаци, интеграци	9
Ө. Омбортогтоо, Л. Ролзодмаа — Улаанбаатар хотын зарим эмнэлэгт үзүүлэхээр иргэгчийн нэг өдрийн судалгааны дүн	15
Д. Намжил — Эмнэлгийн байгууллагын орны ашиглалтанд хийсэн судалгаа	18

СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ

Г. Зуунай, Р. Баянбаа — Говь-Алтай аймгийн хүн амын өсөлтийн зарим асуудал	21
Ц. Хайдав, Ч. Долгор, Б. Хүрэлчүүлүүн — Арьсны зарим өвчний үед доторын нийлбэр бодистой нохойн хошууны тосыг хэрэглэсэн дүн	25
Б. Шижирбаатар, Г. Пүрэвсүрэн — Зүрхний гажигтай эмэгтэйчүүдийн ургийн байдлыг хэт авиааар судалсан дүн	28
Ш. Чадраабал, Д. Эрэксэн — Ходаодын архаг үрэвслийн үед хэрэглэх эмчилгээний хоолны асуудалд	31
М. Алтанхүү, П. Нямдаваа, Г. Хоньчин, А. Г. Анджапаридзе, Т. Е. Ворожбиева, Ё. Батболд, Ж. Оюунбилэг, Т. Гомбосүрэн — Вирус судалалын аргаар ялган оношлосон цочмог гепатитын үндсэн хэлбэрүүдийн клиник-биохимиийн төрх	35
К. Анаргул — Мухар олгойн хурц үрэвсэлт өвчний оношийн алдааны зарим асуудал	40
М. Онгар — Баян-Өлгий аймгийн нэгдсэн эмнэлгийн анестези-реанимацийн тусламжийн хүрээ	43
Д. Отгонбаатар, Г. Үүжээ — Салмонелл тифимуриумыг судлах асуудалд	45

МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨГӨӨ, ЛЁКЦ, ГОЙМ

Г. Лхагважав, Л. Ганболд, Д. Нэргүй — Эгмийн доорхи венийг сэтгүүрдэх, түүний хүндрэлээс сэргийлэх	48
Р. Нямаа — Нүдний өвччөлийн динамикийн зарим үзүүлэлт	51
Л. Эрдэнэбаяр, С. Бямбасүрэн — Архины солиорлыг оношлох, эмчлэх асуудалд	53
С. Цоодол — Оношийн үнэний асуудал, оношлогооны алдааны танин мэдэхүйн шалтгаан	58
Г. Энхдолгор, В. Кордач, П. Мартасек — Порфирины өвчний оношлогоо эмчилгээ	61
Г. Навчсан, Г. Оросоо, Д. Батчулуун — Хүүхдийн эрүүл мэндийн тухай ойлголт	64
Д. Жодов — Перитонитын ангиллын зарим асуудал	67
Б. Очир — Гэдэсний халдварт өвчний голомтыг дүн бүртгэлийн аргаар судлах нь	69
Ш. Жадамбаа — Клиник лабораторийн судалгаанд ижилсгэсэн аргуудыг нарийгах асуудал	71
Б. Чулуунхүү — Электрокардиограммд зүрхний цахилгаан тэнхлэгийг тодорхойлохын оношийн холбогдол	74
О. Сүхбаатар — Ерөнхий мэдээ алдуулах	76

ТУРШЛАГА СОЛИЛЦЬЁ

Н. Цэнд, Ч. Чулуунбаатар — Тэргүүн туршлага нэвтрүүлэх асуудал 79

ХОВОР ТОХИОЛДОЛ

Т. Эрхэмбаатар — Умайн гадуурхи жирэмсний нэгэн ховор тохиолдол 82

ЭРДЭМТДИЙН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

С. Манлай — БНМАУ-ын сургуулийн сурагчдын харааны байдалд хийсэн эмнэл зүй, эрүүл ахуйн судалгааны зарим асуудал 84

Г. Батмөнх — БНМАУ-ын өндөр уулын бүсэд оршин суугч нутгийн хүмүүсийн зүрх судасны системийн үйл ажиллагааны зарим үзүүлэлтийн онцлог 85

ГАДААД ОРНУУДАД

И. С. Марков, Э. Пүрэвдаваа — Дархлалын олдмол дутагдлын хамшинж 87

МЭДЭЭ

Пролетарии всех стран соединяйтесь!

Министерство Здравоохранения
МНР
Научно-практический ежеквартальный журнал

МЕДИЦИНА

Выходит 1970г № 3 (59) 1986 г

СОДЕРЖАНИЕ

Современное состояние и дальнейшие задачи научно-исследовательской работы по медицине 5

ОРГАНИЗАЦИЯ ЗДРАВООХРАНЕНИЯ

Ш. Жигжидсурен — Дифференциация и интеграция в медицине	9
Ө. Омбортава, Л. Ролзодма — Однодневная перепись обращаемостей населения в некоторых поликлиниках г. Улан-Батора	15
Д. Намжил — К вопросу анализа использования коечного фонда в медицинских учреждениях	18

КЛИНИКО-ЭКСПЕРИМЕНТАЛЬНЫЕ ИССЛЕДОВАНИЯ

Г. Зунай, Р. Бямба — Некоторые вопросы воспроизведения населения Гоби-Алтайского аймака	21
Ц. Хайдав, Ч. Долгор, Б. Хүрэлчулун — Результаты применения мази, состоящей из суммы веществ карнитериса, при некоторых кожных заболеваниях	25
Б. Шижирбатор, Г. Пуреевсурен — Результаты ультразвукового исследования состояния плода у беременных женщин с пороками сердца	28
Ш. Чадрабал, Д. Эржэн — К вопросу диетотерапии больных хроническим гастритом	31
М. Алтанху, Г. Нямдара, Г. Хоньчин, А. Г. Анджапаридзе, Т. Е. Ворожбиева, Е. Батболд, Ж. Оюунбилэг, Т. Гомбосурен — Клинико-биохимическая характеристика основных форм острых вирусных гепатитов, дифференцированных при помощи специфических маркеров	35
К. Ааргул — Ошибки в диагностике острого аппендицита	40
М. Онгар — Анестезиологи-реаниматологическая помощь в объединённой больнице Баян-Ульгейского аймака	43
Д. Отгоц-Баттор, Г. Ужсе — К вопросу изучения сальмонелла тифимуриума	45

ОБЗОРЫ, ЛЕКЦИИ, КОНСУЛЬТАЦИИ

Г. Лхагважав, Л. Ганболд, Д. Нэргүй — Катетеризация подключичной вены и профилактика ее осложнений	48
Р. Няма — Некоторые показатели динамики глазной заболеваемости	51
Л. Эрдэнэбаяр, С. Бямбасурен — К вопросу диагностики и лечения алкогольного психоза	53
С. Цоодол — Проблемы истинности диагноза и гнеосологические причины диагностических ошибок	58
Г. Энхдолгор, В. Кордач, П. Мартасек — К вопросу диагностики и лечения Порфириновой болезни	61
Г. Навчсан, Г. Оросо, Д. Батчулуун — Понятия о здоровье ребёнка	64
Д. Жодов — Некоторые вопросы классификации перитонита	67
Б. Очир — Статический метод изучения очагов кишечных инфекций .	69
Ш. Жадамба — К вопросу усовершенствования унифицированных методов в клинико-лабораторном исследовании	71
Ё. Чулунху — Диагностическое значение определения электрической оси сердца	74
О. Сухэ-Батор — Общее обезболевание	76

ОБМЕН ОПЫТОМ

Н. Цэнд, Ч. Чулунбатор — К вопросу внедрения передового опыта	79
---	----

РЕДКИЙ СЛУЧАЙ

Т. Эрхэмбатор — Редкий случай внематочной беременности 82

ДИССЕРТАЦИОННЫЕ ВЫВОДЫ И РЕКОМЕНДАЦИИ УЧЁНЫХ

С. Манлай — Некоторые вопросы клинико-гигиенического исследования состояния зрения школьников МНР 84

Г. Батмөнх — Особенности некоторых физиологических показателей сердечно-сосудистой системы у коренных жителей в высокогорных условиях МНР 85

ЗА РУБЕЖОМ

И. С. Марков, Э. Пуревдава — Тайнственные AJDS гипотезы и факты 87

ХРОНИКА

АНАГААХ УХААНЫ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН БАЙДАЛ, ЦААШДЫН ЗОРИЛТ

Манай нам, засгаас анагаах ухааны эрдэм шинжилгээний ажлыг сайжруулах, материаллаг бааз, боловсон хүчинээр хангахад байнга анхаарал тавьж ирсэний үр дүнд анагаах ухааны эрдэм шинжилгээний ажлын чанар, түвшин дээшилсээр байна.

1981—1985 онд Эрүүлийг хамгаалах яамны харьяа эрдэм шинжилгээний байгууллагауд 5 даалгавар, 32 сэдвээр эрдэм шинжилгээний ажил хийсний дунд олон тооны шинэ бүтээл, эм бэлдмэл, оновчтой санал, улсын стандарт, зовломж заавар гарлаа. Эрдэм шинжилгээний байгууллагауд, ЗХУ-ын холбогдох хүрээлэн, институттэй ажил төрлийн холбоотой ажиллаж зарим сэдвээр хамтарсан судалгаа шинжилгээний ажил хийсэн нь зохих ач тусаа очг байна.

Анагаах ухааны хүрээлэнгийн хамт олон ЗХУ-ын Эрүүлийг хамгаалах яамны харьяа Бүх Холбоотын Нийгмийн эрүүл ахуй, эрүүлийг хамгаалахын зохион байгуулалтын эрдэм шинжилгээний хүрээлэнтэй хамтарч манай орны 170 гэрийн мянган хүнийг судалж, БНМАУ-ын хүн амын өвчлөлийн ерөнхий түвшинг тогтоолоо.

Тус хүрээлэнгийн зүрх судасны мэс заслын хамтлаг хүүхдийн зурхний гажигийг мэс заслаар эрт эмчлэх арга, насанд хүрэгчдийн зурхний гажигийг тогс эмчилж эдгээх, улмаар хиймэл хавхлага тавьж эмчлэх аргыг эмнэлгийн практикт нэвтрүүллээ. Нээлттэй зурхэнд хийх хагалгаа улам боловсронгуй болж байна.

Ардын эмнэлгийн хүрээлэн ургамал, амьтаны гаралтай 10 гаруй шинэ эм хийж эмнэлгийн практикт нэвтрүүлэв.

Эх нялхсиг хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэн ЗХУ-ын холбогдох хүрээлэнтэй хамtran хүүхдийн амьсгалын эрхтэний цочмог ба архаг өвчинүүдийн сюш, эмнэл зүйн асуудлыг судалж, цочмог ба архаг түгээмэл өвчинийг үр дүнтэй эмчлэх, урьдчилан сэргийлэх арга, жирэмсэн эхчүүд, эмэгтэйчүүд, бага наасны хүүхдийг диспансерчлах систем зэрэг практикийн ач холбогдолтой ажлууд хийлэв.

Анагаах ухааны дээд сургуулийн эрдэмтэн багш нар судалгаа шинжилгээнийхээ ажлын дунд 4 шинэ бүтээл, 24 оновчтой санал, 23 аргачилсан зөвлөмжийг эрүүлийг хамгаалах байгууллагад шилжүүлжээ.

Эрүүл ахуй, халдварт, нян судлалын улсын институт "В" гепатитын вирусын гадаргуугийн эсрэг төрөгч ялган авах аргачлал боловсруулж, "В" гепатитын эсрэг ийлдсийн вакцин бий болгох ажлын үндсийг тавьсаны дээр амьсгалын эрхтэний дочмог өвчин үүсгэгчийн биологи, экологийн судалгааг хийж байна.

Хүрээлэн байгаа орчныг бохирдлоос урьдчилан сэргийлэх, туунийг багасгах бүрдэл арга хэмжээ, улс ардын аж ахуйн объектуудад ариун цэвэр, халдварт судлалын хяналт тогтоох боловсронгуй аргыг тус тус практикт нэвтрүүллээ.

Биобэлдмэл цусны үйлдвэр, шинжилгээний институт 6 шинэ бэлдмэл хийж тэдгээрийг үйлдвэрлэх технологи, стандартыг боловсруулсан байна.

Гэвч эрүүлийг хамгаалахын онөөгийн тулгамдсан зорилтыг шийдвэрлэхэд өгөөж багатай ажлыг олон жил үргэлжлүүлж, цаг хугацаа алдаж, улмаар эрдэм шинжилгээний ажлын үр ашиг, чанарыг бууруулж байгаа поцтой дутагдал эрдэм шинжилгээний зарим байгууллагын ажилтны дотор байсаар байна.

Өнгөрсөн таван жилд эрүүлийг хамгаалах салбараас 50-иад хүн эрдмийн зэрэг хамгаалжээ.

Эрүүлийг хамгаалахын хэмжээгээр 200-аад эрдэмтэдтэй болж тоогоор улсдаа дээгүүр байранд явж байна. Гэтэл эрдэмтдийн зөвхөн зургааны нэг нь эрдэм шинжилгээний хүрээнд, институт зэрэг байгууллагад ажиллаж байгаачийн учир дутагдалтай юм.

Эрдэм шинжилгээний нэг сэдовт зохиол, зөвлөмж, эзэндээ юм уу номын сангийн тавиур дээр хэвтэж эмнэлгийн хэрэгцээний жинхэнэ "туухий эд" болж чадахгүй байна. 1981—1985 онд эрдэм шинжилгээний байгууллагаас гаргасан зөвлөмж, заавар 200 гаруй хүрсэн боловч түүнээс манай эрүүлийг хамгаалахын тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийн дорвitoй бүтээл ховор байгаа нь тэдгээр заавар, зөвлөмжийн "ашигт үйлийн коэффициент" тун тааруу байгааг илтгэж байна. Өнгөрсөн таван жилд томоохон онол, таамнаалууд дэвшиж гарсангүй. Энэ нь эрдэм шинжилгээний ажлын онолын түвшин, эрдэмтдийн авьяас чадварыг дээшлүүлэх явдал онцгой шаардлагатай байгааг харуулж байна.

Эрдэм шинжилгээний ажлын үр дүн дээшлэхгүй байгаагийн шалтгаан нь нэг талаас эрдэм шинжилгээний ажлын сэдвийг сонгохдоо эрүүлийг хамгаалахын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх талаас биш эрдэмтний өөрийн "сайн дурын" сэдв сонгож байгаатай холбоотой байгаа бөгөөд нөгөө талаас эрдэм шинжилгээний ажлын үр дүнг практикт нэвтрүүлэх механизм боловсронгуй боллооогүйтэй холбоотой байна. Зарим эрдэмтэнд шинэ сэтгэлгээ, тоц авьяас дутагдаж байна.

Эрдэм шинжилгээний ажлын үр дүнг практикт нэвтрүүлэхэд ЗХУ-ын туршлагаар "Эрдэм шинжилгээ-сургалт-эмчилгээний хамтлаг" (нэгдэл) байгуулж ажиллуулах нь чухал ач холбогдолтой юм. Энэ тухай 1986 онд Эрүүлийг хамгаалах яамны сайдын 44 зодүүгээр тушаал гарсан. Ийм хамтлаг буюу "турван холбоог" зохион байгуулж ажиллуулах нь эрдэм шинжилгээ, сургалт, практикийн интеграцыг гүнзгийрүүлж эрдэмтдийн санал зөвлөмжийг эмчийн одөр тутмын ажилд түргэн хугацаанд цаг алдалгүй нэвтрүүлэх боломжтой болгох юм.

МАХН-ын XIX их хуралдээр п. Ж. Батмөнх хэлэхдээ "Шинжилэх ухаан, техникийн ололтыг ашиглахтай холбогдолгүй шийдэх үйлдвэрлэлийн болон нийгмийн нэг ч асуудал байхгүй.

Энэ чухам юу гэсэн үг вэ? Юуны урьд шинжилэх ухаан үйлдвэрлэлийн холбоог бүх талаар бэхжүүлэхээс оөр зам байхгүй гэсэн үг. Улс орны амьдралын тэргүүн ээлжинд дэвшигдэн тавигдаж байгаа асуудлыг судалж, шийдвэрлэхэд эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтдийн хүчийг оновчтой төвлөрүүлнэ тэсэн үг. Нөгөө талаар манай яамд үйлдвэр, аж ахуйн байгууллагууд тухайн салбарыг хөгжүүлэх бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэхдээ шинжилэх ухаан, техникийн ололтод тулгуурлах ёстой. Тэд шинжилэх ухааны байгууллага эрдэмтэдтэй ажил хэргийн байнгын холбоотой байх ёстой гэсэн үг" гэж эрдэм шинжилгээ, практикийн байгууллагын холбоог бэхжүүлэхийн чухлыг цохон заалаа.

Ийм учраас анагаах ухааны эрдэм шинжилгээний ажлыг эрүүлийг хамгаалахын тулгамдсан асуудал руу, эмнэлгийн бэйгүүллагыг анагаах ухааны эрдэм шинжилгээний ажил руу эргүүлж, шинж-

лэх ухаан, техникийн ололтыг дээд зэргээр ашигладаг болгоход бидний эн тэргүүний зорилт оршиж байна.

Анагаах ухааны эрдэм шинжилгээний ажлыг хөгжүүлэхэд эрдэм шинжилгээний боловсон хүчин гол уургийг гүйцэтгэх ёстой билээ. Мэргэжлийн зонхилох салбараар эрдэмтэд бэлтгэх тэгэхдээ суурь болон хавсрата судалгааны чиглэлээр бэлтгэж байгаа эрдэмтдийн тооны харьцааг зов тохируулах явдал их ач холбогдолтойт анхаарах хэрэгтэй.

Манай улсад ажиллаж байгаа анагаах ухааны эрдэмтдийн эрдмийн зэрэг хамгаалсан мэргэжлийн тойм судалгааг гаргаж үзэхэд зохих дүгнэлт хийх зүйл ч ажиглагдаж байна.

Одоо манайд мэс засал, дотор, халдварт судлал, эрүүл ахуй, бичил амь судлал, хүүхэд, эх барих-эмэгтэйчүүд, эрүүлийг хамгаалахын зохион байгуулалтын салбарт тус бүр 7—13 эрдэмтэн байхад халдварт өвчин, урологи, хүүхдийн мэс засал, эндокринологи, вирус судлал зэрэг салбарт нэгээс хэтрэхгүй эрдэмтэн байна. Харшил судлал. хүүхдийн халдварт өвчин зэрэг зарим салбарт эрдмийн зэрэгтэй хүн огт алга.

Эрдэм шинжилгээний ажилтанд тавих шаардлагыг өндөржүүлэх хэрэгтэй байна. Одоо хүүхэд, эх барих-эмэгтэйчүүдийн чиглэлээр 16, эрүүл ахуй, халдварт судлалын чиглэлээр 20-иод эрдэмтэн ажиллаж байгаа боловч урьдчилан сэргийлэх, эх нялхсын эрүүл мэндийг хамгаалах асуудал шаардлагат хэмжээнд хурэхгүй байгааг энэ салбарын эрдэмтэд зүй ёсоор хуваалцах ёстой.

Эрдэм шинжилгээний байгууллагад он удаан жил ажиллаж эрдмийн зэрэг, цол ахисан “ахмад”-ууд, тэрчлэн эрдмийн зэрэг шинээр хамгаалагчид нь санаа амирлангуй байдалд орж, ажлынхаяа эрчийг сулруулж, бүтээлийн тоо ба чанар, практик огоөжийг бууруулдаг дутагдал ургэлжилсээр байна.

Аспирантураар боловсон хүчин бэлтгэх, эрдмийн зэрэг горижлох мэргэжлийн чиглэлийг эрдэм шинжилгээний ажлын ойрын болон хэтийн төлөвлөгөөг үндэслэн тогтоох, аспирантурт элсэх болон эрдмийн зэрэг горилогоор батлуулах хүмүүсийг сайтар сонгох нь эрдэм шинжилгээний боловсон хүчин бэлтгэхэд чухал ач холбогдолтой юм.

Эрдэм шинжилгээний байгууллагын зохион байгуулалт, бүтэц, орон тоог улам боловсронгуй болгох, гүйцэтгэх ажлын чиглэл, хүрээ, ачааллыг тогтоох, удирдлагын боловсон хүчинийг зов сонгож, шаардлагын өндөр түвшинд ажиллуулах, эрдэм шинжилгээний ажилтны мэргэжил мэдлэгийг байнга дээшлүүлэх, мэргэжлийн дахин шалгаруулалтыг чанар сайтай, хариуцлагатай хийх явдал өнөөгийн нэн чухал асуудал болж байна. Эрдэм шинжилгээний бүтээл багатай, мэдлэг, чадвар тааруухан ажилтныг тодорхой хугацаанд үүрэг өгч ажлыг сайжруулах нэрийдлээр „энхрийлж“ байдаг дутагдлыг эцэс болгох хэрэгтэй байна.

Эрдэм шинжилгээний байгууллагууд эмчилгээ, үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэх, эрүүлийг хамгаалахын хөгжлийг түргэтгэхэд чиглэсэн зангилаа асуудлаар өөр, хоорондоо хамтран ажиллаж тодорхой үр дүнд хүрэх хэрэгтэй. Энэ талаар хөдөлмөр, материал, санхүүгийн нөөцийг нэгтгэн төвлөрүүлэх арга хэмжээ авч болох юм.

Анагаах ухааны эрдэм шинжилгээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах ажилд өөрчлөлт гаргахыг цаг үе шаардаж байна. Сүүлийн жилүүдэд хавсрата судалгааны чиглэлүүдийн төлөвлөлт, агуулга хэлбэрийн хувьд арай дээрдсэн юм. Энд Шинжлэх ухаан, техникийн улсын хороо, Эрүүлийг хамгаалах Яамны хувь нэмэр багажийн бий.

Гэвч анагаах ухааны суурь судалгаа, захиалга-даалгавар болон аж ахуйн гэрээний үндсэн дээр гүйцэтгэх ажил хоцрогдож байна.

Төлөвлөлтийг цаашид боловсронгуй болгож, сайжруулах нэг гол арга зам бол программчилсан зорилтот төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх явдал юм. Ийм төлөвлөгөөний үрээр эрүүлийг хамгаалахын тулгамдсан асуудлыг судалж, шийдвэрлэхэд эрдэм шинжилгээний байгууллагын хүч, хөрөнгийг төвлөрүүлэх боломжтой болж, ур дүн ч тодорхой гарах болно.

Одоо эрүүлийг хамгаалах салбарт хавдар судлалын, хоол судлалын гэхчилэн хэд хэдэн зорилтот программ бий. Гэтэл эдгээр программууд "түгжээтэй" байгааг, уул программыг гардан хариуцагч байгууллага хүмүүс анхааралдаа авч ойрын хугацаанд хэрэгжүүлж, биет ажил болгож эхэлбэл зохино.

Эрдэм шинжилгээний ажлыг шаардлагат хэмжээнд хийхэд орчин үеийн аппарат, тоног төхөөрөмжөөр иж бүрэн хангасан материалыяг бааз зайлшгүй чухал.

Манай эрдэм шинжилгээний байгууллагуудын материалаг бааз тарамдуу байгаад дүгнэлт хийж, эрдэм шинжилгээний байгууллагын туршилт, сорилтын баазыг тоноглох техникийн нэгдсэн бодлого, эрүүлийг хамгаалах салбарын шинжлэх ухаан, техникийн түүшинг тодорхойлж, тус улсын анагаах ухааныг 2000 он хүртэл хөгжүүлэх үндсэн чиглэлийг боловсруулж хэрэгжүүлэх нь нийт эрдэм шинжилгээний байгууллагуудын эрхэм зорилт мөн.

ЭРҮҮЛИЙГ ХАМГААЛАХЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Асуудал хөндсөн өгүүлэл

Доцент Ш. ЖИГЖИДСҮРЭН

АНАГААХ УХААНЫ ДИФФЕРЕНЦИАЦИИ, ИНТЕГРАЦИИ

Улсын клиникин төв эмнэлгийн өрөнхий эмч, доцент Ш. Жигжидсүрэнгийн бичсэн энэ өгүүлэл нь манай эрүүлийг хамгаалахын хөгжлийн онөөгийн шатанд эмнэлгийн нарийн мэргэжлийн туслаамжийг хэрхэн зохион байгуулах тухай асуудлыг сэдсэн байна. Энэ өгүүлэлтэй холбогдуулан эрдэмтэн, эмч, мэргэжилтэн, эрүүлийг хамгаалахын зохион байгуулагч нар саналаа ирүүлж, манай сэтгүүлийн хуудаснаа бодол, саналаа өргөн солицдохыг урьж байна.

Сэтгүүлийн редакци

Интеграци, дифференциаци нь материйн зохион байгуулалтын бүх үе шатанд байх катогори юм. Анагаах ухааны хувьд бол интеграци, дифференциацийг хоршуулан авч үзэх, шийдвэрлэх нь чухал ач холбогдолтой.

Бид хөгжингүй нийгэмд амьдарч байгаа болохоор тавигдаж буй асуудлыг давшигүй шийдвэрлэх явдал тулгарч байна.

Хүний бие махбодын бутэц, үйл ажиллагаа хүрээлэн буй орчинтойгоо мөн өөр хоорондоо шягт уялдаа шүтэлцээтэй оршдог. Энэ бол биологийн интеграци юм. Нөгөө талаар эрхтэн эд, эс ч бутэц, үйл ажиллагааны өөрийн гэх онцлогтой нь дифференциаци бөгөөд хүний бие махбод гэгдэх нэгэн бүхэл бүтэн зүйлийн зовхон нэг хэсэг нь билээ. Бүхэл бүтэн зүйл дотроо ялгаврыг агуулж байдаг.

Нийгмийн бүрэлдэхүүнийг нас, хүйсээр нь ялган үзвэл интеграци, дифференциацийн бас нэг хэлбэр болно.

Эмч өвчтөний харьцааг авч үзвэл интеграцийн нэг жишээ юм. Өрөнхий мэргэжлийн тухайлбал дотрын эмчийг нарийн мэргэжлийн эмч нарын нийлбэр, цул нь гэж үзвэл зохино. Ийм болохоор өрөнхий мэргэжлийн эмч өвчтөний талаар бүх баримт сэлтийг төвлөрүүлэн цуглувуулж, дүн шинжилгээ хийж, зохицуулж байдаг. Энэ тун чухал зүйл бөгөөд эмч нарын ихэнх хэсэг нь дээрх үүргийг гүйцэтгэх зайлшгүй шаардлагатай.

Мэргэжлийн дифференциаци нэлээд олон хүчин зүйлээс хамаарах бөгөөд өрөнхийдээ ургалаа явагддаг гэж болно.

Анагаах ухааны гумораль (шингэний) онол 2000 шахам жилийн турш оршиж тогтнов. Бие махбодын шингэний харьцаа өөрчлөгдсөнөөс эмгэг үүсэх тул анагаах ухаан эдгээр шингэний өөрчлөлийг судалж, түүнийг хэвийн болгох арга замыг хайж олоход чиглэх ёстой хэмээн үздэг байжээ.

Гумораль шингэний өөрчлөлийг засахыг орэлдогч эмч нарыг философич, шарх, яс хугарах зэргийг эмчилж ойр зуурын хагалгаа хийдэг эмч нарыг жирийн дархан гэж үзэж байлаа. Бас ус, рашаан, шавраар эмчилж иллэг хийдэг хүмүүс ч байжээ.

XVIII—XIX зуун болоход мэс засал, эх барихын практикт ихээн хэмжээний түршилага, мэдлэг хуримтлах бэлсноор шинжлэх ухааны нэр хүндийг олж, мэргэжилтнүүд нь эмч гэгдэх болжээ.

Эдгээр шинжлэх ухааны хөгжилт анатоми, физиологийн шинжлэх ухааны хөгжлийн үр дүнд түүний тодорхой үе шатанд явагдсан дифференциацийн үзэгдэл болно.

Ийнхүү оношилгоо, эмчилгээний арга олширсоор байсан тул эдгээрийг нэг эмч эзэмших боломжгүй болов.

Улмаар физик химийн шинжлэх ухааны ололтыг анагаах ухаанд ашиглах нь нэн өсч, үүний дунд жишээ нь рентген туяагаар оношилох, эмчлэх-рентгенологи (рентген-радиологи) физикийн хучнийг хэрэглэн эмчлэх-физиотерапи, байгаль рашаан, шавраар эмчлэх-курортологи (рашаан-сувиал) бие махбодын сэхээн амьдруулах-реаниматологи тэх зэргээр шинжлэх ухааны шинэ салбар, мэргэжил салбарласаар байна.

Бидний амьдраи буй энэ зуунд нийгэм, шинжлэх ухаан урьд үзэгдээгүй хурдаар урагшлах болж анагаах ухаан, эруулийг хамгаалахын дифференциаци улам хүчтэй явагдах болов. Бид кардиологи (зүрхний өвчин), пульмонологи (уушгин өвчин) гематологи (цусны өвчин), нефрологи (боөрний өвчин) зэрэг салбар шинжлэх ухаан хэрхэн хөгжих болсныг нүдээр үзэж биеэр оролцсон билээ.

Халдварт өвчний шалтгааныг нээснээр зөвхөн түүнийг эмчлэх бус үр дүнтэй сэргийлэх санааг төрүүлж улмаар халдвар судлал (эпидемиологи) салбар төрөн гарав. Энэ нь урьдчилан сэргийлэх анагаах ухааны эхлэл байлаа.

Эмчлэх, урьдчилан сэргийлэхээс гадна сэргээн засах анагаах ухаан-реабилитаци амжилттай хөгжиж байна.

Нэг их удалгүй мэргэжлийн анагаах ухаан жишээ нь: инженерийн, жүжигчийн, багшийн, удирдах ажилтны гэх зэргээр цаашид салбарлах болно. Энэ нь хүн бүрийн онцлог байдалд илүү дохомтэй анагаах ухаан байх юм.

Дэлхийн эруулийг хамгаалах байгууллагын мэдээгээр орчин үеийн анагаах, ухааны 172 мэргэжил байгаа ажээ. Одоо шинжлэх ухаанд 10000 өвчин, 100000 орчим шинж, одий тооны эм бүртгэгдээд байна.

Орчин үеийн томоохон эмнэлэгт жил тутам хা�гас сая орчим сорил тавигдаж, энэ нь 4—5 жил тутам хоёр дахин өсч байна.

Бичил биетнийг нээж, тэдгээрийн эмнэл зүйн нөлөөтэйг тогтоосноор халдварт өвчнийг судлах нэг салбар бий болж салбарлан хөгжсоор байна. Халдварт өвчний мөн чанарыг мэдэх болноор өвчнийг зөвхөн эмчлэх бус түүнээс амжилттай урьдчилан сэргийлэх арга замыг боловсруулан хэрэгжүүлэв.

Эрүүл мэндийт хамгаалах тухай эртний шинжлэх ухаан болох эрүүл ахуйн ухаан цоо шинэ төрхийг оляс санитари, эпидемиологи зэрэг хэдэн арван салаа мөчир үүсгэж „урьдчилан сэргийлэх анагаах ухаан“ гэж нэрлэгдэх болов.

Эмчилгээ урьдчилан сэргийлэхийн зэрэгцээ орчин үед ондоо нэг анагаах ухаан бий болсон нь сэргээн засах буюу реабилитаци юм.

Мэргэжлийн анагаах ухааны зорилго нь хүн бүрт түүний бие бялдрын онцлог, орчин, хөдөлмөрийн нөхцөлдөө дасах, эрүүл мэндэд муугаар нөлөөлөхөөс сэргийлэх хувь хүнд тохирсон арга хэмжээг авч явуулахад оршиж байна.

Хөгшрөлтийн (геронтологи), удамшилын (генетик) тухай шинжлэх ухаан ч амжилттай хөгжиж байна. Гэтэл зарим салбарыг дан нэг чиглэлд хамааруулж үл болно. Жишээ нь: хооллох тухай ухаан (диетологи) нь урьдчилан сэргийлэх, эмчлэх, хөгшрөлтөөс хамгаалах ач холбогдолтой юм.

Асар удахгүй онго, хөгжим, бүр үнэрээр эмчлэх, урьдчилан сэргийлэх сэргээн засах мэргэжил бий болно.

Ийнхүү анагаах ухааны дифференциацийн цөн тооны томоохон салбарыг дурдахад ийм байна.

Орчин үед өвчтөн өөрт тохиолдсон эмгэгийг чухам хэн оношлосон болохыг мэдэхэд хэцүү болжээ.

Атеросклерозын шинжийг нүдний эмч анхлан оношлож, зүрхний цахилгаан бичилгийн мэргэжилгэн хэээ нэгэн цагт болж өнгөрсөн шигдээсийг илрүүлэх нь цөөнгүй байдаг. Өвчний оношийг олон мэргэжлийн эмч нарын хүч гаргаж цуглуулсан мэдээлэл (шинж тэмдэг) дээр тулгуурлан тогтоодог билээ.

Өвчин эмгэгийн шинэ шинжийг нээн олж байгаа яиз бүрийн эмгэгийн шинж адил тостай, өвчний эхэн үед тодорхой шинж илрэхгүй тул сиеншийг тогтоох эмчээс өндөр мэдлэг, баялаг туршлагыг шаардах чимхлуур ажил юм.

Гэвч анагаах ухаан хэт салбарлан бутарч, цуглуулсан баримт мэдээлэлдээ живж байгаа мэт ойлгож болохгүй.

Анагаах ухааны мэргэжлийн дифференциацийн эзлэх хувийн жин, гүйцэтгэх үүрэг, шинжлэх, эмчлэх аргын хувьд адилгүй байдаг.

Шинжлэх ухаан бүр өөрийн биет юмс, арга зүйн нэгдлээр өөрийн шинж чанараа илэрхийлж байдаг. Биет юмс харьцангуй тогтмол бараг оөрчлөгддөггүй элемент богоөд тухайн хүний нас, эрхтэн зэрэг нь объект болно. Харин арга зүй нь хувьсагч хүчин зүйл богоөд юмыг танин мэдэх, сорчлах, эзэмшихэд шинэ зам нээж байдаг. Тэгэхээр арга зүй нь дифференциацийн гол тулгуур цөм нь болдог.

Цусны талаархий бидний мэдлэгийг авч үзье. Гематологийн шинжлэх ухаан сдостийн түвшинд серология, коагулоги, трансфузологи зэрэг олон салбартай болжээ. Бас үлаан цогцосын, цагаан цогцосын, цусны удамшлын өвчний маргэжилтэн гэж ялган үздэг бслов. Дээрх жинэ нь паркийн дифференциацийн үр дунд гарч ирэх ба биет зүйлийг танин мэдэж, цаашдын чиг замыг зааж өгдгийг харуулна.

Орчин үеийн шинжлэх ухаан, техникийн хувьсгалын шинж төлөв нь урьд омно хэзээ ч байгаагүй хөгжлийн өндөр хурдаар тодорхойлогдоно. Үүнтэй уялдан арга зүйн хувьд ч шинэ шинэ боломжийг нээн өвч байна. Учир ниймээс бид өндөр парийн мэргэжлийн дифференциацийн эрчимтэй хөгжлийн үед амьдарч байна,

Археологийн анагаах ухааны баталж тогтоосноор неоандертол-чуудын дөнгөж 40% нь 14 насыг түүнээс ердоө 5% нь доч, тавь насладаг байжээ.

Манай зуун эхлэх үес римчүүд дунджаар 22 нас насалж байлаа.

XIX зууны эдийн засгийн хөгжил бүхий орнуудын хүн амын дундаж наслалт 25 байсан бсл одоо 70 хүрээд байна. Орчин үеийн хүн дунджаар 150 наслах боломжтой.

Нөгөө талаар сдоогийн анагаах ухааны дээд сургуулийг шинэ тогссон эмч 40—50 жилийн урьдах нэртэй профессороос илүү тусламжийг өвчтөнд үзүүлэх чадвар бүхий өндөр мэдлэгийг эзэмшиж байна.

Гэхдээ шийдвэрлэх асуудал олон байна. Зэвсэг хурц бол төдий чинээ анхааралтай ажиллах ёстой.

Мэс заслын хутганаас „хурц“ эм олон болжээ. Ийм бэлдмэл олон зуугаар тослогдох богоөд болгоомжгүй хэрэглэвэл тус болохгүй хор болох нь бий. „Тус болохгүй бол хор битгий бол“ гэсэн эртний уг одоо ч сургамжтай хэвээрээ байна. Преднизолон

сайн эм. Гэхдээ болгоомжгүй хэрэглэвэл ходоодны шарх үүсгэж болно. Цитостатик бэлдмэлүүдийг хянуур хэрэглэх ёс бий. Ер жирийн витамиин ч гаж урвал нолөө үзүүлнэ. Хөдөлмөрчдийн дотор эмийн гаж нелөөг сурталчиллах, эмч нарын эмийн мэдлэгийг дээшлүүлэх явдал чухлаар шаардагдаж байна. Эмийг хэдэн арваар нь ууж тарлаа хийлгэж байвал сэтгэл ханадаг, бур эмч наарт тулган шаарддаг хүний тоо тун олон болжээ.

Элдэв өвчинийг анагаан эдгээх, урьдчилан сэргийлэх гол арга бол амьдрал, хөдөлмөрийн зөв дэг журам гэдгийг ойлгодоггүй хүн байна гэж үү? Эмч бид нар ч олон эм огех арга барилд бас дасжээ.

Хүн бурийн бие махбодын эмийг хүлээн авах чадвар тун ч олон янз. Нэг эмийн тун нэг хүнд үйлчлэхгүй байхад нөгөөд нь хүчтэй үйлчлэх жишээтэй. Ийм болохоор зарим улсын томоохон эмнэлгүүдэд „эмгэг зүйн эмийн мэргэжилтэн“ ажиллуулж байна.

Анагаах ухаан, эрүүлийг хамгаалахын аль аль нь хурдан хотжиж шинжлэх ухаан техникийн ололт ирмүүн нэвтэрч байна. Шинжлэх ухааныг байгаль ертөнц, амьдрал, нийгмийн хөгжлийн хуулийг нээн судлах-суурь судалгаа, эдгээр хуулийг практикт нэвтрүүлэн хэрэгжүүлэх-хавсралт судалгаа гэж хуваахыг нийтээр хүлээн зөвшөөрсон билээ.

Манай орны анагаах ухааны эрдэм шинжилгээний байгууллагууд үндсэндээ хавсралт судалгаа явуулж байна.

Суурь судалгаа явуулсан эмч суугаа эрдэмтэн, лабораторид туршилага үйлдэгч болох нь олонтай. Харин эмчлэгч эмч болох нь ховор байдаг. Ийм эрдэмтэд слон эмгэгийн үүсгэгч, өвчтэй ба эрүүл эрхтэний үйл ажиллагааны нууцыг нээсэн билээ. Гэхдээ зөвхөн энэ хүрээнд асуудлыг авч үзэж болохгүй нь ойлгомжтой.

Зүрхний тэжээл дутах өвчин үүсгэхэд хөдөлгөөн хомсдох, сэтгэл түгших, хөдөлмөрийн автоматжуулалт, механикжуулалт гол нөлөөлж байгааг хүлээн зөвшөөрөх ёстай. Харин эдгээрийг ямар нэг туршилтаар баталж бас угүйсгэж болохгүй. Нэг хэсэг хумуусийг удаан хугацаагаар ажиглаж зүрхний өвчний үүсэхэд чухам ямар хүчин зүйл нөлөөлж байгааг тогтоодог бөгөөд тархалтыг судлах гэж нэрлэдэг билээ. Ийнхүү эмгэгийн тархалтыг судлах нь суурь судалгаа боловч бас хавсралт судалгааны чанартай юм. Анагаах ухаанд эрэл хайгуул хийхэд ийм судалгааг илүү оргон ацигламаар байна. Энэ нь шинжлэх ухаан практикийн интеграци болно.

Анагаах ухааны хэдэн арван салбар түүнээс хавьгүй олон мэргэжлийн үялдаа холбоог яаж сайжруулах вэ? гэдэг онөөгийн чухал асуудал гарч ирж байна.

Дифференциаци интеграци нь хөгжлийн түүлийг харуулах нэг мөн чанартайн дээр бие биенээ харилцан өөрчилж байдаг.

Анатоми, физиологи, дотор ба мэс заслын ухаан зэргээс мэргэжлийн дифференциаци үүсч бие даасан шинжлэх ухаан салбарласан бөгөөд цаашид шинэ шинэ дифференциаци явагдах болно.

Клиничийн ба параклиничийн мэргэжлийн хоорондох үялдаа холбоог дээшлүүлэх нь интеграцийн үүсэлтэй юм.

Клиничийн удамжлалт хоёр багана болох, мэс заслын зэрэгцээ гурав дахь багана параклиничийн мэргэжил клиничийн мэргэжлийн ажиллах үялдааг сайжруулан түүцийг баяжуулж бас өөрчилж байна. Мэс засалчид одоо гол асуудлыг онош зүйд тулгуурлан шийддэг бэлсөн нь урьдаа түүхээс ялгагдаж байна.

Тэгэхээр клиник-биохимийн нэгдсэн лаборатори, рентген-оношлогооны төв зэргийг зохиси байгуулах нь эдийн засгийн үр дүн-

гээс гадна дээд зэргийн ижил хэмжээний стандарчлалыг явуулах, "Үнэнд" аль бэлох дохеж очиход ач холбогдолтой юм.

Ондоо нэг жишээ дурдвал сэхэн амьдруулах, гемодиализыг нэгтгэж болно. Интеграци хийж болох ондоо олон салбарыг нэрлэж болно. Ингэхэд үйлчлэх хүрээ зохион байгуулалтын ойр тал, материал-техникийн еронхий зүйл, зүйл ажиллагааны нэг чигтэйг харгалзвал зохино.

Аливаа нэг эмгэгийн шалтгааныг нээн тогтоох нь онош зүй, эмчилгээ урьдчилан сэргийлэлтэнд шинэ шинэ арга боломжийг буй болгодог байна. Иймэрхүү маягаар хоёр ба хэд хэдэн мэргэжил дундаас бас нэг мэргэжил үүсч интеграци явагдана. Энд эндокринологи ба иммунологийг хамааруулан авч үзэж белин.

Анагаах ухааны хөгжлийн тодорхой шатуудад түүний аль нэг салбар тэргүүлэгч үүргийг гүйцэтгэж байдаг. Түүний хүрээ ажлын түвшин нь анагаах ухааны онолын сэтгэлгээнд интеграцийн үүрэгтэй байдаг. Саяхан эсийн эмгэг судлалын түвшин эмч нарын онолын сэтгэлгээг тодорхойлж байлаа. Өнөөдөр биохими, генетик зонхилсон молекулын ба эсийн биологийн иж бүрэн интеграци эргэлзээгүй тэргүүлэх болов.

Мэргэжлийн болон эруүлийг хамгаалахын салбарыц бие даах чадварыг тодорхойлох хэмжүүр байж болох уу? Энэ асуудлыг эруүлийг хамгаалахын зохион байгуулалтын үүдиэс авч үзвэл анагаах ухааны хөгжлийн түвшинд тулгуурлан нээн ялангуяа ондөр нарийн мэргэжилтнийг сургаж бэлтгэхэд нийгмийн ач холбогдолтой юм. Энд онолын болон эруүлийг хамгаалахын зохион байгуулалг, эдийн засаг бусад хамарагдах нөхцөлийн хувьд мэргэжлийн цаашдын хөгжлийн төлөвийг бүрдүүлсэн эсэхийг эруүлийг хамгаалахын зохион байгуулагч пар судлан тогтоох ёстой.

Бидний бодлоор бол бие даахын эхний хэмжүүр нь арга зүй байх болов уу.

Тэрхүү арга зүйг дээд зэргээр эзэмших чадвартай мэргэжилтэн шаардлагатай бөгөөд энэ арга зүйг эмч бур тэр болгон эзэмшиж сурхад амаргүй байдаг.

Клиникийн ухаацыг эзэмшсэн хэнд ч гардан хийх зүйл их тул онолын бэлтглийн зэрэгцээ (илүү ч байж бэлэн) олон жилийн турш хуриатлуулсан дадлага туршлага, махруу ажиллагаа чухал болно. Ийм ондөр нарийн мэргэжлийн эмч мэргэжлээ бусад нөхдөөсөө онцгой илүү сайн эзэмшсэн еронхий мэдлэгийн хувьд бат суурьтай баялаг туршлагатай байх ёстой.

Нарийн мэргэжлийн арга зүйн чухлыг аппарат төхөөрөмжийн унэ, түүний ховор наандин гэдгээр үнэлж болохгүй. Эзэмшиж буй аппаратар эзнийг нь үнэлэх гэдэг утгагүй зүйл юм. Гагцхүү шинжлэх ухааны тухайн түвшинг аль хэр тодорхойлж байгаа ур нөлоөгөөр нь үнэлэх ёстой.

Бие даах чадварын хоёр дугаар үзүүлэлт нь түүний эзлэх хувийн жин болно. Хэтендөр дифференциаци явагдахад онолын хувьд сонирхолтой атлаа түүний практик огөөж нэн тодорхойгүй бол нэг хэсэгтээ хүлээх шаардлагатай болдог.

Гуравдугаар хэмжүүр нь үйлчлэх хүрээ юм. Нэн ялангуяа анагаах ухаан, эруүлийг хамгаалахын салбаруудыг хооронд нь холбоц ажиллах бүрэн боломжтой байх ёстой.

Дээрх шинж чанарыг хадгалж чадсан, тодорхой арга зүй, түүнийг өргөн хүрээтэй ашиглах боломжгой. ангаах ухааны хэд хэдэн салбарт сонирхогдож байвал түүний эх үүсвэр болох шинжлэх ухааныхаа ашиг сонирхолд таарах таарахгүйгээс шалтгаалахгүйгээр оорийн чиглэлдээр бие даан хөгжиж чадна.

Анагаах ухааны дифференциаци бараг аяидаа явагдсан бол интеграциал аяндаа явагдахгүй, харин ихээхэн хүч зарцуулах шаардлагатай. Эмнэлгийн олон төрөл мэргэжлийг үр дүнгэй нэгтгэж чадах гол баганыг олох хэрэгтэй байна.

Социалист эруүлийг хамгаалахын үндсэн зарчим нь урьдчилан сэргийлэх, овчтонд байнгын системтэй тусламж үзүүлэх-диспансерчлал юм. Диспансерчлал нь өвчинийг аль болох эрт илрүүлэх (тэгвэл эмчлэхэд хялбар) овчтонийг байнга анхааран халамжлах, сувилах (хаана ч байсан ялгаагүй) өвчтонийг хөдөлмөрийн чадвар, тэнхээ тамирыг сэлбэн засч. өвчин дахиаас сэргийлэх эдгээр гурван зорилтыг агуулдаг билээ. Нэн ялангуяа архаг өвчинүүдийн хувьд бур чухал байна.

Эмчилгээний арга дээр үндэслэн салбарласан олон мэргэжлийн эмч нарын ажлын уялдаа, зохион байгуулалтыг сайжруулан үүргийг нь ухамсарлуулж чадвал диспансерчлалыг оөд татаж болно.

Анагаах ухааны интеграцилах ганц чиглэлээр бус наад зах нь хоёр чиглэлээр явагдах боломжтой. Нэгдэх чиглэлд үндсэн өвчинээр мэргшүүлэх, хун өвчилж эхлэхээс эхлэн шаардлагатай бол бүхий л амьдралын турши эмчлэх туслах мэргэжлийн тусламжаар нь интеграцилахыг оруулж байна.

Нөгөө нэг чиглэл нь хүүхдийн эмч хүүхдийг эруүл чийрэг, бур насанд хүрэх хүртэл нь эруүл байхыг хариуцаж, мэс засалч амь насанд тулгарсан аюулыг мэсээр зайлзуулж, сувиллын эмч хөдөлмөрийн чадварыг сэргээж байн.

Ийм системийн хувьд өвчин эсвэл түүнийг үүсгэх шалтгаанаар мөн эмчилгээний аргыг хоссон мэргэжүүлэх шаардлага гарч байна. Ийнхүү хүүхдийн кардиолог, дотрын кардиолог, кардиолог-мэс засалч, кардиолог-сэхээн амьдрнуулагч гэсэн мэргэжлийн хослол бий болоод байна.

Дээрх дифференциаци эмнэлгийн тусламжийг холбоо уялдаагүй, тусгаар хэсгүүд болгох ёсгүй бөгөөд өвчтон (эруүл хүн ч нэгадил) дотрын байнгын анхааралд байж тусламж авч байх ёстой. Сурьеэ, хавдар судлал, мэргэжлийн өвчиний диспансеруудыг жишээ татаж болно.

Нөгөө талаар ондөр мэргэжлийн датлага туршилагатай заах арга сайтай багш, эрдэмтдийг ийм интеграцилалыг эзэмшилэн төлөөлөгч гэж хэлж болно.

Мэргэжлийн хувьд зүрхний тэжээл дутах өвчинийг эмчлэж буй дотрын эмч, сэхээн амьдрнуулагч, кардиолог, мэс засалч, сувиллын эмч бас л интеграцилалд байна.

Сүүлийн жилүүдэд эмнэлгийн томоохон барилга байгууламж баригдаж хүчин чадал нь нэмэгдэн, оношлогоо, эмчилгээний шинэ техник нэвтэрч эмч нар гар гараасаа барилцан ажиллаж байна. Гэвч зөвхөн үүгээр интеграцилалыг хангана гэх үндэсгүй юм.

Хүн амын эруүл мэндийг байнга сахин хамгаалагч тэдэнд хамгийн ойр дот, урьдчилан сэргийлэх, эмчлэх ажлыг гардан хариуцагч хэсгийн эмч нар (хэсгийн эмнэлгийг) оцгой аяхаарч тэнд ажиллаж байгаа эмч нарын мэргэжлийг дээшлүүлэх, эмнэлгүүдийг төвлөрүүлэх, материаллаг баазыг бэхжүүлэх явдал чухал болжээ.

Чухам хэсгийн эмнэлэг олон мэргэжлийн больниц жишээ нь район, аймгийн нэгдсэн эмнэлэг, сум дунд, сумын эмнэлэг интеграцилалын гол багана болох ёстой.

Мэргэжлийн хувьд анагаах ухааны „аав“, „ээж“ болсон мэс засал, дотрын эмч нарын ажлын уялдааг бүр нягт болгох нь зүйн хэрэг юм. Сүүлийн уед эдгээр зонхилох мэргэжлийн аль нэг аргыг эзэмшигчдийн тоо олширч оргөн хүрээнд мэдлэг, туршилагатай дотор, мэс заслын эмч цоөрч байх шиг санагдана. Мэргэжлийн

дээшлүүлэх кардиорлогийн курс суугаад "кардиолог" нефрологийн курс суугаад "нефролог" болчихсон эмч наартай цөөнгүй тааралдах болов. Энэ л эмч нараас өвчтөнийг бие бие руулгээ түлхэх шалтаг их гардаг юм. Ер нь эмч бол эмч байх ёстой. Эхлээд эмчийн зайлшгүй мэдэх, хийх ёстой зүйлийг эзэмшиж, цаашид нарийн мэргэжил олж, улмаар аль нэг ондөр нарийн мэргэжлийт гаргууд эзэмшивэл сайнсан. Дээд сургууль төгсөөд эмчийн ажлын амтыг амсалгүй "нарийн мэргэжлийн" "зовлех" болчихсон хүн ч манайд цөөнгүй бий. Хэсгийн эмч өвчтөнг ямар мэргэжлийн эмчид явуулах, ер нь шаардлагатай эсэхийг шийдэх чадвартай байх ёстой. Өвчтөнг юм л бол түүнд үзүүл, тэнд оч гэж биеэсээ холтгож дадлага дутахаас илүү энгийн ёс суртахуун, үүрэг хариуцлагаа бодлогүйгээс болж байна.

Хэсгийн эмнэлгүүд зовлөх поликлиник, районууд (аймаг, сум дунд)-ын эмнэлгийн мэргэжил ажлын холбоог сайжруулах, диспансерчлалыг чанаржуулах, түүний арга барилыг эмч бүрт эзэмшилүүлэх ажил хангалтгүй байна. Энд сургалтын арга барилын дутмаж тал ч нөлөөлж байна. Оюутны дадлагыг поликлиникт маш бага хийлгэдэг. ихэнх цагийг стационарын (онош, эмчилгээ нэгэнт тодорхой) өвчтөнг үзүүлэх, мэс заслын явцыг харуулж онгороодгөөс урьдчилан сэргийлэх ажил, өвчинийг амбулаториор оношлож, эмчлэх арга барилаас хөндийруулж байна.

Анагаах ухааны интеграцчилалын нэг баатана нуруу нь эмч бүр өвчтөний тухай мэдэх ёстой зүйлийг мэдэж байхад оршиж байна. Аль мэргэжлийн ч бай урьд үзсэн эмч нарын тавьсан онош, эмчилгээнд үнэлэлт огч, оорийн дүгнэлтийг хийж чаддаг, өвчтөнийг шинжлэх, эмчлэх, тактикийн арга барилыг эзэмшиж байх нь чухал байна.

Ирээдүйн анагаах ухааны гол чиглэл нь интеграцчилал болно. Одоогийн байдаар эмч нар хоорондоо хэл яриагаа төдийлөн ойлголцож чадахгүй байна.

Мэргэжлийн тоо ёсч нарийн мэргэжлийн эмнэлгүүд салангий байдалтай байна. Одоогийн нөхцөлд эмнэлгүүдийг аль болохоор төвлөрүүлэн томсгох байдлаар зохион байгуулж харин ийм эмнэлгийн дотор нарийн мэргэжлийн тасгуудыг нээн ажиллуулах нь илүү ашигтай мэт санагдана.

Интеграцчилал нь зөвхөн анагаах ухаан, эрүүлийг хамгаалахын хүрээнд хийгдэх асуудал бас бишээ. Түүний гадна ч нэг адил хийгдэх шаардлагатай. Энэ нь нарийн багаж төхөөрөмж, холбооны хэрэгсэл, мэдээлэл түүнийг боловсруулан ашиглах, материал хангамжийн төвлөрөлтөнд хамарагдана.

Ө. ОМБОРГАВАА, Л. РОЛЗОДМАА

Э руулгийг хамгаалах яам

УЛААНБААТАР ХОТЫН ЗАРИМ ЭМНЭЛЭГТ ҮЗҮҮЛЭХЭЭР ИРЭГЧДИЙН НЭГ ӨДРИЙН СУДАЛГААНЫ ДҮН

Улаанбаатар хотын 9 поликлиникт үзүүлэхээр ирэгчдэд нэг өдрийн судалгаа хийв.

Судалгааг амбулатори-поликлиникийн үзлэгийн цагийг зохицуулан үзлэгийн эмч нарын ажлын цагийн ачааллыг жигдүүлж,

хөдөлмөрчдийн хүлээгдлийг багасган амбулатори-поликлиникийн ажиллагааг боловсронгуй болгох ажлыг зохион байгуулах үндэсмэл гаргах зорилгоор хийлээ.

Судалгааг 1985 оны 3 дугаар сарын 25-нд (үзүүлэгчдийн тоо бусад өдрийнхөөс хамгийн их байдаг, даваа гаригт) үзлэгийн бүтэн одор нэгэн зэрэг хийв.

Судалгаанд 3381 хүн хамрагдаж, үзүүлэхээр ирэгчдийг тусгай бэлтгэсэн талонд бүртгэн түүнийг статистик аргаар боловсруулав.

Хүснэгт 1

Эмнэлэгт үзүүлэхээр ирэгчид (Дунд харьцуулсан хувь)

Цаг	Насанд хүрэгчдийн эмнэлгийн нэр					Хүүхдийн эмнэлгийн нэр				
	ҮКТЭ ТЭ	УБХК НрНэ	ОрНэ	АрНэ	Бүгд	АрХэ	ОрХЭ	НрХЭ	СрХЭ	Бүгд
8—9	65,2	43,3	27,5	41,8	43,0	48,6	51,1	31,9	36,8	35,5
10—11	22,2	25,7	27,9	28,1	20,5	24,6	38,3	37,5	23,3	32,8
12—13	10,5	13,8	16,2	8,0	14,7	12,0	8,5	21,3	29,5	14,4
14—15	2,1	15,0	19,8	17,8	18,6	12,2	2,1	9,3	10,4	15,1
16 ба дээш	—	2,2	8,6	4,3	3,0	2,6	—	—	2,2	0,9
Дун	100,0	100,0	100,0	100,0	100,0	100,0	100,0	100,0	100,0	100,0

Тайлбар:

ҮКТЭ — Улсын клиникийн төв эмнэлэг

УБХКТЭ — Улаанбаатар хотын клиникийн төв эмнэлэг

НрНэ — Найрамдлын районы нэгдсэн эмнэлэг

ОрНэ — Октябрыйн районы нэгдсэн эмнэлэг

АрНэ — Ажилчны районы нэгдсэн эмнэлэг

АрХЭ, ОрХЭ, НрХЭ, СрХЭ — Ажилчин, Октябрь, Найрамдал, Сүхбаатарын районы хүүхдийн эмнэлгүүд.

Хүснэгт 1-ээс үзэхэд судалгаа хийсэн эмнэлгүүдэд өглөөний 8—11 цагийн хооронд нийт үзүүлэгчдийн 60,1—89,4 хувь нь ирж байгаа нь үйлчилгээг хүндруулж, үзлэг хийж буй эмч нарын тухайн цагийн ачааллыг ихэсгэж, хөдөлмөрчдид цаг хугацаа алдаж байна.

Энэ одор Улсын клиникийн төв эмнэлгийн стоматологийн 2 дугаар ээлжийн эмчид үзүүлэхээр ирсэн 70 хүний 58 /82,9 / нь өглөө 7—11 цагт ирж номер авч карт олуулжээ.

Гэтэл 2 дугаар ээлж нь 13 цагаас 20 цаг хүртэл ажиллах ёсстой байв. Тэдгээрээс 7 цагт ирсэн 4 хүн гус бүр 6 цаг, 8 цагт ирсэн 16 хүн тус бүр 5-аас дээш цаг, 9 цагт ирсэн 21 хүн 4-өөс дээш цаг тус тус хүлээсэн буюу нийтдээ 41 хүн 188 цаг хүлээснийг эдийн засгийн хувьд авч үзвэл хичнээн их зүйл бүтээх цаг хугацаа алдаж байгаа нь тодорхой юм.

Улсын клиникийн төв эмнэлэгт энэ өглөө үзлэг хийх бүх эмч нар цагт 140 хүн үзэх байв. Гэтэл өглөөний 8 цагт 334 хүн, 9 цагт 212 хүн үзүүлэхээр ирсэн байв.

Энэхүү 7—9 цагт ирсэн 546 хүнээс 266 нь 2—3 цаг хүлээж үзүүлсэн байна,

Улаанбаатар хотын клиникийн төв эмнэлгийн поликлиникт энэ өглөө нийтдээ цагт 103 хүн үзэх ёстой байв.

Гэтэл өглөөний 7,8 цагт 153 хүц, 9 цагт 154 хүн, 10 цагт 104 хүн тус тус үзүүлэхээр иржээ. Тэдгээрээс 100 гаруй хүн 2—3 цаг

хүлээсэн байна. Харин өдрийн 12 цагаас хойш үзүүлэхээр ирэгчдийн тоо эмнэлэг бүрт эрс буурч нийт үзүүлэгчдийн дөнгөж 12,6—36,3 хувийг эзэлсэн байна.

Хүснэгт 2

Ээлжээр ажилладаг мэргэжлийн эмч нарын үзлэгийн цагийн ачаалал

Эмнэлгийн нэр нарийн мэргэжил	Эзэж	Үзлэг хий- сэн цаг		Эмчийн тоо	Үзүүлэхээр ирсэн хүний тоо	Үзлэгийн цагийн дундаж ачаалал
		Эхэлсэн	Дууссан			
1	2	3	4	5	6	7
ҮКТЭ шуд	I	8	15	5	67	2,4
УВХКТЭ шуд	II	13	20	2	70	6,4
НРНЭ Дотор	I	8	15	5	135	4,9
	II	12	19	1	40	7,3
	I	8	16	3	98	5,0
	II	12	20	1	3	0,5
	I	8	16	1	26	4,7
	II	12	19	1	13	2,4
	I	8	16	1	29	4,5
ОРНЭ Дотор	II	12	20	1	2	0,3
	I	8	17	7	108	2,4
	II	12	20	1	30	4,6
	I	8	15	2	57	5,2
АРНЭ Дотор	II	14	21	1	24	4,4
	I	8	16	4	92	3,5
	II	8	15	2	70	6,4
	I	12	20	1	2	0,3
	II	—	—	—	—	—

Хүснэгт 2-оос үзэхэд шудний эмчийн ачаалал ихэнх эмнэлгүүдэд харьцангуй өндөр, хоёр дугаар аэлжинд ирж үзүүлэгчдийн тоо их байгаа нь энэ-ээлжийг сайн зохион байгуулах шаардлагатайг харуулж байна.

Судалгаанаас үзэхэд эмнэлгүүдэд эмчийн ачаалал жигд биш байна. Насанд хүрэгчдийн эмнэлгүүдэд мэдрэлийн эмчийн ачаалал бараг хэвийн хэмжээнд байхад мэс засал, шудний эмчийн ачаалал ихэнх эмнэлэгт их байлаа. Харин чих, хамар хоолой нудний эмчийн ачаалал бага, ялангуяа харшил, хавдар судлал, эмэгтэйчүүд зэрэг нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгийн цагийн дундаж ачаалал энэ өдөр 1,2—3,0 байв. Насанд хүрэгчдийн эмнэлэгт дотор, шудний эмчид хамгийн олон хүн үзүүлэхээр иржээ. Үзүүлэхээр ирсэн хүмүүсийн 37,3—65,6 хувь нь энэ хоёр мэргэжлийн эмчид үзүүлсэн байна.

Хүүхдийн эмнэлгүүдэд дотор, чих хамар хоолой, шудний эмчид хамгийн олон хүүхэд үзүүлэхээр иржээ. Үндд бүх үзүүлэгчдийн 60,6—83,9 хувь болж байна.

Эмнэлэгт үзүүлэхээр ирэгчдийн ихэнх хувийг эмэгтэйчүүд, ажилчин, албан хаагчид эзэлж байна.

Насанд хүрэгчдийн 5 поликлиникт үзүүлэхээр ирэгчдийн дотор 1051 ажилчид байсан нь хотын иргэдээс энэ өдөр үзүүлэгчдийн 48,7%-ийг эзэлж байна.

Насанд хүрэгчдийн 5 поликлиникт үзүүлэхээр ирэгчдийн 63,6—71,7 нь эмэгтэйчүүд, хотын иргэдийн 48,7% нь ажилчид байсан нь анхаарал татаж байна.

ДҮГНЭЛТ:

1. Хотын эмнэлгүүдэд үзүүлэхээр ирэгчдийг зохион байгуулж хэсэг, амбулатори, поликлиникийн эмч нарын үзлэгийн цагийн ачааллыг жигдруулэх талаар одоогоор тодорхой ажил хийгдээгүй байна. Иймээс оглөөний ээлжинд ажиллаж байгаа эмч нар хэт их ачлаадтай, 2 дугаар ээлжиннд буюу 12 цагаас хойш ажиллаж байгаа эмчид бараг үзүүлэх хүнгүй болж байна.

2. Эмнэлэгт үзүүлэхээр оглөө өрт иргийн гол шалтгаан нь үзүүлж чадахгүй буцахаас болгоомжилдогтой холбоотой байна.

3. Судалгааны дүng үндэслэж, хотын эмнэлгүүдэд үзүүлэхээр ирэгчдийг зохион байгуулж, эмнэлгүүдийн үзлэгийн цагийн ачааллыг жигдруулэн, эмнэлэгт үйлчлүүлэхээр хүлээж цаг хугацаа алддагийг аль болохоор багасгах арга хэмжээг зохион байгуулах нь чухал байна.

Редакцид ирсэн 1985—06—11.

Д. НАМЖИЛ (Монгол улсын их сургууль)

ЭМНЭЛГИЙН БАЙГУУЛЛАГЫН ОРНЫ АШИГЛАЛТАНД ХИЙСЭН СУДАЛГАА

Үйлдвэрлэлийн бус хүрээний санхүүжилтэнд Эрүүлийг хамгаалах салбар онцгой байр эзэлж нийгэм соёлын арга хэмжээнд зориулсан төсвийн хөрөнгийн 22,0 хувийг ашиглах байна. Эмнэлгийн байгууллагын ажлын чанарын үзүүлэлтийг дээшлүүлэх, до тоод нөөц бололцоог олж илрүүлэх, санхүүгийн нөөцийг үр дүнтэй ашиглахад энэ салбарын зорилт чиглэх ёстой.

Эрүүлийг хамгаалах байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд судалгаа хийх, ажлын үр дүng тодорхойлоход орны ашиглалтыг судлах нь чухал юм.

Орны ашиглалтанд судалгаа хийхэд юуны өмнө ор хоногийн толовлөгөөний биелэлтээс эхлэх шаардлагатай байна.

Хүснэгт 1

Нэгдсэн эмнэлгийн төлөвлөгөөт Үзүүлэлтэнд хийх судалгаа

№		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	т/г-ийн зоруу
1.	Нийт санхүүжилт (1000 төг)	5680,0	5910,0	+230,0
2.	Эмнэлгийн дундаж орны тоо	260	286	+26
3.	Нэг оронд ногдох дундаж зардал	21,8	20,6	-1,2
4.	Орны ашиглагдах хугацаа (хоногоор)	330	340,8	+10,8
5.	Орны эргэлтийн тоо		18,9	—
6.	Нэг өвчтөний эзлэх дундаж ор хоног		18,0	—
7.	Ор хоног	86800	99464	+12664

Эмнэлгийн ор хоногийн төловлөгөөний биелэлтийг орны эргэлтийн тоо, нэг оронд хэвтэж эмчлүүлэх хугацаа зэрэг узүүлэлтийг нягт уялдаатай судлана.

Орны эргэлтийн тоог дараах томъёогоор тооцно

$$\mathcal{E} = \frac{T}{K}$$

T — орны ашиглагдах хугацаа (хоногоор)
K — өвчтоний хэвтэж эмчлүүлэх хугацаа /хоногоор
Э — орны эргэлт

Өвчтоний хэвтэж эмчлүүлэх хугацааг гүйцэтгэлээр дараах байдлаар тодорхойлно.

$$K = \frac{O}{P}$$

$$O — \text{ор хоног /гүйцэтгэлээр/}$$

P — өвчтоний тоо /тайлангаар/

Дээрх томъёонос орны эргэлтийн тоо нь орны ашиглагдах хугацаатай шууд, хэвтэж эмчлүүлэх хугацаатай урвуу хамааралтай байна. Эмнэлгийн практикт үйлчилгээ, эмчилгээний онцлоогоос шалтгаалж зарим тасгуудын орны ашиглалт нормативаас 30—40 хоногоор хэтэрч, орны ачааллыг нэмэгдүүлж байна.

Төловлөгөөт хугацаанд орны ашиглалтыг жигд байлгахын тулд тасгуудын хооронд орны ходолгөөн хийх замаар зохицуулалт хийж болох юм.

Өвчтоний нэг ор өзлэх хоногийн тоог цөөрүүлэхэд орны ашиглагдах хугацаа тогтмол байгаа нөхцөлд орны эргэлтийн тоо тургасэх сайн талтай боловч энэ нь тасаг бурийн онцлог, эмчилгээний үр дүнгээс шууд хамаарч байх ёстой.

Нэгөө талаар хэвтэж эмчлүүлэх хугацааг хэт нэмэгдүүлэх нь орны эргэлтийг багасгаж эмнэлгийн хэмжээгээр хэвтэж эмчлүүлэгчдийн тоосг буруулах хандлагатай байдгийг анхаарах хэрэгтэй.

Эмнэлгийн хэмжээгээр (хүснэгт I) ор хоногийн төловлөгөөн 12664 ор хоногоор давж биелсэн байна. Ор хоногийн төловлөгөөний биелэлтэнд орны тооны өөрчлөлт, орны ашиглагдах хугацаа нулоолсон байна. Нолоөлөл тус бурийг авч үзвэл:

1. Орны тоо өөрчлөгдсөнөөс

$$26(260—286) \times 330 = 8580,$$

2. Орны ашиглалтын хугацааны өөрчлөлтөөс.

$$10,8(330—340,8) \times 286 = 3084 \text{ болно.}$$

Ор хоногийн төловлөгөөний биелэлтэнд шинжилгээ хийхэд тасаг бурийн төловлөгөөний биелэлтийг судлан орны эргэлт, хэвтэж эмчлүүлэгчдийн тоог нэмэгдүүлэх боломжийг тодорхойлох шаардлагатай.

Хүснэгт 2-оос үзэхэд II, V тасгуудаас бусад нь ор хоногийн төлөвлөгөөг давуулсан биелүүлсэн байна. Энэ нь хоёр тасагт орны ашиглагдах хугацаа төловлөгөөт хэмжээнд хүрээгүй байгааг харуулж байна.

Өөрөөр хэлбэл орны ашиглагдах хугацааг нормативт хэмжээнд хүргэхээр орны ачааллыг зохицуулж тасгуудын орыг шилжүүлэн ашиглах боломжтой байна.

Хэрэв II, V тасгуудын орыг төловлөгөөт хугацаагаар нь (нормативаар нь) ашигласан бол 1260(42×30) 460 (46×10) нийтдээ 1720 ор хоног нэмж ашиглах боломж байв. Өөрөөр хэлбэл нэг өвчтон дунджаар 17 ор хоног эзэлсэн гэж үзвэл нэмж 100-аад овтөнг хэвтүүлэн эмчлэх боломж байжээ.

Эмнэлгийн байгууллагад ор хоногийн төловлөгөөг тасаг бүрээр биелүүлэх, түүнд хяналт тавих замаар нэг өвчтоний эзлэх ор хоногийг багасгаж орны эргэлтийг нэмэгдүүлж болох юм.

Хүснэгт 2

Нэгдсэн эмнэлгийн тасгуудын ор хоногийн
төлөвлөгөөний биелэлтийн судалгаа

Эмнэлгийн тасгууд	Орны тоо	Орны ашиг- лагдах ху- гацаа		Ор хоног		Хэвтэж эмчлүү- лэгчдийн тоо	Хэвтэж эмч- лүүлсэн хугацаа	Орны эргэлт
		төлөв.	гүйц.	төлөв.	гүйц.			
I тасаг	48	330	365	15840	17520	921	19	19
II тасаг	42	330	300	13860	12600	735	17	17
III тасаг	50	330	370	16500	18500	1010	18	20
IV тасаг	52	330	335	17160	17420	1040	16	20
V тасаг	46	330	320	15180	14720	798	18	17
VI тасаг	48	330	348	15840	16704	910	18	18
Тасгуудын дун	286	330	340,8	94380	97464	5414	18	18

Хүснэгт 3

Нэгдсэн эмнэлгийн орны ашиглалтанд хийх судалгаа

№	Үзүүлэлт	Гүйцэтгэл	тооцоогоор	зөрүү
1. Ор хоног		97464	97464	=
2. Орны ашиглалтын хугацаа		340,8	340,8	=
3. Нэг оронд хэвтэж эмчлүүлсэн хугацаа (хоногоор)		18	16	-2
4. Хэвтэж эмчлүүлэгчдийн тоо		5414	6091	+677
5. Орны эргэлт		18,9	21,3	+2,4

Хэрэв эмнэлгийн хэмжээгээр эмнэлэг үйлчилгээний үр дүнг дээшлүүлэн, нэг оронд хэвтэж эмчлүүлэх хугацааг зөвхөн 2 хоногоор багасгахад орны тоо, ашиглалтад хугацааг нэмэгдүүлэх түйгээр 677 өвчтөнг хэвтүүлж эмчлэж болох байна. Харин хэвтэж эмчлүүлэх хугацааг багасгахад тасаг бүрийн эмнэлэг үйлчилгээний онцлогийг нарийн харгалзан ялгавартай хандах нь зүйтэй.

Эмнэлгийн байгууллагууд дээр дотоод ноөц бололцоог олж илрүүлэн эмнэлгийн үйлчилгээний үр дүнг дээшлүүлэх, орны эргэлтийг түргэтгэх, эмнэлэгт хэвтэж эмчлүүлэгчдийн тоог нэмэгдүүлэх боломжийг судлаж практикт хэрэгжүүлэх нь эмнэлгийн ажилтан бүрийн эдийн застийн мэдлэтийг дээшлүүлэхтэй холбоотой.

Эмнэлгийн байгууллагын орны ашиглалтанд нөлөөлсөн хүчин зүйлсийг судалж, дотоод ноөц бололцоог бүрэн дайчлахад эрүүлийг хамгалах байгууллагын ажилтан бүрийн хүч анхаарлыг төвлөрүүлэх хэрэгтай байна.

Редакцид ирсэн 1985—04—05.

СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ

Г. ЗУУНАЙ, Р. БЯМБА (Төмөр замын эмнэлгийн алба)
(Говь-Алтай аймгийн эрүүлийг хамгаалах газар)

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ХҮН АМЫН ӨСӨЛТИЙН ЗАРИМ АСУУДАЛ

Эрүүлийг хамгаалахын удирдлага төловлөлтийг боловсронгуй болгож хүн амд үзүүлэх эмнэлгийн тусlamжийн хэтийн төлөвийг тогтооход хүн ам зүйн судалгаа чухал ач холбогдолтой билээ. Ялангуяа тодорхой аймаг хотын хүн амын төрөлт, нас баралт, гэрлэлт зэрэг нөхөн үржилтийн үзэгдэл, түүнд нөлөөлж байгаа бодит хүчин зүйлс, тухайн орчны байгаль газар зүй, орон нутгийн онцлогийг тусгасан судалгааны материал нь эрүүлийг хамгаалахын өмнө тавигдаж байгаа асуудалд зөв шуурхай хариу өгөх, зангилаа гол асуудлыг тодруулахад шийдвэрлэх үүрэгтэй юм.

Иймээс бид Говь-Алтай аймгийн төрөх насны эмэгтэйчүүдийн 9 жилийн материалд (1976—1984 он) статистикийн боловсруулалт хийж хүн амын нөхөн үржилтийн байдалд зарим гүнзгийрүүлсэн судалгаа явуулах зорилт тавьсан юм.

Говь-Алтай бол манай орны баруун хязгаарын говь, хээрийн бүс хосолсон 142,5 мянган хавтгай дөрвөлжин талбай бүхий нутагтай, 48 мянган хүн амтай, мал аж ахуй, газар тариалан зонхилон эрхэлдэг аймаг юм.

Нутаг дэвсгэр нь газар зүйн хэвтээ чиглэлээр говь хангай хосолсон төдийгүй, Хан тайшир, Хар азарга, Аж богд, Бурхан Нуудай зэрэг далайн түвшнээс дээш 3000—4000 м ондорт өргөгдсөн уул нуруудын завсар хөндийгөөр алдарт Шарга, Бигэр, Но мин, Алаг нуурын говиуд салаавчлан оршдогоос нэгэн хэсэгжэн газрын хувьд хүртэл байгаль газар зүйн хэд хэдэн бүсийг босоо чиглэлээр (вертикаль) үүсгэдэг өвөрмөц нөхцөлтэй юм.

Аймгийн төв Алтай хот Хэнтайширын нурууны бэлд далайн түвшнээс дээш 2160 м ондорт оршдгоороо тус улсын хамгийн ондорт байдаг хотын тооцд орно. Алтай хотод аймгийн хүн амын 21,7% нь оршин суудаг. Тус аймгийн нутагт хүн ам сийрэг суудаг. Тухайлбал нэг хавтгай дөрвөлжин км нутагт 0,41 хүн ногдох байгаа нь улсын дунджаас бараг З дахин цөон байгаа хэрэг. Хүн амын 51,3% нь эмэгтэйчүүд буюу аймгийн нийт хүн амын 24,2% нь төрөх насны (15—49 нас) эмэгтэйчүүд байгаа нь хүн амын нөхөн үржилтэнд шүүд нөлөөлөх хүчин зүйл юм.

Говь-Алтай аймгийн 18 суманд эхчүүдийн төрөхийн өмнөх амрах байрыг нэгдсэн зураг төслөөр барьсан нь хөдоөгийн малчин эхчүүдийг төхьтэй амарч, амаржих бодит бололцоогоор хангаж байгаа зохицой арга хэмжээ болжээ.

Тус аймагт аймгийн нэгдсэн эмнэлгээс гадна Баян-Уул, Төгрөг, Бигэрийн сум дундын эмнэлэгт эх барих, эмэгтэйчүүдийн их эмч, бусад сум, зарим бригадад х баригч бага эмч ажилладаг.

Ийнхүү Говь-Алтай аймаг газар нутаг, байгаль цаг уурын нохдол, эх барих эмэгтэйчүүдийн тусламжийн зохион байгуулалт, хангамж, хүрэлцээний хувьд бусад аймат орон нутгийг төлоөлүүлж болох нийтлэг нэлээд шинж чанартай юм.

Бид аймгийн хүн амын зүйн сүүлийн 10 жилийн (1975—1984 он) материалд судалгаа хийж үзэхэд аймгийн хүн ам сүүлийн 10 жилд 17,5% осч 16 хүртэлх настай хүүхэд хүн амын бараг 50%-ийг эзлэх болжээ. 1984 оны байдлаар тус аймгийн 1000 хүн амд жилдээ 37,4 төрөлт ногдох 27,6 промиллийн цэвэр осолттэй байгаа нь улсын дунджаас дээгүүр байгаа үзүүлэлт юм. Аймгийн нийт жирэмсэн эхчүүдийн 30,5%, үүнээс анхны төрөлтийн 24% нь Алтай хотод төрж байна. Эпэ нь ч зүйн хэрэг. 1981 онд тус аймагт төрсон нийт эхчүүдийн 19,9% нь анхны төрөлт, 15,7% нь 2 дахь төрөлт, 12,5% нь 3 дахь, 10,8% нь 4 дэх төрөлт болж төрөлтийн дугаар ихсэхийн хэрээр төрөлтийн хувийн жин багассан байна.

Хүснэгт 1

Аймгийн төв ба сумдад төрсон эхчүүдийн төрөлтийн дугаарын нийт төрөлтөнд эзлэх хувийн жин (1981 он)

	Төрөлтийн дугаар															Бүгд	
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	XIII	XIV	XV	XVI	
Аймгийн төвд	24,0	17,6	13,1	12,0	7,5	7,3	4,9	4,7	2,9	2,0	1,8	1,2	0,8	0,2	0,2	100,0	
Сумдад	17,6	14,8	12,3	10,2	9,3	8,1	7,0	7,1	4,3	3,0	2,8	2,1	0,7	0,3	0,1	0,1	100,0
Бүгд	19,9	15,7	12,5	10,8	8,7	7,8	6,4	6,6	3,9	2,7	2,5	1,8	0,7	0,2	0,1	0,05	100,0

Харин 5-аас хойших төрөлтийн хувийн жин сумдад харьцаагүй их байна.

Хүн амын нохон үргжилтэнд төрөх насны эмэгтэйчүүдийн насын бүлэг чухал ач холбогдолтой байдаг (3).

Хүснэгт 2

Говь-Алтай аймгийн төрөх насны эмэгтэйчүүдийн төрөх чадварын хөдлөл зүй (1000 эмэгтэйд)
(1976—1984 он)

Он	Төрөх насны эмэгтэйчүүдийн насны бүлэг							Бүгд
	15—19	20—24	25—29	30—34	35—39	40—44	45—49	
1976	45,7	247,3	379,5	330,0	325,2	175,8	61,6	223,6
1977	46,7	242,5	399,8	337,4	317,9	176,8	52,9	224,86
1978	29,9	238,7	384,9	319,6	271,2	179,5	41,2	209,3
1979	37,3	236,3	380,9	273,8	258,3	140,7	52,9	197,17
1980	37,9	242,7	384,2	280,4	265,7	143,2	52,4	200,9
1981	39,7	254,1	401,6	292,4	277,0	149,7	55,0	209,9
1982	41,3	280,4	317,5	163,6	104,3	73,5	16,5	142,4
1983	34,6	301,9	332,5	152,3	99,0	65,2	13,3	142,7
1984	30,7	297,1	324,4	145,9	99,0	64,2	16,9	139,7
Дүн	38,2	260,1	367,2	255,0	224,1	129,8	40,3	187,8

Хүснэгт 2-оос үзэхэд эмэгтэйчүүдийн төрөх чадвар 15—19 насанд хамгийн бага (38,2) промилл, 25—29 насанд хамгийн их (367,2) промилл байгаад цаашдаа аажим буурч, 45—49 насанд эрс буурч 40,3 промилл болж байна.

Дэд эрдэмтэн Р. Гурийн судалгаагаар Говь-Алтай аймагт эмэгтэйчүүдийн төрөх чадвар 1955—1956 онд 23,8 промилл, 1962—63 онд 41 промилл байсан боловч бидний судалгаагаар 1976—1980 оны хооронд 223,6—139,7 промилл болтол өссөн байна. Энэ нь 1970-аад оны үед эмэгтэйчүүдийн төрөх чадвар маш ондор болоод цаашдаа аажим буурч тогтвортой байдалд орж байнгийн гэрч юм. Харин эмэгтэйчүүдийн төрөх чадвар нь 20—24 насанд нэмэгдэж байгааг хүснэгтээс ажиглаж болно.

Хүн амын нөхөн үргжилтийн чадварт эмэгтэйчүүдийн горх чадварын нийлбэр үзүүлэлт (суммарный показатель плодовитости) онцгой ач холбогдолтой. Эмэгтэйчүүдийн төрөх чадварын нийлбэр үзүүлэлт бол нэг эмэгтэй амьдралынхаа туршид хэдэн хүүхэд төрүүлж байгааг 1000 эмэгтэйд гаргасан дундаж үзүүлэлт юм.

Хүснэгт 3
Эмэгтэйчүүдийн төрөх чадварын нийлбэр Үзүүлэлт (1976—1984 он)

Насны бүлэг	1000 эмэгтэйн төрөх чадвар	
	жилийн үзүүлэлт	нийлбэр үзүүлэлт
15—19	38,2	191,0
20—24	260,1	1300,5
25—29	367,2	1836,0
30—34	255,0	1275,0
35—39	224,1	1120,5
40—44	129,8	649,0
45—49	40,3	201,5
Дундаж үзүүлэлт	187,8	6573,5

Хүснэгт 3-аас үзэхэд Говь-Алтай аймагт амьдарч байгаа 1000 эмэгтэй амьдралынхаа туршид 6573 хүүхэд төрүүлэх буюу нэг эх дунджаар 6—7 хүүхэд төрүүлж байгаа нь тодорхой байна.Өөрөөр хэлбэл бидний судалгаагаар эмэгтэйчүүдийн төрөх чадварын нийлбэр үзүүлэлт 6,6 байгаа нь харьцангуй өндөр үзүүлэлт юм.

Р. Гурийн судалгаагаар (1967) тус улсын эмэгтэйчүүдийн төрөх чадварын нийлбэр үзүүлэлт 1955—1956 оны үед 4,6 промилл байснаа 1962—1963 онд 7,0 промилл болж өссөн байна.

Хүн амын нөхөн үргжилтийн чухал үзүүлэлтүүд болох нийт төрөлтөнд эмэгтэй хүүхдийн эзлэх хувийн жин (брutto коэффициент) буюу бохир итгэлцүүр, цэвэр итгэлцүүр буюу эмэгтэй хүүхдүүдийн амьдрах магадлалыг тоодож гаргасан үзүүлэлтүүд (нетто коэффициент) чухал ач холбогдолтой юм (4).

Бид эдгээр үзүүлэлтийг тус аймагт 1976—1984 онд төрсөн, наас барсан хүүхдийн тоо болон эмэгтэй хүн амын материалд үндэслэлэж аймгийн хүн амын наслалтын хүснэгтийг зохих журмаар гаргав.

Говь-Алтай аймагт сүүлийн таван жилийн (1980—1984) дунджаар нийт төрсөн хүүхдэд охидын эзлэх хувийн жин 48,8% байна. Аймгийн эмэгтэй хүн амын наслалтын хүснэгтийн материалд үн-

дэслэж ердийн аргаар дээрх үзүүлэлтүүдийг бодоход Говь-Алтай аймагт брутто үзүүлэлт 3,1, нетто үзүүлэлт 2,4 байгаа нь Р. Гурин 1962—1963 оны материалаар тогтоосон үзүүлэлтээс (3,4 ба 2,9) аль аль нь бага байна.

ДҮГНЭЛТ: 1. Говь-Алтай аймгийн хүн амын 51,3% нь эмэгтэйчүүд байгаагийн дотор 15—49 наасны эмэгтэйчүүд 24,2%-ийг эзэлж, жилдээ 1000 хүн амд ногдох төрөлт 37,4, хүн амын жилийн цэвэр өсөлт 27,6 промилл байгаагийн үрээр аймгийн хүн ам суулийн 10 жилд 17,5% өссөн байна.

2. Тус аймагт төрж байгаа эхчүүдийн 30,5% нь аймгийн төвд 69,5% нь сумдад төрж байгаа нь сум, сум дундын эмнэлэгт ажиллаж байгаа эмч иарт эх барих, эмэгтэйчүүдийн мэдлэг дадлага олгох, тэдний мэргэжлийг дээшлүүлж давтан сургах, нэгдлүүдэд ажиллаж байгаа төрөхийн өмнөх амрах байрны ашиглалт, зохион байгуулалтыг цаашид улам боловсронгуй болгохын чухлыг харуудж байна.

3. Бидний судалгаагаар төрөлтийн дугаар ихсэхийн хэрээр түхайн наасны бүлэгт төрөх хувийн жин багасч байгаа бөгөөд эмэгтэйчүүдийн төрөх чадвар 15—19 насандaa хамгийн бага (38,2 промилл), 25—29 насандaa их (367,2 промилл) болж хойших насанд аажим буурч байна. Харин 20—24 насандaa төрөх чадвар осч байна.

4. Говь-Алтай аймаг 1976—1984 оны хооронд эмэгтэйчүүдийн төрөх чадвар 223,6—139,7 промиллийн хооронд хэлбэлзэж өрнхийдөө буурах хандлагатай байна.

5. Эмэгтэйчүүдийн төрөх чадварын нийлбэр үзүүлэлт 6,6, брутто үзүүлэлт 3,1, нетто үзүүлэлт 2,4 байгаа нь 1960-аад оны үзүүлэлтээс буурч байгааг харуулж байна. Энэ нь хүн ам соёлжиж сурч боловсрох, хотжих үзэгдлийг дагаж эмэгтэйчүүдийн цөөн хүүхэдтэй байх сонирхол ихэсч байгаатай холбоотой байж болох юм.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. Р. Гур—Хүн амын эрүүл мэндийн байдалд хийсэн статистик судалгаа. УБ, 1967, 213.
2. Ж. Дугаржав—Пособие к практическим занятиям по санитарной статистике. 1973. 127.
3. И. С. Гусева—Демографическая статистика. 1977. 83.
4. А. М. Мерков, Л. Е. Поляков—Санитарная статистика. 1974. 383
5. Под. ред. И. В. Ильина—Организация родовспоможения и гинекологической помощи в СССР. 1980. 239.

НЕКОТОРЫЕ ВОСПРОИЗВОДСТВА НАСЕЛЕНИЯ ГОБИ-АЛТАЙСКОГО АЙМАКА

Г. Зунай, Р. Бямба

На анализе данных за последние 10 лет, авторами рассчитаны показатели рождаемости, смертности и прирост аймачного населения имеется тенденция снижения динамики плодовитости женщины детородного возраста в аймаке. Население в Гоби-Алтайском аймаке за последние 10 лет увеличилось на 17,5%.

Редакций ирсэн 1985. 11. 19

Ц. ХАЙДАВ, (Ардын эмнэлгийн хүрээлэн)

Ч. ДОЛГОР, Б. ХҮРЭЛЧУЛУУН (Арьс өнгөний эмгэг судлалын нэгдсэн төв)

АРЬСНЫ ЗАРИМ ӨВЧНИЙ ҮЕД ДОГОРЫН НИЙЛБЭР БОДИСТОЙ НОХОЙН ХОШУУНЫ ТОСЫГ ХЭРЭГЛЭСЭН ДҮН

Манай оронд сүүлийн жилүүдэд эмийн ургамлын хими-фарма-
кологийн судалгаа нэлээд хийгдэх боллоо. Мөн ардын эмнэлэгт
өргөн хэрэглэж байсан эмийн ургамлуудаас судлан, анагаах ухаанд
янз бүрийн өвчнийг эмчлэхэд хэрэглэсэн нь үр дунгээ өгч байна.
ЗХУ, БНБАУ, БНАГУ-д гоо сайхан болон арьсны өвчинд эмийн
ургамлуудыг хэрэглэх судалгааны ажил хийгдэж практикт нэв-
тэрч байна (8).

Манай оронд сүүлийн жилүүдэд янз бүрийн гарал, шалтгаан-
тай арьсны өвчнүүд багагүй тохиолдох боллоо. Иймээс бид ургам-
лын гаралтай түүхий эдээр эм бэлдмэл хийж ашиглах зорилгоор
дорогын нийлбэр бодистой нохойн хошууны тостой бэлдмэл хийж
клиникт туршив.

Нийлбэр бодистой тосны найрлага (100 гр-д)

1. Дорогын газрын дээд хэсгээс ялгасан флавоноидын төрлийн
бодис 5%
2. Өндөр зоосон цэцгийн үндэснээс ялгасан (усан хандаар)
хуурай бодис 5%
3. Нохойн хошууны урийн цэвэр тос 40%
4. Ланолин (суурь) 50% болно.

Энэ тосыг фармакопейн зааврын дагуу (7) бэлтгэв. Уг тосонд
орсон түүхий эд, бодисуудыг авч үзвэл:

1. *Caragana pteris mongolica*-монгол дотор

Монгол дотор нь манай орны эндемик ургамал бөгөөд овгийн
дорогын төрөлд хамаардаг соёглог ургамал юм (2). Химийн талаар
нарийн судалгаа хийгээгүй. Харин гликозидын төрлийн „гипола-
тин 7“ бодисыг ялган авсан болно (3). Фармакологийн судалгаа-
гаар олон талын үйлчилгээтэй болох нь тогтоогдсон (4).

Бид дорогын хандны, арьсны хялгасан судасны үрэвслийг нам-
даах үйлчилгээтэй (4) байдлыг сонирхон физиологийн идэвхт зарим
бодисын судалгааг арта зүйн дагуу (1) хийв. Үүнд: флаваноид,
сапонин, гликозидын төрлийн бодисууд чанарын урвалжаар илэр-
сэн. Флаваноидын төрлийн бодис нийлбэрээр 1,7—2% байгаа нь
тооны тодорхойлтоор илэрхийлэгдэв.

Уг нийлбэр бодисыг цэвэршүүлсэн байдлаар ялган авч цаасан
хроматографийн аргаар судалгааг хийхэд флаваноидын төрлийн 3
бодис илэрсэн нь тэрчлэгч бодис болон тархалтын коэффициентын
байдлаас үзэхэд рутин, кверцетинтэй төстэй байв.

Ер нь флаваноидын төрлийн бодисууд судасны ханыг биежуулэх,
үрэвслийг намдаах үйлчилгээтэй байдаг. Иймд уг нийлбэр боди-
сыг тосны орцонд сонгон авлаа.

2. Нохойн хошуу *Rosa acicularis*

Нохойн хошуу нь сарнайн төрөлд хамаардаг. Манай оронд 9
зүйл нохойн хошуу (*R. acicularis*, *R. Beggeriana*, *R. albertii*, *R.*
oxyacantha, *R. davurica*, *R. Laxa*, *R. pimpinellifolia*, *R. platyacan-
tha*, *R. kokanica*) ургадаг (2).

Эдгээрийн алийг нь ч эмнэлгийн практикт хэрэглэж болно.

Бид сүүлийн үед нохойн хошууны жимсийг витамин дутагдахад өргөн хэрэглэж байгаатай холбогдуулан үрийн хаягдлыг ашиглах зорилгоор хамгийн элбэг ургадаг оргөст нохойн хошуу (*Rosa acicularis*) -ны дан үрийн тосны физик химийн шинж чанарыг судлав, Үрийн тосыг петролейны эфирист ялган шиаж чанарын тодорхойлолтыг хийв.

Хүснэгт I

Оргөст нохойн хошууны дан үрийн тосны физик химийн шинж

Физик химийн шинж чанар	Үзүүлэлт
Өнгө байдал амт	Улаан шаргал өнгөтэй шингэн, амтгүй
Гарц	7—9%
Гэрлийн хугарал 20 ид	1,46
Хэт ёслийн тоо	0,11—0,12
Хүчлийн тобо	3,6—4,2
Саванжилтын тоо	188,4—189,6
Эфирийн тоо	184,8—185,0
Иодын тоо	60—65

Хүснэгт I-ээс харахад оргөст нохойн хошууны дан үрийн тосны 7—9% гарцтай улаан шаргал өнгөтэй шингэн тос бөгөөд тосны ханаагүй хүчлээр баялаг, удаан хадгалах боломжтой сайн чанарын тос болох нь илрөч байна.

ШУА-ийн химийн хүрээлэнгийн судалгаагаар уг тосонд тосны ханаагүй хүчил 60% үүнээс липолин, липолин хүчлүүд 40% эзлэж байгаа нь тодорхойлогдов. Эдгээр шинж чанар нь нийлбэр тосонд хэрэглэхэд чухал нөлөөтэй байлаа.

3. Өндөр зоосон цэцэг — *inula helenium*

Энэ нь нийлмэл цэцэгтний овгийн олон наст овслэгт ургамал бөгөөд практикт өргөн хэрэглэж байгаа физиологийн идэвхт олон төрлийн бодисыг агуулсан байдаг.

Уг ургамлын үндсийг ардын эмпэлэгт өргөн хэрэглэж байснаас гадна шинжлэх ухааны үндэслэлтэйгээр нэлээд судалжээ (6).

Сүүлийн үеийн судалгаанаас өндөр зоосон цэцгийн үндэс микроб эсэргүүцэх, халдвартгүйжүүлэх үйлчилгээтэй болох нь тогтоогдов (8). Иймд бид энэ талын үйлчилгээг харгалзан нийлбэр тосонд усан хандыг хуурайшшуулах замаар гарган авсан бодисыг хэрэглэв. (Хэвлэлийн мэдээгээр голдуу усан хандаар хэрэглэдэг).

Дээрх найрлага бүхий тосон бэлдмэлийг арьсны овчнийг анааход хэрэглэв.

Нийлбэр тосыг арьсны овчтэй 32 овчтонд өдөрт 1—2 удаа түрхэж хэрэглэв. Үр дүн сайтай үед тосыг 10—12 хоног түрхэв. Харшилын чанарын арьсны үрэвсэлтэй овчтонд үр дүн сайн байгаа нь ажиглагддаг. Арьс нь их загатнаад улаан хавтгай үлдийн үед загатнаа намдаах үйлчилгээтэй байв.

Энэ тос загатнаа дарах үйлчилгээтэйгээс гадна арьсиг зөөлрүүлэх давхар үйлчилгээтэй байв. Харин нейродержимтын үед тодийж сайн үр дүн өгсөнгүй.

Судалгаанаас үзэхэд арьсны овчтэй 32 овчтоний 22-д нь загатнах зовиур багасах буюу дарагдаж, 4 овчтонд ямар нэг сайжирал өгөөгүй, 6 овчтонд муу нөлөө үзүүлэв. Нийлбэр тосыг хэрэглэсэн 32 овчтонд цусны ерөнхий шинжилгээг эмчилгаэнд өмнө, хойно нь хийв. Үүнд ямар нэгэн өөрчлөлт гарсангүй.

Нийлбэр тосыг зарим арьсны өвчинд хэрэглэсэн үзүүлэлт

Өвчиний нэр	Хүний тоо	Загатнах нь Үгүй болж элтэрсэн	Загатнах шинж хэвээр байгаа	Үр дүн өгөө- гүй	Өвчин ихэссэн
Харшлын чанартай арьсны цочмог үрэвсэл	6	5	1	1	1
Нейродер- мит	хязгаарлагдмал	4	—	2	1
	түгээмэл	7	2	3	2
Маажуур (почесуха)	2	2	1	1	1
Улаан хавтгай үлд	5	3	2	1	1
Нянгийн гаралтай экзем	5	—	—	2	3
Мөөгөн хэлбэрт микоз	3	—	3	1	1
Бүгд	32	12	10	4	6

ДҮГНЭЛГ 1. Нийлбэр төс нь арьсны өвчинд чухал нөлөө бүхий тосны ханаагүй хүчлээр баялаг, картопонд болон флаваноидын төрлийн физиологийн идэвхт бодисууд агуулсан болох нь судалгаагаар тодорхойлгдоз.

2. Энэ тос клиничийн судалгаагаар загатнах зовиур ихтэй, архаг явцтай, арьсны өвчтонд үр дүнтэй байна. (харшлын чанартай арьсны үрэвсэл, улаан хавтгай үлд)

3. Нийлбэр тосыг манай нөхцөлд арьсны зарим өвчиний эмчилгээнд хэрэглэх боломжтой гэж үзэж байна.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. Н. И. Гринкевич, Л. И. Сафронич — Химический анализ лекарственных растений. М., 1983
2. В. И. Грубов — Определитель сосудистых растений Монголии. Л., 1982
3. Г. Г. Запесочная, Т. Т. Пончарова — Гипполаэтин 7 гликозид карноптиса. 1973.
4. И. В. Николаевич, Ц. Хайдав Влияние карноптериса монгольского на реактивность капилляры кожи и воспалительному агенту. Шинжлэх ухааны академийн анагаах ухааны эрдэм шинжилгээний бичиг. 1965. 9.
5. А. И. Сало — Зеленые друзья человека. Л., 1975.
6. А. Д. Турова — Лекарственные растения СССР и их применение. М., 1974
7. Фармакопей — ГОС Х. Москва., 1968
8. П. Чуршнов — Фитотерапия в дерматологии и косметике. София., 1979.

РЕЗУЛЬТАТЫ ПРИМЕНЕНИЯ МАЗИ, СОСТОЯЩЕЙ ИЗ СУММЫ ВЕЩЕСТВ КАРИОПТЕРИСА, ПРИ НЕКОТОРЫХ КОЖНЫХ ЗАБОЛЕВАНИЯХ

Ц. Хайдав, Ч. Долгор, Б. Хүрэлчулун

Авторами применено мазь, состоящей из суммы веществ кариоптериса на масле шиповника, для лечения некоторых кожных заболеваний.

Физикохимическими исследованиями установлено, что изучаемая мазь богата физиологически активными веществами типа каротиноидов и флавоноидов, ненасыщенными жирными кислотами, обладающими положительными и влияниями на ряд кожных заболевания.

Клиническими испытаниями выявлены нейбольшую эффективность применения данной мази при таких кожных заболеваниях, имеющих длительное хроническое течение с выраженным зудом, как аллергический дерматит, красный плоский лишай, а при некоторых зудящих дерматозах типа нейродермита не получены лечебного эффекта.

Редакцид ирсэн 1985—10—30

Б. ШИЖИ РБААТАР (Анагаах ухааны дээд сургууль)

Г. ПҮРЭВ СҮРЭН (Эх нялхыг хамгаалах эрдэм шинжилгээний хүрэлэн)

ЗҮРХНИЙ ГАЖИГТАЙ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН УРГИЙН БАЙДЛЫГ ХЭТ АВИАГААР СУДАЛСАН ДҮН

Сүүлийн үед эх барих эмэгтэйчүүдийн практикт хэт авианы оношлогооны аргыг хэрэглэх болсноор ургийн байдлыг үнэн зөв оношилж түүний осолт, эхсийн эмгэг, ураг хавийн усны байдлыг ажиглах боломжтой боллоо. Хэт авианы оношлогооны арга нь шинжилгээнд тусгайлан бэлтгэх шаардлагагүй, бие маходод хорт нөлөөгүй, техникийн хялбар ажиллагаатайгаараа бусад оношлогооны аргаас давуутай юм.

Судалгааны материал, арга

Цусны эргэлтийн алдагдал бүхий зүрхний гажигтай эхдэс төрсөн нярайн 29,2% нь хүчинтөрөгчийн архаг дутмагшлын нөлөөнөөс осолт нь удааширч туралтай төрдөг болохыг зөвлөлтийн судлаачид тогтоожээ (3).

Иймд бид зүрхний гажигтай жирэмсэн эмэгтэйчүүдийн ургийн байдлыг судлах зорилгоор зүрхний олдмол ба төрөлхийн гажигтай 50, эрүүл 30 бүгд 80 эмэгтэйн ургийн байдлыг хэт авиаагаар оношлов. Эмэгтэй тус бурд жирэмсний 28, 30, 36, 38 долоо хоногтой хугацаанд хэмжиж динамик ажиглалт хийсэн бөгөөд ургийн зулайн ясны төвгөрүүдийн хоорондох хэмжээ (БПХ), цээжний дундаж хэмжээ (T), хэвлийн дундаж хэмжээг (A) дээр дурдсан хугацаанд хэмжиж тэдгээрийн 7 хоногийн осолтийн байдлыг гаргаж үзлээ.

Зулай ясны төвгөрүүдийн хоорондох хэмжээг тархины авиааны дундаж бүтцээс (M-эх) зулай ясны хоёр төвгөр ижил зайд байхаар тохируулан, дээд төвгөрийн гадна доод төвгөрийн дотор захаар хэмжив. Ургийн цээжний хэмжээг зүрхний хавхлагуудын төвшинд, хэвлийн хэмжээг хүйний венийн эсвэл ургийн хоёр бөөрний төвшинд хэмжив. Судалгааг Япон улсын "Алоке" фирмийн "Эхокамера ссд 202" аппаратаар хийв.

Судалгааны дун. Зүрхний гажигтай ба эрүүл жирэмсэн эмэгтэйчүүдийн ургийн хэмжээнүүдийг харьцуулан узэхэд эрүүл эмэгтэйн ургийн хэмжээнүүд зүрхний гажигтай эмэгтэйчүүдийн ургийнхаас даруй 0,51—3,63 мм-ээр их байна.

Xүснэгт 1.

Зүрхний гажигтай ба эрүүл жирэмсэн эмэгтэйчүүдийн ургийн хэмжээнүүдийн харьцаа

Зүрхний гажигтай эмэгтэйчүүдийн ургийн хэмжээнүүд

Жирэмсний хугацаа (долоо хоногоор)	БПХ (мм) $M \pm m$	Цээжний дундаж хэмжээ (Т) мм $M \pm m$	Хэвллийн дундаж хэмжээ (А) мм $M \pm m$
28	68,5±0,20	69,0±0,24	71,4±0,18
30	72,7±0,22	75,9±0,16	79,5±0,17
36	85,2±0,16	89,6±0,23	92,2±0,25
38	87,8±0,32	93,4±0,21	98,4±0,17

Бидний судалгаагаар тогтоогдсон эрүүл жирэмсэн эмэгтэйчүүдийн ургийн хэмжээнүүд (б), Зөвлөлтийн эрдэмтэн Л. С. Персианинов В. Н. Демидов нарын судалгаагаар тогтоогдсон хэмжээтэй (а) үндсэндээ тохирч байв.

Xүснэгт 2

Эрүүл жирэмсэн эмэгтэйчүүдийн ургийн хэмжээнүүд

Жирэмсний хугацаа (7 хоногоор)	БПХ (мм) $M \pm m$		Т (мм) $M \pm m$		А (мм). $M \pm m$	
	a	b	a	b	a	b
28	70,5	69,3±0,27	71,9	70,5±0,26	73,5	72,1±0,39
30	75,4	74,7±0,18	77,4	76,5±0,24	79,3	80,2±0,22
36	87,7	86,7±0,17	91,8	90,3±0,26	94,8	93,5±0,21
38	91,0	91,4±0,20	95,3	94,3±0,23	99,3	98,4±0,17

Эрүүл жирэмсэн эмэгтэйчүүдийн ургийн БПХ жирэмсний 28—30 долоо хоногтой хугацаанд 7 хоногт $2,68 \pm 0,04$ мм осож байхад зүрхний гажигтай эмэгтэйчүүдийн урагт $2,36 \pm 0,06$ мм, ургийн цээжний дундаж хэмжээ энэ хугацаанд эрүүл хүмүүст $3,53 \pm 0,01$ мм нэмэгдэж байхад зүрхний гажигтай эмэгтэйд $1,87 \pm 0,04$ мм, ургийн хэвллийн дундаж хэмжээ эрүүл хүмүүст $4,12 \pm 0,02$ мм, өвчтэй хүмүүст $4,09 \pm 0,08$ мм нэмэгдэж байлаа. Харин жирэмсний 36—38 долоо хоногтойд ургийн хэмжээнүүдийн осолт илт удааширч байгаа нь ажиглагдав.

Үүнд: Ургийн БПХ эрүүл жирэмсэн эхчүүдэд 7 хоногт $2,36 \pm 0,01$ мм, зүрхний гажигтай хүмүүст $1,31 \pm 0,08$ мм, цээжний дундаж хэмжээ $1,87 \pm 0,01$ мм, хэвллийн хэмжээ эрүүл хүмүүст $2,45 \pm 0,02$ мм, өвчтэй хүмүүст $2,39 \pm 0,02$ мм тус тус осож байсан болно.

БПХ-ний осолт жирэмсний хугацаатай шууд хамааралтай бай-
даг бөгөөд энэ хамаарал нь: $B = -0,0521 \cdot W^2 + 5,49$. $W = 42,4$ (3)
гэсэн томъёогоор илэрхийлэгднэ.

Үүнд: $B = \text{БПХ}$, W — жирэмсний хугацаа (7 хоногоор). Энэ томъ-
ёогоор бодоход жирэмсний тодорхой хугацаанд тохирих БПХ гар-
на. Гэтэл жирэмсний тухайн хугацаанд тохирих БПХ хэвийн үеийн
хээс 2—2,5 долоо хоногоор бага байхаар гарвал ураг хөнгөн хэл-
бэрийн тураалтай 3—4 долоо хоногоор бага байвал ургийн осолт
ихээхэн удаашралтай байгаат үзүүлиэ (2,3).

Бидний судалгаанд хамрагдсан 28 долоо хоногийн жирэмсний
хугацаатай зүрхний гажигтай эмэгтэйчүүдийн 4(8)-ийн БПХ нь
62—65 мм, 30 долоо хоногтой үед 3(6)-ийн БПХ нь 68—70 мм,
36 долоо хоногтой үед 8(16)-ийн БПХ нь 82—84 мм, 38 долоо
хоногтойд 8(16)-ийн БПХ нь 85—87,5 мм байсан учир ургийг
хөнгөн хэлбэрийн тураалтай гэж оношлов. Эдгээр эмэгтэйчүүд нь
цусны эргэлтийн алдаалын 11б зэрэгтэй хүнд хэлбэрийн зүрхний
гажигтай хүмүүс байв. БПХ-ний осолт зогсох нь ураг осолтгүй
болсныг гэрчилнэ.

БПХ-г цээж ба хэвлэйн дундаж хэмжээнд харьцуулсан харь-
цаа нь ямагт 1-ээс бага байх ба энэ нь байх ёстой хэмжээнээс
5%- нас илүүгээр ихэссэн байвал ургийн тураал гэж оношлож бо-
лох юм.

Энэ харьцаа нь дараах томъёогоор илэрхийлэгднэ.

$$\begin{aligned} B/T &= 1,068 - 0,00315 \cdot W \\ B/A &= 1,0745 - 0,00415 \cdot W \end{aligned} \quad (2)$$

Т — цээжний дундаж хэмжээ.

А — Хэвлэйн дундаж хэмжээ

W — Жирэмсний хугацаа (7 хоногоор)

Бидний судалгаагаар 36—38 долоо хоногтой жирэмсний хуга-
цаанд илэрсэн тураалтай 8 ургийн B/T харьцаа 1,05—1,07 байсан
нь ураг хөнгөн хэлбэрийн тураалтай байгааг давхар нотолж бай-
лаа.

ДҮГНЭЛТ: 1. Цусны эргэлтийн алдагдал бүхий зүрхний хүнд хэл-
бэрийн гажигтай жирэмсэн эмэгтэйчүүдийн ургийн осолт удааш-
ралтай явагддагаас тэдгээрийн 16% нь хөнгөн хэлбэрийн тураал-
тай байдаг байна.

2. Жирэмсний хугацаа ахих тутам ургийн осолтийн хурдац
удааширч байпа.

3. Ургийн осолтийн удаашралт ба тураалыг БПХ, толгой-цээж
(B/T), толгой-хэвлэйн (B/A) харьцааг ашиглаан оношлох бүрэн бо-
ломжтой.

4. Хэт авианы шинжилгээний аргыг цаашид клиникийн болон
судалгаа шинжилгээний ажилд оргеноор ашиглах шаардлагатай
байна.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. А. Н. Валентинова—Риск беременности родов и состояние новорожденных у женщин с пороками сердца. Дис. на соиск. уч. степени канд. мед. наук. М. 1974.
2. В. Н. Демидов—Клиническое значение ультразвукового определения бипи-
риетального размера головки плода. Акуш. и гин. 1979, 8, 50—52
3. Л. С. Персианинов, В. Н. Демидов—Ультразвуковая диагностика в аку-
шерстве. М, Медицина, 1982. 8. 95—120

РЕЗУЛЬТАТЫ УЛЬТРАЗВУКОВОГО ИССЛЕДОВАНИЯ
СОСТОЯНИЯ ПЛОДА У БЕРЕМЕННЫХ ЖЕНЩИН С ПОРОКАМИ
СЕРДЦА

Б. Шижир-батор, Г. Пурэвсурен

С целью установления внутриутробного состояния плода, авторами подвергнуты к ультразвуковому исследованию 50 беременных с пороками сердца. Исследование установлено, что по мере прогрессирования беременности постепенно снижается скорости роста размеров плода. В третьем триместре беременности у 16% беременных с пороками сердца наблюдалась легкая степень внутритробной гипотрофии плода.

Редакция ирсэн 1985.04.05

Ш. ЧАДРААБАЛ Д. ЭРЖЕН (Анагаах ухааны хүрээлэн)

ХОДООДНЫ АРХАГ ҮРЭВСЛИЙН ҮЕД ХЭРЭГЛЭХ
ЭМЧИЛГЭЭНИЙ ХООЛНЫ АСУУДАЛД

Ходоодны архаг үрэвсэл нь хоол боловсруулах эрхтний овчний дотор хамгийн элбэг тохиолддог. Энэ овчний үед ходоодны салст бүрхэвчид дистрофи-атрофийн шийжтэй өөрчлөлт гаражын зэрэгцээ ходоодны шүүсний хэмжээ, найрлагад чанарын өөрчлөлт гардаг.

Ходоодны архаг үрэвсэл нь олон янзын шалтгаанаар үүсэж болох бөгөөд хамгийн гол нь хооллох дэглэмийг зөв баримтлаатүйгээс үүсдэг.

Ходоодны архаг үрэвслийг эмчлэхэд овчний үе шатыг харгалзан хоолыг тодорхой дэглэмтэйгээр зөв тохишуулах нь чухал ач холбогдолтой болохыг эрдэмтэд судлан тогтоожээ (1-3).

Судалгааны материал, арга Бид „Оргил“ „Жанчивлин“ рашаан сувилал, хоолоор сувилах төв сувилалын эмчилгээний бодит хоолыг лабораторийн болон тооцооны аргаар тодорхойлж, мөн ходоодны архаг үрэвсэлтэй 134 хүнд хоолны эмчилгээний судалгаа хийв.

Хоолны найрлагыг тооцоолоходоо үндсэн шимт бодисын хэмжээ, харьцаа, хоногийн хоолны илчлэгийг тодорхойлов.

Судалгааны үр дүн.

Судалгаанаас үзэхэд ходоодны архаг үрэвсэлтэй хүмүүсийн хэрэглэж байгаа хоолны илчлэг нь хангалттай байгаа боловч хоногийн хоолны найрлагын тохиороо, хосллох дэглэм нь тухайн овчний онцлогт тохироогүй байгаа нь ажиглагдах байна.

Хүснэгт 1-ээс үзэхэд ходоодны үрэвсэл 30—49 насанд хамгийн олон тохиолдож байгаа бөгөөд нийт тохиолдлын 60,4 хувийг эзэлж байна.

Удаан хугацаагаар хоол идэхгүй байх, хурц хоом идэх, хэтэрхий халуун хоол үнд хэрэглэх, цаг баримжаагүй хооллох, архи, тамхийг хэтрүүлэн хэрэглэх нь ходоодны архаг үрэвсэл үүсэхэд нөлөөлдөг болох нь нэгэнт тогтоогдсон бөгөөд бидний судалгаагаар, судалгаанд хамрагдсан нийт хүмүүсийн 68,7 хувь хооллох дэглэмийг нарийн баримталдаггүй хүмүүс байлаа.

Хүснэгт 1

**Судалгаанд хамрагдсан хүмүүсийн
нас, хүйс**

Хүйс	Насны бүлэглэл				
	20—29	30—39	40—49	50—59	60-аас дээш
Эрэгтэй Эмэгтэй ДҮН	4 10 14	17 30 47	18 35 53	13 14 27	12 3 15

Хүснэгт 2

**Ходоодны архаг үрэвсэл үүсэхэд нөлөөлөх
зарим хүчин зүйлийн эзлэх хувийн жин (хувиар)**

Үрэвсэл үүсэхэд нөлөөлөх хүчин зүйл	Эзлэх хувийн жин
Хооллох дэглэм баримтлаагүй	68,7
Архи уудаг	8,9
Тамхи татдаг	25,2
Унтахын өмнө хоол иддэг	25,2

Ходоодны архаг үрэвсэл нь удаан хугацаанд үргэлжилдэг архаг өвчин учир ходоодны салст бүрхэвчинд гарах өөрчлөлт нь хэдэн жилийн дараа илэрч болно.

Хүснэгт 3

**Ходоодны архаг өвчтэй хүмүүсийн
өвчлөлийн хугацаа**

Өвчилсөн хугацаа	Насны ангилаал				
	20—29	30—39	40—49	50—59	60-аас дээш
3 жил хүртэл	8	3	9	3	2
4—6 жил	6	19	16	5	2
7—9 жил	—	15	15	8	3
10-аас дээш жил	—	10	13	11	8
БҮГД	14	47	53	27	15

Ходоодны салст бүрхэвчинд органик өөрчлөлт гарахаас өмнө яз бүрийн шинж тэмдэг илрэх үед нь тодорхой эмчилгээ хийлгэх, хооллох дэглэмийг нарийн баримтлахгүй бол удаан хугацаанаар үргэлжлэн даамжирдаг онцлогтой.

Хүснэгт 4-ээс үзэхэд ходоодны архаг үрэслэлийн гол шинж нь хоолонд дургүй болох, хоолны шингэц муудах, цээж хорсох, өрциен дээр өвдөх зэргээр илэрдэг ба бие сулрах, түргэн ядрах шинж тэмдэг нь хоолны шингэн муудаж бодисын солилцооны өрөнхий хямрал үүссэнтэй холбоотой юм.

Ходоодны архаг үрэслэлийг цаг тухайд нь эмчилж цаашид даамжрахаас урьдчилан сэргийлэх гол арга нь хоолны найрлагын

Xүснэгт 4

**Ходоодны архаг үрэвслийн клиникийн зарим
шинж тэмдгийн илрэл (хувиар)**

Гол шинж тэмдэг	Илэрсэн хувь
Аль нэг төрлийн хоолонд дургүй болох (хооллох сонирхол жамрах)	100,0
Хэхрүүлэх	67,2
Цээж хэрсох	69,0
Бөөлжис цутгах, хааяа бөөлжих	28,4
Өрцөн дээр өвдөх	70,0
Өтгөн хатах	34,0
Суулгах	22,4
Өтгөн хатах, суулгах ээлжлэх	44,0
Гэдэс дүүрэх	77,6
Цанхайх	28,0
Бие сурлах, түргэн ядрах	77,6

тохироо, хооллох дэглэмийг өвчний үе шаттай уялдуулан зөв тохицуулах явдал байдаг.

Бид ходоодны архаг үрэвсэлтэй хүмүүст өгч байгаа хоолны найрлага, илчлэгийг МҮЭ-ийн Төв Зөвлөлийн харьяа хоолны төв сувилал, „Оргил“, „Жанчивлин“ сувиллуудад судлан үзэхэд хоногийн хоолны илчлэг нь шаардлага хангаж ($2641 \pm 163,9 = 3577,2 \pm 150,6$ ккал) байгаа боловч кальци, фосфор зэрэг зарим эрдсийн бодис С витамины хэмжээ шаардлагаас нэлээд доогуур байлаа.

Xүснэгт 5

**Ходоодны архаг Үрэвсэлтэй хүмүүсийн хэрэглэсэн
бодит хоолны найрлага, илчлэг (M+m)**

Сувиллын нэр	Уураг (г)	Өөх тос (г)	Нүүрс ус (г)	Илчлэг (ккал)
Хоолны төв сувилал „Оргил“ сувилал	$106,8 \pm 12,4$ $134,5 \pm 10,5$	$109,7 \pm 13,1$ $95,3 \pm 12,3$	$288,6 \pm 17,9$ $506,2 \pm 20,5$	$2641 \pm 163,9$ $3577,2 \pm 150,6$

Дээрх хоёр сувилалд ходоодны архаг үрэвсэлтэй хүмүүст өгч байгаа хоолны найрлаганд байгаа үндсэн шимт бодис болох уураг, өөх тос, нүүрс усны хэмжээний харьцаа 1:1:2,7—1:07:3,7 байгаа нь түргэн хугацаанд боловсорч шингэдэг онцлогтой нүүрс усны хэмжээ харьцангуй бага байгааг харуулж байна. Мөн „Жанчивлин“ сувилалд ходоодны архаг үрэвсэлтэй хүмүүст өгч байгаа хоолны найрлаганд байгаа өөх тосны хэмжээ харьцангуй их байлаа. ДҮГНЭЛГ. 1. Ходоодны архаг үрэвсэл нь 30—49 наасны хүмүүст зонхилон тохиолдож байна.

2. Ходоодны архаг үрэвсэлтэй хүмүүсийн сувиллын иөхцөлд хэрэглэж байгаа хоолны найрлагыг уг өвчний үешатыг харгалзан нарийвчлан тогтоох шаардлагатай байна.

3. Ходоодны архаг үрэвслийн үед хэрэглэх эмчилгээний үр нөлөөг дээшлүүлэхийн тулд хялбархан боловсрон шингэдэг хүнсний бүтээгдэхүүнээр сувиллын газруудыг хангах, витамин ихтэй хоол өгөх зэрэг зохион байгуулалтын арга хэмжээ авах нь чухал байна.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. В. Х. Василенко, А. Л. Гребенев—Болезни желудка и 12-перстной кишки. М., Медицина, 1981, 48—49.
2. А. А. Покровский, И. С. Савошенко, М. А. Самсонов, М. С. Маршак, М. И. Черников, А. М. Ногаллер—Лечебное питание. М., Медицина 1971, 124—129.
3. М. А. Самсонов—К оценке эффективности диетической терапии. Тезисы докладов II Всесоюзной конференции. М., 1976, 239—240.
4. Справочник по диетологии. Под редакцией А. А. Покровского, М. А. Самсонова. М., Медицина, 1981, 212—216.

К ВОПРОСУ ДИЕТОТЕРАПИИ БОЛЬНЫХ ХРОНИЧЕСКИМ ГАСТРИТОМ

Ш. Чадрабал Д. Эржэн

Авторами исследовано фактическое состояние лечебного питания больных хроническим гастритом в Центральной диетической столовой, санаториях „Оргил“ и „Жанчивлин“.

Отмечено, что оно в отношении калорийности, хотя и удовлетворяет физиологическим нормам, но не сбалансировано по химическому составу, содержит низкое содержание некоторых витаминов и минеральных веществ.

Среди причин, способствующих возникновению хронического гастрита наибольший удельный вес (68,7%), по материалам авторов, принадлежит несоблюдению больными соответствующего режима питания.

Редакцийд ирсэн 1985—06—11.

М. АЛТАНХҮҮ, П. НЯМДАВАА, Г. ХОНЬЧИН, А. Г. АНДЖАПАРИДЗЕ,
Т. Е. ВОРОЖБИЕВА, Ё. БАТБОЛД, Ж. ОЮУНБИЛЭГ, Т. ГОМБОСҮРЭН

ВИРУС СУДЛАЛЫН АРГААР ЯЛГАН ОНОШИЛСОН ЦОЧМОГ ГЕПАТИТЫН ҮНДСЭН ХЭЛБЭРҮҮДИЙН КЛИНИК-БИОХИМИЙН ТӨРХ

Анагаах ухааны хүрээлэн

Эрүүл ахуй, халдвэр, иян судлалын улсын институт

Халдварт өвчний анагаах клиникин эмнэлэг

ЗХУ-ын Анагаах ухааны академийн Полиомиелит ба вируст энцефалитын эрдэм шинжилгээний хүрээлэн

ЗХУ-ын Анагаах ухааны академийн Д. И. Ивановскийн нэрэмжит вирус судлалын хүрээлэн

Анхдагч цочмог гепатит үүсгэх чадвартай вирусийн тоо нэг мэгдэж (1,5, 9—14), тэдгээрийн хавсарсан хэлбэр олширч байгаа (7) нь вируст гепатит (ВГ)-уудыг эмнэлэлзүйн шинж, биохимиийн үзүүлэлт, халдвэр судлалын асуумжаар ялган оношдохыг хүндруулж, үүсгэгчийнх нь овормөц маркеруудыг (эсрэг төрөгч ба эсрэг биеийг) ялгах оношид ашиглахыг шаардаж байна. Гэбч вирус судлалын лабораторийн шинжилгээт эмнэлгийн бүх нэгж салбарт нэвтрүүлэх техник бололцоо бурдээгүй байгаа одоо уед ВГ-гийн янз бүрийн хэлбэрийн үе дэх клиник-биохимиийн онцлогийг вирус судлалын шинжилгээгээр онош батлагдсан тохиолдолд судалж тогтоох нь онол, практикийн ихээхэн ач холбогдолтой юм (2, 3, 6, 8).

Тиймээс бид энэ судалгаагаар клиник-эпидемиологийн дүгнэлтэд үндэслэн оношилсон ВГ-ийн тохиолдлуудыг вирус судлалын аргаар шинжлэн оношийн тохиролцоог судлах, манай орны нөхцөлд ВГ-гийн үндсэн хэлбэрүүцийн клиник-биохимиийн онцлогийг илрүүлэн гаргах оролдлого хийх зорилт тавив.

Судалгааны материал, арга

Улаанбаатар хотын халдварт өвчний анагаах клиникин эмнэлэгт 1983, 1984 оны 9—11 дүгээр сард ВГ оноштой хэвтсэн 136 өвчтөний өвчний түүх, тэднээс авсан цусны ийлдсийг судалгааны үндсэн материал болгов.

Цусны ийлдсэнд биохимиийн шинжилгээнүүдийг нийтээр баримталж буй аргаар, уүнд: билирубиныг Ендрашикийн аргаар, аспартат аминотрансфераз (АСТ), алапин-аминотрансфераз (АЛТ)-ын идэвхийг френкель-Райтманы аргаар, тимолын сорилыг Маклаганы аргаар тус тус хийв.

А гепатитын вирусийн эсрэг М иммуноглобулин (АГВ эсрэг Ig-M)-ыг ЗХУ-ын Анагаах ухааны академийн Полиомиелит ба вируст энцефалитын хүрээлэнд боловсруулсан тест-системийг хэрэглэн ферменттэй холбоотой эсрэг биеийн урвал (ФХЭБУ)-аар, В гепатитын вирусийн гадаргуугийн эсрэгтөрөгч (HB_s Ag)-ийг цус шууд бус наалдуулах урвал (ЦШБНУ)-аар тус тус тодорхойлов.

Үр дүн, шүүмж

Судалгаанд хамрагдагсадын 85 (62,5%) нь 19 хүртэлх наасны, 51 (37,5%) нь 20 болон түүнээс дээш наасны хүмүүс байсан бөгөөд шинжилсэн бүх өвчтөний 44 (32,4%)-д нь А гепатитын овормөц маркер АГВ-эсрэг IgM, 58 (42,6%)-д нь В гепатитын овормөц маркер HB_s Ag илэрэ, 34 (25%)-д нь дээрх хоёр маркерын аль

аль нь илэрсэнгүй (хүснэгт 1). Вирус судалын шинжилгээний дүн эмнэлзүйн оноштой 47%-48%-д тохирч байгаа нь манайд ашиглаж буй клиник-эпидемиологийн ялгах оношийн хэмжүүр учир дутагдалтай байгааг харуулж байна.

Хүснэгт 1

Эмнэлзүйн болон вирус судалын оношийн тохиролцоо

Эмнэл зүйн онош	Өвчтөн ний тоо	Үүнээс					
		АГВ-эсрэг IgM(+)		HB _s Ag (+)		АГВ-эсрэг IgM (-) HB _s Ag (-)	
		тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Г.А	66	31	47%	24	36,4%	11	16,7%
Г.В	70	13	18,6%	34	48,6%	23	32,9%
БҮГД	136	44	32,4%	58	42,6%	34	25%

Г. А-гепатит А, Г. В-гепатит В

АГВ-эсрэг IgM илэрсэн буюу цочмог А гепатитаар өвчилсөн хүмүүсийн 20 (45,5%)-д нь HB_sAg давхар илрэв. Харин А гепатиттай өвчтөн болон А гепатитаар өвчилсөн HB_sA_d агуулагчдын

Хүснэгт 2

А гепатиттай өвчтөн болон А гепатитаар өвчилсөн HB_s Ag агуулагчдын клиник биохимийн зарим шинжилгээнүүдийн харьцуулсан үзүүлэлт

Шинжилгээ	АГВ-эсрэг IgM (+)	АГВ-эсрэг IgM (+) HB _s A _d (+)	T	P
Тимолын сорил	11,3±0,5	9,47±0,64	2,29	<0,05
АСАТ	2,05±0,14	1,89±0,21	0,64	>0,05
АЛАТ	3,50±0,19	3,39±0,09	0,55	>0,05
Дундаж ор хоног	22,9±0,8	23,1±0,26	0,25	>0,05
Хордолгын шинж тэмдэг Үргэлжлэх хугацаа	7,64±0,7	8,6±1,46	0,6	>0,05
Шарлалтын үеийн үргэлжлэх хугацаа	10,6±1,0	9,35±1,5	0,65	>0,05
Билирубин	нийт	46,6±4,3	45,27±7,4	0,15
	шууд	31,5±3,1	31,7±5,6	0,003
	шууд бус	18,7±1,6	16,33±2,23	0,87

эмнэлзүй-биохимиийн шинжилгээнд магадтай зөрөө илэрсэнгүй. (хүснэгт 2). Зөвлөлтийн судлаачдын ажиглалттай (7) манай судалгааны дүн зөрж байгааг зөвлөлтийн судлаачид насанд хүрсэн өвчтөнд судалгаа хийсэн бол манай судалгааны 75% нь 5 хүртэлх насны хүүхэд байснаар тайлбарлаж болох юм.

АГВ-ийн эсрэг IgM илрээгүй тохиолдолд HB_sAg бүхий өвчтөнийг бид цочмогт В гепатитаар өвчлөгсөд гэж үзэв. В гепатитаар өвчилсон зарим тохиолдолд HB_sA₂ илрэхгүй байж болох бөгөөд HB_sAg агуулагчид А ч бус В ч бус гепатитаар мөн өвчилиж болох учир В гепатитаар шинээр өвчилсон гэдгийг HB_sAg-ны эсрэг IgM байгаагаар батлах ёстой (14, 15, 16) гэж судлаачид үзэхэд хүрч байгаа боловч HB_c Ag-ны эсрэг IgM илрүүлэх тест-систем бидэнд байхгүй учир HB_sAg-ийг В гепатитын өвөрмөц маркер болгож авахаас өөр арга байсангүй. Тэгээд ч бидний лабораторийн шинжилгээгээр А болон В гепатит гэж үзсэн тохиолдлын насны бүлэг дэх тархалт (хүснэгт 2) нь сүүлийн жилүүдэд манайд бүртгэгдэж буй ВГ-ын халдварт судлалын еронхий төрхтэй (4) дүйж байна.

Хүснэгт 3

Гепатитын вирусийн өвөрмөц маркёрийн илрэлтийг насны байдлаар авч Үзвэл

Насны бүлэг	Өвчтөний тоо	Үүнээс							
		АГВ-ийн эсрэг IgM (+)		HB _s Ag (+)		АГВ-ийн эсрэг IgM (-) HB _s Ag (-)		Бүгд	
		тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
1—4	58	33	75%	18	31%	7	20,6%	58	42,7%
5—9	9	5	11,4%	2	3,5%	2	5,9%	9	6,6%
10—19	18	5	11,4%	12	20,7%	1	2,9%	18	13,2%
20—29	37	1	2,3%	22	38%	14	41,1%	37	27,2%
30—39	10	—	—	3	5,2%	7	20,5%	10	7,4%
40 ба түүнээс дээш	4	—	—	1	1,7%	3	8,8%	4	2,9%
Бүгд	136	44	100%	58	100%	34	100%	136	100%

АГВ-ийн эсрэг IgM, болон HB_sAg илрээгүй цочмог гепатиттай өвчтөнүүдийг бид А ч бус В ч бус гепатитаар өвчлөгсөд гэж үзсэн бөгөөд ийм хэлбэрийн гепатитаар өвчлөгсодийн дийлэнх (41,1%) нь 20—29 насанд бүртгэгдсэн нь ходоод гэдэсний замаар дамжин халдвартладаг А ч бус В ч бус гепатитын тархалтын тухай гадаадын судлаачдын бичсэнтэй (12, 13) тохирч байна.

Вирус судалалын лабораторийн шинжилгээгээр А ч бус В ч бус гепатит онош тавьсан тохиолдлын 70,6% нь эмэгтэйчүүд байгаа нь мөн сонирхолтой юм.

Эмнэлзүйн илрэлийн хувьд судалгаанд хамрагдсан бүх тохиолдлын 62% нь хүндэвтэр хэлбэр байсан бөгөөд А гепатитын үед хөнгөн хэлбэр (33,3%), В гепатитын үед хүнд хэлбэр (61,1%) харьцаангуй илүү тохиолджээ.

Хүснэгт 4

ВГ-ын үндсэн хэлбэрүүдийн эмнэлзүйн илрэл

Эмнэлзүйн явц	HBs Ад (+)		АГВ-эсрэг ИГМ (+)		HBs Ag (-) АГВ-эсрэг ИГМ -(-)		Бүгд	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Хөнгөн	2	5,7%	12	33,3%	3	10,7%	17	17%
Хүндэвтэр	22	61,1%	21	58,3%	19	67,9%	62	62%
Бүгд	36	100%	36	100%	28	100%	100	100%

Вирус судалалын шинжилгээгээр онош нь батлагдсан ВГ-ын үндсэн хэлбэрүүдийн эмнэлзүйн зарим шинж, биохимиин шинжилгээний үзүүлэлтийг харьцуулан үзвэл (хүснэгт 5) шаралт ба хордлогын шинж тэмдэг үргэлжлэх хугацаа, тимолын сорил, билирубины хэмжээ, түүний фракцуудын харьцаа нь ялгах оношийн ач холбогдолтой болох нь харагдаж байна.

ДҮГНЭЛТ: 1. Манай улсад тохиолдож буй ВГ-ын илээд хувийг А ч бус гепатит (25% орчим), ба А, В гепатитын хавсарсан хэлбэр (14,7%) эзэлж байгаа нь ялгах оношийг ихээхэн барьшээлтэй болгож байна.

2. Хэдийгээр ВГ-уудыг халдварт судлаяа, эмнэлзүй-биохимиийн шинжилгээний үзүүлэлтүүдийг үндэслэн ялган оношлоож болох боловч магадтай оношлохын тулд гепатитын вирусуудын өвөрмөц маркеруудыг илрүүлэх шинжилгээ хийх зайлшгүй шаардлагатай юм.

3. А, В, ВГ-уудыг ялган оношлоход биохимиийн шинжилгээнүүдээс тимолын сорил, билирубины фракцii, ГПГ-ын идэвхийг үзүүлэлтийн ялгаа ихээхэн ач холбогдолтой байна.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. М. С. Балаян и др—Вирусный гепатит, сходный по клинике и эпидемиологии с гепатитом А, но отличающийся от него этиологически. ЖМЭИ., 1982, 3, 79—84

2. Ё. Батболд, М. Алтанхүү и др—К вопросу специфической дифференциальной диагностики острых вирусных гепатитов. В кн.: Тезисы докладов четвертой научно-практической конференции „Актуальные вопросы вирусологии“ УБ., 1984. 12—14.

3. Ю. И. Девайте и др—Дифференциальная диагностика вирусных гепатитов А и В. В кн.: „Вирусные гепатиты“ под ред. Е. С. Кетиладзе. М. 1978. 85—88,

4. Г. Жамба и др—Эпидемиологическая характеристика вирусных гепатитов в МНР. ЖМЭИ. 1983, № 1, 86—89.

5. М. И. Михайлов и др—Вирусный гепатит ни А ни В-проблемы изучения. Вопр. вирусол. 1984, 29, 389—399,

6. Э. М. Осна и др—Клиничко-лабораторные различия же лтушных форм инфекционного и сывороточного гепатитов. В кн.: „Вирусные гепатиты“ под Е. С. Кетиладзе, М., 1978. 88—92.

БГ-ын Үндсэн хэлбэрҮдийн клиник-биохимийн зарим ҮзҮүлэлтҮүдийг харьцуулбал

Өвчтөний булэг	HB _s Ag (+)			АГВ-ийн эсрэг ИгM (+)			АГВ-ийн эсрэг ИгM (-), HB _s Ag (-)		
	HB _s Ag (+) бүлэгтэй харьцуулахад			HB _s Ag (+) бүлэгтэй харьцуулахад			АГВ-ийн эсрэг ИгM (-) бүлэгтэй харьцуулахад		
	M±m	M±m	P	M±m	t	P	t	t	P
Тимолын сорил	6,9±0,8	11,3±0,5	3,7	<0,01	6,06±0,71	0,8	>0,05	6,02	<0,001
ACAT (ГОТ)	2,52±0,15	2,05±0,14	2,3	<0,05	1,84±0,12	3,4	<0,001	1,17	>0,05
АЛАТ (ППТ)	4,43±0,1	3,50±0,19	3,4	<0,01	3,6±0,23	2,76	<0,01	0,34	>0,05
Шаралт Үргэлжлэх хугацаа	21,5±1,03	10,6±1,0	7,5	<0,001	15,87±1,6	2,96	<0,01	2,92	<0,01
НИЙТ	79,2±5,8	46,6±4,3	4,53	<0,01	88,8±8,25	0,95	>0,05	4,54	<0,01
ШУУД	54,5±4,3	31,5±3,1	4,34	<0,01	53,8±6,56	1,19	>0,05	3,09	<0,01
ШУУД БУС	23,4±1,53	18,7±1,6	2,42	<0,01	29,4±4,0	1,43	>0,05	2,49	<0,01
Дундаж ор хоног	30,0±1,40	22,9±0,8	4,4	<0,01	22,5±1,99	3,23	<0,01	0,05	<0,05
Хордогтын шинж тэмдэг ҮР-гэлжлэх хугацаа	10,4±0,76	7,64±0,7	2,7	<0,01	15,57±2,06	2,35	<0,02	4,04	<0,01

7. Н. А. Фарбер и др.—Смешанная инфекция вирусами гепатитов А и В. Тер. арх., 1984, 2, 77—80.
8. И. В. Шахгильдян и др.—Сравнительная клинико-биохимическая характеристика инфекционного и сывороточного гепатитов у детей, В кн.; „Вирусные гепатиты“ под ред. Е. С. Кетиладзе, М. 1978, 100—107.
9. Blum, H. E., Vyas G. N.—Non-A, non-B hepatitis: a contemporary assessment, Hematology, 1982. 15, 153—173.
10. Bradley D. W.—The agents of non-A, non-B viral hepatitis, J. virol. methods, 1985. 1. 307—319.
11. Deinhardt, F. Gust, I. D.—Viral hepatitis, Bull. W. H. O. 1982. 60. 661—691.
12. Kane, M. A. et al.—Epidemic non-A, non-B hepatitis in Neal, J. A. M. A., 1984. 252. 3140—3145.
13. Khuroo, M. S.—Study of an epidemic of non-A, non-B hepatitis—Possibility of another human hepatitis virus distinct from post-transfusion non-A, non-B type, Am. J. Med. 1980. 68. 818—824.
14. Kryger, P.—Non-A, non-B hepatitis: Serological, clinical, morphological and prognostic aspects, Liver. 1983. 3. 1976—1998.
15. Kryger, P.—Significance of anti-H.B. IgW in the differential diagnosis of viral hepatitis, J. viral. methods. 1985. 10. 283—290.
16. Perrillo, R. P.—Perspectives on viral hepatitis. 3. The hepatitis viruses: differential diagnosis, Hepatitis information Center, Abbott Laboratories North Chicago. 1983. p. 16.

КЛИНИКО-БИОХИМИЧЕСКАЯ ХАРАКТЕРИСТИКА ОСНОВНЫХ ФОРМ ОСТРЫХ ВИРУСНЫХ ГЕПАТИТОВ, ДИФФЕРЕНЦИРОВАННЫХ ПРИ ПОМОЩИ СПЕЦИФИЧЕСКИХ МАРКЕРОВ

М. Алтанху, П. Нямдава, Г. Хоньчин,
А. Г. Анджапаридзе, Т. Е. Ворожбиева,
Е. Батболд, Ж. Оюунбилэг, Т. Гомбо-
сурэн

У 136 больных вирусным гепатитом, госпитализированных в сентябре-октябре 1983 и 1984 годов в клинической инфекционной больнице города Улан-Батора были определены IgM-анти ВГА по ELISA, HBsAg по РПГА и сделан сравнительный анализ клинико-биохимических показателей. У 44 (32,4%) больных был выявлен IgM-антити ВГА, у 58 (42,6%) больных только HBsAg и у 34 (25%) больных не выявлены маркеры вирусов гепатита А и В. Для дифференциальной диагностики различных форм вирусных гепатитов самыми информативными показателями оказались тимоловая проба, общее количество билирубина их фракции.

Редакцыйн ирсэн 1985. 05.29

К. АНАРГҮЛ (Нийгмийг аюулаас хамгаалах яамны төв эмнэлэг)

МУХАР ОЛГОЙН ХУРЦ ҮРЭВСЭЛТ ӨВЧНИЙ ОНОШИЙН АЛДААНЫ ЗАРИМ АСУУДАЛ

Хэвлэлийн хөндийн мэс заслын өвчний дотор олон тохиолддог мухар олгойн хурц үрэвсэлт өвчний оношийн алдааг судалсан зөвлөлтийн эрдэмтдийн материалд эмч нарын гаргасан оношийн алдаа 39,4%, түүний дотор мэс заслын эмч нарын 7,8%(1,7) жижүүрийн мэс заслын эмч нарынх 29,6%(2) байгаа нь оношийн алдаа 27,0—40,9% хүртэл осөх хандлагатайг (3) харуулж байна.

Мухар олгойн хурц үрэвсэлт өвчний оношийн алдаа манайд ч мэдэгдэхүйц байна. Бидний судалсан мухар олгойн хурц үрэвсэлтэй 1112 өвчтөний 287(25,8%)-д эмнэлэгт хэвтэхээс өмнө оношийн алдаа тохиолдажээ.

Хүснэгт

Мухар олгойн хурц Үрэвслийн оношийн алдаа

№	Хэвтүүлж эмчлүүлэхээр явуулсан онош	бодит тоо	Өвчтөн өнийн насны ялгаа				
			хувь	18—29	30—44	45—55	55-аас дээш
1	Мухар олгойн хурц Үрэвсэл	144	50,1	49	34	47	14
2	Хэвлэлийн хурц үрэвсэл	63	21,9	20	18	25	—
3	Цөсний хүүдийн хурц Үрэвсэл	30	10,4	10	2	15	3
4	Нойр булчирхайн хурц үрэвсэл	15	5,2	1	4	6	4
5	Ходоодны цоорсон шархлаа	9	3,1	4	1	3	1
6	Гэдэсний түгжрэл	20	6,9	5	10	2	3
7	Мухар олгойн архаг Үрэвсэл	6	2,4	2	2	1	1
	БҮГД	287	100,0	91	71	99	26

Өвчтөн эмнэлэгт хэвтэхээс өмнөх үеийн түргэн тусламж, амбулатор болон бусад тасгийн эмч нар мухар олгойн хурц үрэвсэлт өвчнийг оношлосон оношийн алдааг хүснэгт 2-т харуулав.

Хүснэгт 2

Эмнэлэгт хэвтэхээс өмнөх үеийн оношийн алдаа (хувиар)

Мэс заслын тасагт эмчлүүлэхээр явуулсан эмнэлгийн байгууллага	Алдааны хувь
Түргэн тусламж	47,9
Амбулатор	26,7
Бусад тасаг	25,4
БҮГД	100,0

Хүснэгт 2-оос узехэд өвчтөн хэвтэж эмчлүүлэхээс өмнөх оношийн алдааны ихэнхийг түргэн тусламжийн эмч нар гаргажээ.

Оношийн алдааны ихэнх нь мухар олгойн хурц үрэвслийн өвөрмөц явцтай ч холбоотой байдаг байна (4,5).

Клиникийн шинж тэмдэг нь тодорхойгүй, мухар олгойн үрэвсэлт өвчний сэжиг бүхий 57(54,8%) өвчтөнд жижуурийн мэс засалч "мухар олгойн хурц үрэвсэл" онош тавьж, мэс заслын тасагт онош тодруулхаар хэвтүүлсэн 27 өвчтөнд мухар олгойн хурц үрэвсэл гэдгийг батлан хагалгаа хийж, 30 өвчтөний оношийг тодруулж зохих тасагт шилжүүлэн эмчилсэн болно. Хагалгаа хийж авсан 27 мухар олгойн 16 нь улайж үрэвссэн, 8 нь идээлж үрэвссэн, 3 нь үрэвсэгүй байлаа.

Мухар олгойн хурц үрэвслийн эхний үе шатанд мухар олгойн эмгэг морфолог өөрчлөлтөөс хамаарахгүйгээр, клиник шинж тэмдэг тодорхой байдаг нь үрэвслийн процесс зөвхөн мухар олгойд байгаагаар тайлбарлагдана. Өвчний хожуу үе шатанд үрэвслийн процесс мухар олгойгоор зогсохгүй ойр орчмын эрхтэнд нөлөөлж, улмаар олгой үрэвсэж цоорсноос хэвлэлийн гялтангийн

Үрэвслийн шинж тэмдэг илэрч мухар олгойн үрэвслийг оношлоход түвэгтэй байдгаас оношийн алдаа гарч байна.

Зөвлөлтийн эрдэмтдийн тэмдэглэснээр мэс заслын тасагт хэвтсэний дараах оношийн алдаа 1,4—4,8% байгаа бол бидний судлагаанд хамрагдсан 1112 өвчтоний 42(3,7%)-д оношийн алдаа гарчээ.

Хүснэгт 3

Мэс заслын тасагт хэвтсэний дараах оношийн алдаа

Батлагдсан онош	Өвчтоний тоо	Хүйсний ялгаа	
		Эр	Эм
Эмэгтэйчүүдийн өвчин	14	—	14
Шээсний замын өвчин	8	6	2
Ходоодны шархлаат өвчин	1	1	—
Цэсний хүүдийн, нойр булчирхайн хурц	7	4	3
Үрэвсэл	2	2	—
Мухар гэдэсний хавдар	2	2	—
Миккелний цүлхэн	3	2	1
Кронийн өвчин	5	3	2
Мухар гэдэс рүү нарийн гэдэс чихэлдэх	42	20	22
Бүгд			

Оношийн алдаа гарсан үндсэн шалтгаан нь овчтонөөс анамnez дутуу авсан, бодит үзлэг, шинжилгээ хангалтгүй хийсэнтэй холбоотой байлаа.

ДҮГНЭЛТ: 1. Оношийн алдааны шалтгаан нь хэвлэйн хөндийн мэс заслын яаралтай эмгэгийн талаарх эмч нарын мэдлэг хангалтгүй байгаатай холбоотой юм. Алдаанаас урьдчилан сэргийлэхийн тулд эмч нарын мэргэжил мэдлэгийг дээшлүүлэх, өвчтонийт сайн узэж, анамnez гүйцэд авч, боломжтой бүх шинжилгээг хийж чадах чадвартай болгох шаардлагатай байна.

2. Оношийн алдааны зарим тохиолдолд өвчтон эмчид үзүүлэлгүй өөрөө дур мэдэн эмчилгээ хийснээс өвчний клиникийн шинж тэмдгийг бүдгэрүүлж хүндрэлд хүргэж байна.

3. Энэхүү өвчний талаар хөдөлмөрчдөд эмнэлэг гэгээрэл, сурталчилгааны ажлыг өргөн хүрээтэй, эрчимтэй явуулж мухар олгойн хурц үрэвсэлтэй хүмүүсийг цаг тухайд нь ирүүлэхэд туслах ажлыг зөхион байгуулах нь зүйтэй юм.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. У. А. Алексеев, М. М. Мурзанов-Диагностика острого аппендицита и некоторые пути ее улучшения. В кн: Ошибки и трудности в диагностике и лечении острых хирургических заболеваний органов брюшной полости. Саратов, 1973, 26—29.

2. Т. У. Алимов, О. Д. Слободняк-Ошибки в клинической диагностике острого аппендицита. В кн: Труды Уральской конференции хирургов. Пермь, 1971, 223.

3. П. И. Андросов, А. Н. Володин-Ошибки и осложнения при остром аппендиците у лиц молодого возраста. В кн: Труды Уральской конференции хирургов. Пермь, 1971, 118—120.

4. А. К. Арсений-Диагностика острого аппендицита. Кишинев, 1978.

5. Ю. И. Датхаев-Об ошибках в неотложной хирургии живота. В кн: Диагностика и тактика лечения экстрен, заболев. в хирургии, травм. и детской хирургии. Душанбе, 1968, 58—60.

6. В. Ф. Малых, Т. Г. Загребина-Ошибки в диагностике острого аппендицита. В кн: Антибиот. в хирургии, ошибки и ослож. при остром аппенд., новое в хирургии, вопр. краев. патологии. Пермь, 1969, 88.

7. М. М. Мурзанов-Ошибки диагностики острого аппендицита. Дис.канд. Уфа, 1971.

М. ОНГАР (Баян-Өлгий аймгийн нэгдсэн эмнэлэг)

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН АНЕСТЕЗИ-РЕАНИМАЦИЙН ТУСЛАМЖИЙН ХҮРЭЭ

Бид аймгуудын нэгдсэн эмнэлгүүдийн анестези-реанимацийн тусlamжийн одоогийн түвшинг ямар нэг хэмжээгээр тодорхойлох зорилгоор Баян-Өлгий аймгийн нэгдсэн эмнэлгийн анестези-реанимацийн ажлын зохион байгуулалт, үйл ажиллагааг 6 жилээр (1978—1984) авч судлав. Гус эмнэлэг 1978 оноос мэргэжлийн анестезиолог-реаниматолог эмчтэй болж хагалгааны дараах болон хүүхдийн тасгийн эрчимт эмчилгээний өрөөтэйгээр ажиллаад 1982 оноос тасаг болж өргөжин мэргэжлийн эмч, сувилагчтай ажиллаж байна. Энэ тасаг 1983 онд 448 өвчтонийг хүлээн авч 81,1%-д сэхээн амьдруулах эмчилгээ хийжээ. Ерөнхий мэдээ алдуулалтын тоо 6 жилд гурав дахин нэмэгдэж, эндотрахеал мэдээ алдуулалтын эзлэх хувь нь энэ хэмжээгээр осч, 1983 оны байдлаар бүх хагалгааны 27,9%-ийг ерөнхий мэдээ алдуулж хагалгаа хийжээ. Сүүлийн үед 0—15 насны хүүхдийн хагалгааг еронхий мэдээ алдуулалтаар хийж, байгаа ць бүх мэдээ алдуулалтын 1/3 буюу 37,3%-ийг эзлэж байна.

Xүснэгт I

Ерөнхий мэдээ алдуулж хагалгаа хийсэн өвчтонийг нас
хүйсээр ангилах нь

Нас	Хүйс		Бүгд	Хувь
	Эрэгтэй	Эмэгтэй		
0—3	20	14	34	
4—7	33	19	52	37,3
8—15	42	33	75	
16—49	103	117	220	
50—59	11	10	21	62,7
60-аас дээш	17	13	30	
БҮГД ХУВЬ	226 52,3	206 47,7	432	100%

ОШИБКИ В ДИАГНОСТИКЕ ОСТРОГО АППЕНДИЦИТА

К. Анаргүл

Диагностические ошибки при распознавании острого аппендицита наблюдаются до настоящего времени в 27—40,9% случаев. По нашим данным диагностические ошибки острого аппендицита были допущены на догоспитальном этапе у 287(25,8%) из 1112 больных.

Диагностические ошибки на догоспитальном этапе чаще допускались выездными врачами скорой помощи и врачами других стационаров не хирургического профиля. Среди наших больных диагностические ошибки в стационаре допускались у 42 из 1112 больных (3,7%). Допущенные диагностические ошибки при заболевании острым аппендицитом происходят в основном вследствие недостаточно глубоких знаний врачами общей сети.

Редакцид ирсэи 1984. 07. 07.

Ерөнхий мэдээ алдуулалтын чанар жилээс жилийд сайжирч, хэргэлж байгаа арга, төрөл нь олширсоор байна.

Бүх мэдээ алдуулалттай хагалгааны 1/3 буюу 37,7%-ийг яаралтай хагалгаа эзэлж байгаа бөгөөд 1983 онд ерөнхий мэдээ алдуулалттай төловлөгөөт хагалгаа 76,1% болж оссон байна.

Хөдөө сум дундын эмнэлэг, их эмчийн салбарт дуудлагаар очиж хийсэн хагалгааны ерөнхий мэдээ алдуулалтыг судлахад бүх мэдээ алдуулалтын донгөж 0,7%-ийг эзлэж байна. Энэ нь нь 75—300 км зайд байрлаж байгаа сум дундын эмнэлэг, их эмчийн салбарт мэс заслын ба мэдээ алдуулалтын нарийн мэргэжлийн тусламжийн хүртэмж хангалтгүй, нөлөө талаар наркозын зөврүийн аппаратгүй байгаатай холбоотой байна.

Хүснэгт 2

Мэдээ алдуулалтын төрөл

Он	эндогра-хеал мэдээ алдуулалт	маскаар мэдээ ал-дуулалт	судсаар мэдээ ал-дуулалт	хавсарсан мэдээ ал-дуулалт	перидурал мэдээ ал-дуулалт	Бүгд
1978	17	2	5	11		35
1979	14	11	8	9		42
1980	45	7	5	3		60
1981	41	10	13	5	3	72
1982	71	12	16	10	1	110
1983	57	26	17	2	11	113
Бүгд	245	68	64	40	15	432
Хувь	57,7	15,7	14,8	9,3	3,5	100%

Хүснэгт 3

Төлөвлөгөөт ба яаралтай хагалгааны ҮЗҮҮЛЭЛТ

Ялгавар		1978	1979	1980	1981	1982	1983	Бүгд
Яаралтай	тоо хувь	19 54,39	20 47,6	12 20,0	26 36,1	59 53,6	27 23,9	163 37,7
Төлөв-төгөөт	тоо хувь	16 45,7	22 52,4	48 80,0	46 63,9	51 46,4	86 76,1	269 62,3
Бүгд		35	42	60	72	110	113	100%

Дээрх судалгаанаас дүгнэлт хийж үзэхэд:

1. Баян-Өлгий аймгийн нэгдсэн эмнэлгийн анестези-реанимацийн тусламж сүүлийн жилүүдэд өргөжиж ерөнхий мэдээ алдуулалттай хийх хагалгаа, мэдээ алдуулалтын тоо төрөл олширч, тусгай анестези-реанимацийн тасагтай болсон нь мэс засалч, анестезиолог-реаниматолог өмчийн ажлын хүрээ өргөсч, тусламжийн чанар сайжирч байгааг харуулж байна.

2. Хүүхдийн хагалгааг ерөнхий мэдээ алдуулалттай хийж байгаа нь цаашид аймгийн төвд хүүхдийн анестезиолог-реаниматолог өмчтэй болох, анестези-реанимацийн тасагт тусгай мэргэжлийн өмч жижүүр хийх шаардлагатай болж байна.

3. Сум дундын эмнэлэг, их эмчийн салбарт ерөнхий мэдээ алдуулж хагалгаа хийх нь хангандгүй (дөнгөж 0,7%) байгаад зохиц дүгнэлт хийж сум дундын эмнэлэгт мэс заслын тусламж, ерөнхий мэдээ алдуулалтыг өргөжүүлэх нь хөдөөгийн хөдөлмөрчдөд эмнэлгийн нарийн мэргэжлийн тусламжийг уламжлалтой ойртуулах зорилтыг биелүүлэхэд томоохон түлхэц болох юм.

4. Аnestезиолог-реаниматологийн албаны зохион байгуулалт, үйл ажиллагаа хөдөөгийн эмнэлгүүдэд хоцрогдож байгааг онцлон анхаарах хэрэгтэй юм.

Ихэнх аймаг аnestези-реанимацийн тасаггүй, зөвхөн эрчимт эмчилгээний өрөө ажиллуулж байгаа боловч тэр нь мэргэжлийн сувилагчгүй, аnestезиолог-реаниматологийн нэгдсэн журам тогтоогүй, тайлагнах систем боловсронгуй бус байгааг цаашид анхаарч тодорхой арга хэмжээ авах хэрэгтэй байна.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. Г. М. Цанава — "Аnestезиология и реаниматология" 1977, 5, 25—27.
2. Л. Ф. Косоногов — "Аnestезиология и реаниматология" 1984, I, 59—61.

АНЕСТЕЗИОЛОГИ-РЕАНИМАТОЛОГИЧЕСКАЯ ПОМОЦИ В ОБЪЕДИНЁННОЙ БОЛЬНИЦЕ БАЯН- УЛЬГЕЙСКОГО АЙМАКА

М. Оигар

В последние годы возрастает объем аnestезиологической и реаниматологической помощи и удельный вес общего обезболивания по отношению всему количеству операций. В объединённой больнице Баян-Ульгейского аймака они увеличились в 8,5—27,9% в 1978—1983 г.

Нами использованы все наркотические и другие лекарственные препараты, имеющиеся в нашей стране. В 1983 г в отделении аnestези-реанимации находились 448 больных, и эффективность лечения которых составила 81,1%. За последние 6 лет под общим обезболиванием выполнены 37,7% всех экстеренных операций.

Из всех плановых операций под эндотрахеальным наркозом оперировано 57 (50,4%), под масочным—26 (23%), под внутривенным—17 (15%), под комбинированным—13 (11,6%) больных с различными хирургическими заболеваниями.

Наши данные показывают, что наличие крупного аnestезиологического реанимационного отделения в объединённой больнице аймака позволяет оказывать сельским жителям все виды специализированной аnestезиологической и реаниматологической помощи на современном уровне.

Редакций ирсэн 1984. 10. 06

Д. ОТГОНБААТАР, Г. УУЖЭЭ (Эрүүл ахуй, халдвэр, нян судлалын улсын институт)
(Бактериологийн төв лаборатори)

САЛМОНЕЛЛ ТИФИМУРИУМЫГ СУДЛАХ АСУУДАЛД

Сүүлийн жилийн эдээд салмонеллийн өвчлөл бага наасны хүүхдийн дунд ихсэж яз бүрийн амьтан, хүнсний бүтээгдэхүүн, малын тэжээл зэрэг гадаад орчноос илрэх ийлдэс судлалын хүрээний тэрээр эрс нэмэгдэж байна.

Эрдэмтдийн ажиглалтаас үзэхэд гэдэсний хямрад, хурц хордлогст халбар нь ихэвчлэн ахуй хавьтлын замаар халдварлах, хоол хүнсэнд уржиж өвчлүүлэх, хоолны хордлогын хэлбэртэй

адил болохыг нотолж байна. Хүн амьтанд илэрч байгаа салмонеллийн хүрээний дэлгэрч байгаад судалгаа хийхэд яз бурийн оронд ихэнхдээ 4 үндсэн ийлдэс судлалын булэг ялгагдаж, ялгасан осгөврийн 35—70 орчим хувийг салмонелл тифимириум зонхилж байна. Салмонеллийн шалтгаан судлалд *S. typhimurium*, *S. derby*, *S. Hadar*, *S. Enteritidis* зэрэг 20 гаруй ийлдэс хүрээ зонхилж байна. (1, 2, 4).

Эдгээрийн дотроос салмонелл тифимириум ээр уусгэгдэх овчлийн тоо түргэн тархадтай осч байгаа бөгөөд халдварт судлалын онцлогтой, эмнэлгийн дотоод халдварын хэв шинж, тодорхой уүрэгтэй болж байна. Уг халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээ хангатгүйгээс овчин тархаж эмнэлгийн дотоод халдвар болон хувирдаг. Энэ нь эмнэл зүйн илрэлтэй халдварын явц бүхий бактер ялгаруулдгаас илүү аюултай (6).

Эмнэлгийн дотоод халдварыг эмнэлгийн похцэлд тэсвэртэй омог уусгэдэг бөгөөд энэхүү омгуудаар ууссан халдварт нь ахуй хавьтальны замаар зөвхөн хүмүүсийн дунд дэлгэрдэг бөгөөд бага наасны хүүхдэд өвчлөл хүнд явцтай, антибиотикт дээд зэргийн тэсвэртэй болдог. ЗХУ-ын судлаачид эмнэлгийн дотоод халдварт уусгэдэг салмонелл тифимириумын тодорхой омгууд нь дээрх шинжээс гадна феликсокеллоугийн залгигддаггүй, гадаад орчинд тэсвэртэй, хулгананд хоруу чанар султай, биохимиийн идэвхээр зарим омгууд нь лизинийг карбоксилгүйжүүлэх шинжээ алдсан, ийлдэс судлалын шинжээр биеийн 05 эсрэгтерөгчтэй наалдах урвал өгдөггүй омгууд байгааг тэмдэглэж байна (3).

Манай оронд 1980 оноос салмонелл тифимириум ээр уусгэгдсэн эмнэлгийн дотоод халдварын хэв шинж тохиолдож байна (5). Бид 1983 оноос зарим аймаг хотод гарсан салмонелл тифимириумын халдварт судлалын байдалд дүгнэлт хийж, ялгатсан омгийн биологийн болон ийлдэс судлалын зарим шинжийг судлах оролдлого хийв. Судалгааг эпидемиологийн задлан шинжилгээ хийж, сүүлийн 3 жилийн тайлангийн материал, уусгэгчийг лабораторийн шинжилгээний ердийн аргаар судлав. Салмонелл тифимириумын халдварт 1984 онд 10,0 хүн амд 2,6% болж Архангай,Өвөрхангай, Хөвсгөл аймаг, Дархан Улаанбаатар хотод эмнэлгийн дотоод халдварын хэлбэрээр бүртгэгдэж гарсан байна.

Голомтуудаас ялгасан омгийг сулахад биохимиийн болон ийлдэс судлалын шинжээр 100% тохирч, лизин карбоксилгүйжүүлээгүй омог дайралдаагүй ба 3—4% нь 05 оношийн ийлдэсд наалдах урвал өгсөнгүй. Антибиотикт мэдрэг чанарыг цаасан дискийн шингээх аргаар 6 антибиотикт судлахад гентомицинээс бусад тэсвэртэй байлаа. 8—30 хоног хэвтэж эмчлүүлэгчдийн 69,2% нь өөр өвчний оноштой ирээд халдварт авч 10,3% нь уушгины урэсэлтэй, 20,5% нь энтероколит болон шалтгаангүй суулгалтын оноштой байлаа. 2—3 удаагийн давтан шинжилгээгээр тэднээс өвчин уусгэгч дахин илэрч эмчилгээний үр дүн эдгэрэх хугацаа удааширч, ор хоног 30—45 байлаа.

Салмонелл тифимириум оноштой хүмүүсийн 60 орчим хувь нь хүнд явцтай, 30 хувь нь дунд зэргийн, үлдсэн хувь нь хөнгөн явцтай байв. Өвчлөлийн эпидемиологийг судлахад халдварт ахуй хавьталь, нян тээгчийн замаар халдварлаж, хүлээн авахаас эхлээд хүүхдийн сэхээн амьдруулах, эрчимт эмчилгээний тасаг дамжиж байгаа нь шинжилгээгээр нотлогдов.

Эмнэлгийн ажилчдаас 125 хүнд шинжилгээ хийхэд Архангай аймгийн хүүхдийн сэхээн-амьдруулах тасгийн 2 сувилагч нян тээгч болох нь илрэв.

ДҮГНЭЛГ 1. Аймаг хотод гарч байгаа эмнэлгийн дотоод халдварт салмонелл тифимуриумээр үүсгэгдэж байна.

2. Эмнэлгийн дотоод халдварт үүсгэж байгаа салмонелл тифимуриум нь антибиотикт мэдрэг бөгөөд гентомицинд тэсвэртэй байгаа нь судлаачдынхтай тохирч байна.

3. Хэвтэж эмчлүүлэгсийн 62,2% нь оноштой ирээд улмаар халдвартай байна. Шалтгаангүйгээр суулгалтын 25,5% нь салмонелл тифимуриумаар үүсгэгдэж байгааг тогтоов.

4. Гарч болзошгүй халдвартын үүсгэгчийг тогтоож, урьдчилан сэргийлэх арга хэмжээг яаралтай авч мэдээлэл, оношлогоо, халдварт судлалын судалгаат зааврын дагуу хийж эх уурхайт олж тогтоох шаардлагатай юм.

5. Салмонелл тифимуриумын клиник эпидемиологийн зүй тогтолыг нарийвчлан холбож судлах пь чухал байна.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. А. Ф. Блюгер, И. Н. Новицкий, З. Ф. Теребкова — Салмонеллэз, Рига, 1975
2. В. А. Килессо, Е. И. Выдрина и др — Распространение отдельных серотипов салмонелл на ряде территорий Советского Союза Акт. вои. эпид. Вып. 2. М, 1970, 129.
3. В. А. Килессо, Л. Ф. Колобовой — В кн: Материалы всесоюзного симпозиума по фагатипированию возбудителей кишечных инфекций, Тбилисса. 1968.
4. Н. И. Лебедев — Салмонеллэзы, Минск, 1980.
5. С. И. Трембоковая, Л. В. Королева, Г. И. Хохлова, — Об этиологии респираторной синдрома при салмонеллезе у детей. Педиатрия, М, 1981.
6. Л. В. Фелскова и др.— Особенности внутрибольничного салмонеллэза у детей. Педиатрия, 1980, 3.62—63.
7. Г. Уужээ, Г. Пүрэв, Г. Санжмятав, С. Хишигт, Ч. Цэндээхүү—БНМАУ дахь салмонеллийн шалтгаан судлалын асуудалд. Анагаах ухаан, 1983, 31—36.

К ВОПРОСУ ИЗУЧЕНИЯ САЛМОНЕЛЛА ТИФИМУРИУМА

Д. Отгон-батор, Г. Уже

В результате исследования нами установлено, что 69,2% больных доставляются в больницу с диагнозами, не связанными с салмонеллезной инфекцией. Ввиду этого только у 20,5 больных обнаруживаются салмонелл тифимуриум.

Редакцид ирсэн 1984. 04. 20

РЭЖЛИЙН ЗЭВЛӨГӨӨ, ЛЕКЦ, ТОЙМ МГ

Г. ЛХАГВАЖАВ, Л. ГАНБОЛД, Д. НЭРГҮЙ (Улсын клиникин төв эмнэлэг)
(Улсын нэгдсэн тусгай эмнэлэг)

ЭГМИЙН ДООРХИ ВЕНИЙГ СЭТГҮҮРДЭХ, ТҮҮНИЙ ХҮНДРЭЛЭЭС СЭРГИЙЛЭХ

Манай орны хот, хөдөөгийн эмнэлгүүдэд төвийн венийг сэтгүүрдэх аргыг суулийн жилүүдэд өргөн хэрэглэх боллоо.

Сэхээн амьдруулах, эрчимт эмчилгээ хийх үед их хэмжээний цус, шингэн сэлбэх, хучил шулт, давс ус, цусны бүлэгнэх системийн гүнзгий хямраалыг богино хугацаанд засах, цусны эргэлтийн системийн зарим нэг үзүүлэлтийг тодорхойлох (төвийн венийн даралт хэмжих гэх мэт), биохимиин шинжилгээнд олон дахин дус авах, зүрхэнд цахилгаан сэдээгч хэрэглэхэд төвийн венийг сэтгүүрдэх шаардлага гарна. Учир нь дээрх зорилгоор захын судсыг сэтгүүрдэхэд бэрхшээл, хүндрэл тохиолдог.

Энэ зорилгоор төвийн аль ч венийг сэтгүүрдэж болох боловч, эгмийн доорхи венийг сэтгүүрдэх нь (1952 онд анх Ацванис хэрэглэсэн) түгээмэл арга болжээ. Эгмийн доорхи вений судас анатомын байрлалын хувьд тохиромжтой, харьцаангуй будуун (насанда хүрсэн хүний судасны диаметр 12—25 мм), цусны урсгалын хурд бусад хэсгээс илүү байдаг тул булэн (тромб) үүсдэггүй сайн талтай. Нэгээ талаар нэгэнт сэтгүүрдсэний дараа өвчтөний судсыг олон дахин хатгахгүй, гар, хөлийн хөдөлгөөнийг чөлөөтэй байлгах ба асаргаа, сувилгааг үлэмж хөнгөвчилнэ. Эгэм орчмын зөвлөн эдийн

урэвсэл, цусны бүлэгнэлтийн гүнзгий хямралтай өвчтөнд хэрэглэдэггүй.

Эгмийн доорхи венийг сэтгүүрдэхэд дараах багаж, хэрэгсэлийг урьдчилан бэлтгэсэн байна. Үүнд:

1. Судас хатгах ариутгасан бүдүүй зүү буюу Селдингериийн зүү

2. Ариутгасан сэтгүүрүүд. (Сэтгүүрийн урт 15—18 см, гадна диаметр 1—1,8 мм байвал зохино).

3. Металл буюу поли хлорвинил хөтлөгч (хөтлөгчийн урт сэтгүүрийн уртаас 2,5—3,5 дахин их байна)

4. 10 мм-ийн багтаамжтай ширшид зүү

5. Хайч, скальпель зүү баригч, торгон утас, арьсны зүү

6. Спирт, иод, 0,25%—0,5%-ийн новокайны уусмал

7. Ариутгасан материал, лейкопластырь

Эгмийн доорхи венийг сэтгүүрдэхэд асептик, антисептикийн дүрмийт нарийн чанд сахина. Эмч хагалгаа хийх гэж байгаа мэт гарва угааж, эгэм орчмын талбайг сайтар ариутгаж, ариутгасан материалаар хулдаж тусгаарлана. Их хэмжээний цус, шингэн алдсан өвчтөний хөл талыг өндөр байрлуулна. Энэ үйлдлийг ихэвчлэн хэсгийн мэдээ алдуулалтаар хийх

боловч бага насны хүүхэд, сэтгэл санааны хямралтай өвчтөнд ерөнхий мэдээ алдуулалтаар

хийх нь зүйтэй. Сэтгүүрийг зүүн талын судсанд тавихад лимфийн судас гэмтэж болох учир ихэвчлэн баруун талд тавьдаг.

Эгмийн доорхи венийг хатгах цэгүүд олон байдаг боловч ихэнхдээ дараах цэгүүдээс хийдэг.

1. Achanias - 'ийн' цэг. Эгмийг З хуваасны дотор талд, эгмээс 1 см доорхи цэг


2. Wilson - ийн цэг. Эгмийн дунд шугамаар эгмээс доош 1 см орчим зайд орших цэг.

3. Giles - ийн цэг. Овчүүнээс гадагш 2 см, эгмийн доор 1 см зайд уулзах цэг

4. woffa-ийн цэг. Эгмийн дээрээс хатгах цэг

Зураг 1.

Эгмийн доорхи венийг сэтгүүрдэх цэгүүд



Эгмийн доорхи венийг сэтгүүрдэх 2 арга байдаг.

1. Том хөндийтэй зүүгээр хатгаж, дотуур нь сэтгүүрдэх

2. Сельдингериийн аргаар хотлогч хэрэглэж сэтгүүрдэх

Сэтгүүрийг арчлах

Эгмийн дэорхи венийн судсанд тавьсан сэтгүүрийг хүндрэл гаралгүй удаан хугацаагаар ашиглах нь түүнийг хэрээр арчилснаас ихээхэн хамаарна. Үүний тулд:

1. Сэтгүүрийн орчмыг өдөр бүр ариутгах уусмалаар сайтар цэвэрлэж, боолтыг сольж байх.

2. Шингэн юулэх эмчилгээний үед дуслын системийг 24 цагаас илүү хэрэглэхгүй байх.

3. Сэтгүүрийг 4—6 цагийн зайтай 1: 1000-ын гепарины уусмалаар угааж байх, харин засварлах бүрийд гепарины уусмал 2—3 мл хийж, тусгайлан ариутгаж бэлтгэсэн бөглөөгөөр бөглоно. Ихэнх судлаачид сэтгүүрийг 7—14 хоногийн хэрэглэхгүй хэрэглэхийг зөвлөдөг боловч нягт, нямбай арчилж чадвал 1—2 сар хүртэл хугацаагаар хэрэглэж болно.

Манай хот, хөдөөгийн эмнэлгүүдэд өргөн хэрэглэж байгаа дээрх аргын үед янз бүрийн хүндрэл тохиолдож болзошгүй учраас этмийн доорхи венийг сэтгүүрдэх үед гарах хүндрэлээс урьдчилан сэргийлэх талаар эмч, эмнэлгийн дунд мэргэжилтнүүд сайн мэдэж, болгоомжтой хандаж байх нь зүйтэй.

Эрдэмтдийн судалгаагаар хүндрэлийн тохиолдол янз бүр байна. Зөвлөлийн судлаач А. П. Магомедов, В. Н. Родионов (1981 он) нарын судалгаагаар 4,9%, М. С. Маргулис, В. Б. Савченко (1980 он) нарынхаар 2,8% байхад Г. А. Рябов, Glaris нар 6—9% хүртэл хүндрэл тохиолдож болох тухай мэдээлжээ,

Эгмийн доорхи венийг сэтгүүрдэх үед гарах хүндрэлийг 3 ангилаа.

1. Судас хатгах үед гарах хүндрэл

2. Сэтгүүрдэх үед гарах хүндрэл

3. Сэтгүүр судсанд удаан хугацаагаар байснаас гарах хүндрэл

1. СУДАС ХАТГАХ ҮЕД ГАРАХ ХҮНДРЭЛ

а) Эгмийн доорхи артерийг ташаарч хатгах

Энэ хүндрэл М. С. Маргумис, А. Г. Магомедов нарын судалгаагаар 0,3—1,1% тохиолдож байна. Хэрэв артерийн судас ташаарч хатгасан бол үүнийг зүрх-судасны дутагдал, цус их алдсан өвчтөнд оношлоход бэрхшээлтэй байдаг. Учир нь хатгах үед зүүний нүхээр тодийлөн их дараалттай цус гардаггүй. Артерийн судас ташаарч хатгасан үед арьсандор цус хурна. Хэрэв судсыг цээжний гялтантай давхар хатгавал цээжний хөндийд цус хуралдах тул яаралтай хагалгаа хийхээс өөр аргагүй болно.

б) Цээжний гялтан хальсыг хатгах (пневмоторокс)

Дээрх судлаачдынхаар энэ хүндрэл 0,3—2% тохиолдоно.

Цээжний гялтан хатгасан үед цээжээр овдөх, амьсгаадах, тогшиход тэр талдаа хэнтэргэн дуу сонсдох зэрэг шинж тэмдэг гардаг.

Хэрэв эдгээр шинж тэмдэг илэрвэл яаралтай гэрэлд харж, оношиг тодруулан арга хэмжээ авах хэрэгтэй.

в) Судсаар хий сорогдох

Амьсгал авах үед дээд хөндий венийн дараалт эрс багасдаг.

Энэ үед судсаар хий сорогдож болзошгүй юм. Судсаар хий сорогдсон шинж тэмдэг илэрвэл, үйлдлийг зогсоож зүрх-судас, амьсгалын үйл ажиллагааг дэмжих эмчилгээг яаралтай эхлэнэ.

Энэ хүндрэлээс урьдчилан сэргийлэхийн тулд хэсгийн мэдээ алдуулж зүүнээс шприцээ салгаж, судсанд сэтгүүр хийх үедээ өвчтөнөөс амьсгалахгүй бага зэрэг дүлж байхыг шаардах буюу зохиомол амьсгалтай үед амьсгалын замын дараалтыг ихэсгэнэ.

Мөн өвчтөний хөл талыг Тренделенбургийн байрлалд оруулж, хатгах үед зүүгээ усмыал бүхий шприцтэй холбосон байх нь энэ хүндрэлээс урьдчилан сэргийлнэ.

г) Мөрний мэдрэлийн сүлжээ гэмтэх

Энэ нь маш ховор тохиолдох боловч, тохиолдвол гарны хэвийн ажиллагааг алдагдуулж болох талтай. А. Г. Магомедев 5200 удаа хатгахад энэ хүндрэл 4 (0,07%) тохиолдож байсан тухай мэдээлсэн байна. Эдгээрээс гадна эгмийн доорхийн гялтаныг хатгахад лимфийн судас, цагаан могоерсон хоолой, бамбай булчирхай гэмтэх тохиолдол байдаг.

2. СЭТГҮҮРДЭХ ҮЕД ГАРАХ ХҮНДРЭЛ

а) Сэтгүүрийг гүн тавьснаас гарах хүндрэл

Судсанд сэтгүүрийг хэтэрхий гүн тавьснаас сэтгүүрийн үзүүр баруун ховдолд орж зүрхний хэм алдагдах хүндрэл гарч болохоос гадна сэтгүүр буюу хөтлөгчийн үзүүрээр зүрхний ханыг цоо хатгасан тухай хэвлэлд тэмдэглэсэн байна. А. Г. Магомедев, В. Н. Родионов нар (1981 он) эгмийн доорхийн венийг сэтгүүрдэх үед зүрхны ханыг цоолсон хүндрэл 2 удаа тохиолдож, үхлээр төгссөнийг мэдээлжээ. Ялангуяа энэ хүндрэл зүрхний булчингийн үрэвсэл (миокардит), сорвижсон (кардиосклероз) үед тохиолдоно.

Зарим үед сэтгүүр, хөтлөгчийн үзүүрээр венийн ханыг нэвт хатгах хүндрэл тохиолддог. Элгээр хүндрэлээс урьдчилан сэргийлэхэд сэтгүүрийг судсанд 7—10 см-ээс илүүгүй оруулах ба заавал үзүүртээ туялзууртай металл буюу полихлорвиалил хөтлөгч хэрэглэх нь зүйтэй.

б) Сэтгүүр тасарч алдрах

Энэ хүндрэл ховор тохиолдох боловч зарим үед судсанд хатгасан зүүгээ салгалгүй сэтгүүрийг гэдрэг татсанаас зүүний хурц үзүүрт сэтгүүрийн хагас оттлогдон үлдэж болно. Ийм учраас том хөндийтэй зүү-

гээр хатгаж, дотуур нь сэтгүүрдэх үед онцгой анхаарах нь зүйтэй. Үнээс гадна сэтгүүр судсан дотор зангирах, нугарах хүндрэл нь хэтэрхий уян хатан, зөвлөн сэтгүүр хэрэглэсэнээс болох ба зангиран сэтгүүрийг хагалгаа хийж аваахаас оөр аргагүй болно.

3. СЭТГҮҮР СУДСАНД УДААН БАЙСНААС ГАРАХ ХҮНДРЭЛ

а) Венийн судасны үрэвсэл
Хэвлэлд мэдээлснээр энэ хүндрэл 0,3—0,5% тохиолдож байна.

Сэтгүүрдсний дараах 3—5 хоногт ихэвчлэн тохиолдох ба энэ үед өгмийн дээд талд улайж хатуурах, зарим үед гүрээний судас дагаж улайж хавдах, биенийн халуун нэмэгдэх зэрэг шинэ тэмдэг илрэнэ.

Хэрэв дээрх шинж тэмдгүүд илрвэл сэтгүүрийг авч, антибиотик эмчилгээ хийхийн хамт,

хавдаж улайсан газар гепарини буюу Вишневскийн тосоор боноо.

б) Сэтгүүр бөглөрөх

Сэтгүүрийг зохих ёсоор арчлаалгүй, удаан хугацаагаар байлгаснаас цусны бүлэнгээр бөглөрөх хүндрэл тохиолддог. Иймд сэтгүүр бөглөрсөн эсэхийг тогтмол шалгаж, дээр дурдсан аргаар сэтгүүрийг угааж байх хэрэгтэй. Мөн сэтгүүр орчмын зөвлөн эд үрэвсэн идээлэх хүндрэл тохиолддог. Ийм учраас сэтгүүр тавих буюу тавысны дараах үед халдварт хамгааллын дэглэмийг нарийн чанд сахих шаардлагатай.

Дээр дурдсан хүндрэлүүдээс урьдчилан сэргийлж, сэтгүүрийг сайтар арчилик чадвал эгмийн доорхи венийг сэтгүүрдэх арга нь олон төрлийн хүнд овчин, мгэгийн үеийн сэхээн амьдрзулах эрчимт эмчилгээнд хэрэглэж болох сайн арга юм.

Редакцид ирсэн 1985—01—04

Р. НЯМАА (Анагаах ухааны дээд сургууль)

НҮДНИЙ ӨВЧЛӨЛИЙН ДИНАМИКИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ

Манай оронд эрүүлийг хамгаалах талаар авч байгаа байнтыц арга хэмжээний үрээр хүмүүсийн эрүүл мэнд дээшилж нүдний өвчлөл, үүсэх шалтгаан, бутэцийн хувьд өөрчлөлт гарлаа.

О. Б. Гейликманы 1939 онд бичсэн „Монголд нүдний хараагүй болох шалтгаан“ гэсэн судалгааны өгүүлэлд хараагүй болох шалтгааны дотор нэгдүгээрт эвэрлэг бүрхэвчийн үүл, цагаа, хөөрдүгэарт тэмбүүгийн гаралтай нүдний өвчинүүд, гуравдугаарт глауком өвчин эзэлж байна тэжээ (1). Н. Н. Назаров 1951 онд бичсэн өгүүлэлдээ монголд хараагүй болгох шалтгаанд дээрх

өвчинүүдийг дурдаад, харин глаукомын эзлэх хувь оссон гэсэн байв (2).

Тэр үеэс хойш манай оронц нүдний өвчлөл, хараагүй болох шалтгаан өөрчлөгджээ. Нам, засгаас авсан арга хэмжээний үр дүнд цагаан цэцэг, тэмбүү, хүйтэн, сахуу зэрэг өвчинөөс хараагүй болох явдал бүрмөсөн устаж сүрьеэгийн гаралтай нүдний өвчлөл эрс цөөрөв.

Нүдний тусламжийн түвшинг илтгэх гол үзүүлэлтүүд нь нүдний өвчлөл ерөнхийдөө буурч, түүний бүтэц өөрчлөгдэх, хараагүйн коэффициент багасан түүний дотор эдгэрч болох хараа алдалтын хувь харьцаангуй буурах зэргээр то-

дор хойлогддог. Үүнийг судлахын тулд бид архивын материалыаас Үлсын клиникийн төв эмнэлгийн нүдний тасагт хэвтэж эмчлүүлэгсийн өвчлөлийн бүтцийг судлан үзээд 30-аад оныхтой харьцуулахад мэдэгдэхүйц өөр байна. Хэрэв 30-аад оны үед эвэрлэгийн үүл сорив 28%, трахом 20,1%, болорын будэгшил 7,9%, нүдний хүйтэн 1,5% тус тус эзлэж байсан бол одоо хэвтэж эмчлүүлэгсийн өвчлөлийн бүтцэд болорын будэгшил 20,6%, глауком 17%, эвэрлэгийн урэвсэл 14%, осол гэмтэл 11%-ийг тус тус эзлэж байна. Үүнээс үзэхэд трахом, нүдний хүйтэн мэтийн нийгмийн халдварт өвчин устаж, харин катаракт болон глаукомын эзлэх хувь харьцангуй осох хандлагатай боллоо. Энэ нь дундаж наслалт уртасан, зүрх судас, бодисын солилцооны овчний нөлөөтэй холбо отой юм. Нүдний осол гэмтэл гол төлөв бага наасны хүүхдэд илүү тохиолдож байна.

Амбулаторт ирж эмчлүүлэгчдийн өвчлөлийн бүтцэд нэгэн адил өөрчлөлт орсон байна. 30-аад онд конъюнктивит 40%, трахом 8%, эвэрлэгийн үүл цагаа 4% эзлэж байсан бол одоо төрөл бүрийн конъюнктивитын эзлэх хувь, багасч, трахом буртохиолдохгүй болж, харин хараа засах шил тааруулах, катаракт, глауком зэрэг өвчиний учир үзүүлэх нь олширлоо.

Дээрх үзүүлэлтээс үзэхэд амбулаториор эмчлүүлэгсийн дотор салт ба эвэрлэгийн өвчний хувь хэмжээ багасч трахом мэтийн өвчин тохиолдохгүй болж, харааны хугарлын гажиг засах, шил тааруулах явдал нэмэгдэв.

Үүний зэрэгцээ бид хараагүй болох шалтгааныг судлав. Одоо дэлхийд 10-аас илүү сая хараагүйчүүд байна, гэж ДЭХБИИ мэдээлэлд дурдсан байдаг. Хөгжил буурай орнуудад хараа алдах шалтгааны дотор хурц

ба архаг өвчин, трахом, кератомаляци, ксерофталм, онхочеркоз гэх мэтийн өвчин зонхиилж байхад хөгжингүй орнуудад гол төлөв миопи, катаракт, глауком, удамшлын ба төрөлхийн өвчин эзлэж байна.

О. Б. Гейликманы судалгаанаас үзэхэд дээхэн үед хараагүй болоход эвэрлэгийн үүл сорви, нийгмийн халдварт өвчин, глауком, трахом байсан бол одоо бидний судалгаа, ажиглалтаар хараагүй болох шалтгаанд глауком, харааны мэдрэл ба торлог бурхэвчийн өвчин төрөлхийн эмгэг шалтгаан эзлэж байна. Орчин үед хөгжингүй орнуудад глауком өвчин зонхилох хувийг эзлэх болжээ.

Ийм учраас нүдний эмч нарын анхаарлыг татах энэ өвчинтэй тэмцэх дэс дараатай, эрчимтэй арга хэмжээ авах шаардлагатай байна. Гол нь урьдчилан сэргийлэх идэвхтэй аргыг хэрэтлэн өвчинийг далд болон эрт үед илрүүлэн диспансерийн хяналтанд авч эмчлэх нь чухал юм. Цаашдаа глаукомын кабинетыг улмаар үлсын чанартай диспансер болгон өргөжүүлэх, аймаг дундны нүдний тасаг болон глаукомын кабинет байгуулан, урьдчилан сэргийлэх ажиллагааг эрчимтэй явуулах нь зүйтэй байна.

Нэг нүдний хараагүй болох нь харах ажиллагааг хязгаарлан хүний эрүүл мэнд амьдралд муугаар нөлөөлдөг. Үүний гол шалтгааныг нүдний осол гэмтэл эзэлж байна. Нүдний осол гэмтлээс урьчилан сэргийлэхийн тулд хүүхэд багачууд, эцэг, эх, багши, хүмүүжүүлэгчдэд осол гэмтлийн хор холбогдлыг тайлбарлан таниулах, бага наасны хүүхдийн асаргаа сувилгааг сайжруулах, нүдний гэрэл хугалах гажгийг эрт илрүүлэх, шилээр засах, хялрыг засах, харааны эрүүл ахуйд онцгой анхаарах нь чухал байна. Насанд хүрэгчдийн хувьд юуны өмнө глауком өвч-

жөөс' урьдчилан сэргийлэх, үүний тулд эрт илрүүлэх диспан-

серийн хяналтыг сайжруулах явдал нэн чухал байна.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. О. Б. Гейликман — Слепота в МНР и её причины В. О. 1939.
2. Н. Н. Назаров — „Опыт изучения заболеваемости глазными болезнями в МНР“ М. 1951.

Редакцид ирсэн 1985—12—02

Л. ЭРДЭНЭБАЯР, С. БЯМБАСҮРЭН (Эрүүлийг хамгаалах яам)
(Сэтгэл мэдрэлийн өвчнийг эмчлэх улсын клиникийн эмнэлэг)

АРХИНЫ СОЛИОРЛЫГ ОНОШЛОХ, ЭМЧЛЭХ АСУУДАЛД

Архины хор хүний мэдрэл сэтгэхүйг гэмтээдгийн нэг жишээ нь архины солиорлууд илрэх явдал юм. Архины солиорол архаг архичдын 20 орчим хувьд нь илэрдэг.

Архины солиорлын хэлбэрүүдийг архины цагаан солио, архины сонголын хий үзэгдэл, хардлагат дэмийрэл, Корсаковын солиорол, архины танихрад, архины ухаан тэнэгрэл, архины шалтгаант унадаг өвчин гэж ангилацаг.

Архины солиорол нь шартах үед болон архины хуурамч доң завсарласны дараа ихэвчлэн илэрдэг. Архины солиорол нь хэд хоногоос хэдэн сараар ургэлжилж болно. Архины солиорлын 80 орчим хувь нь цагаан солионы хэлбэрээр илэрдэг тул энэ хэлбэрэйн солиорлыг тухайлсан авч үзэх шаардлагатай юм.

Архины цагаан солио (белая горячка)-ны эмнэл зүйн үндсэн шинжийн нэг нь ухамсарт ухаан дэмийрэн балартах явдал мон.

Архийг удаан хугацаанд хэтрүүлэн хэрэглээд түр завсарласан буюу шартсан үед цагаан солио илэрдэг. Цагаан солионы эмнэл зүйг солиорлын өмнөх үе, солиорлын шинж тэмдэг тодрох үе, солиорлын дараах үе гэсэн 3 үе шатаар авч үздэг.

Солиорлын өмнөх үед өвч-

төн тайван биш болж, шөнө элдэв муу муухай зүүд зүүдлэн түүнээс айн цочин сэргж, түгшүүрлэн улмаар үе үе шалтгаангүйгээр айдас бий болж дотныхоо хүнийг хардаж сэргдэх болно. Үүний зэрэгцээ зүрх судас, амьсгалын эрхтэний үйл ажиллагаа хямарч, хордлогын байдал бий болно. Үүний дараа солиорлын шинж тэмдэг тодрох үе эхлэнэ. Өвчтөнд харааны сонсголын хүрэлцэхүйн мэдрэхүйн зэрэг хий үзэгдлүүд бий болж хорхой шавьж, могоид баригдах, хэлхээ яс, хохимой толгой элдэв янзын араатан амьтан үзэгдэж, чихэнд нь өөрийг нь доромжилж муучилсан уг сонсогдсон биеийг нь идох, хазах, ороох, боох баглах мэт хүртэхүйн хий үзэгдлүүдэд авшагдана.

Эдгээр хийхоосон юмс үзэгдлийг архины цагаан солиотой өвчтон үнэн зүйл, гэж итгэн айн сандарч, байх газраа олж ядан наашаа, цаашаа гүйх, хашгирах, хамгаалах, зугатаах, довтлох мэт ургэлжийн хөдөлгөөнд орж дошгирно. Архины цагаан солио олонх тохиолдолд оройн цагаар эхэлж, шенийн цагаар ширүүсдэг.

Солиорлын дараах үед өвчтөн сүл дорой байдалтай болно. Энэ үед өвчтон 40—41° хүртэл халуурч, цусны даралт бууран бүх бие нь хөлрөн, үе

уе татах, мэдээгүй бие засч зарим үед комын байдалд орж, амьсгал, зүрх судасны амин чухал төвийн үйл ажиллагаа нь сэргэхгүй нас барах ч уе тохиолддог.

Иймээс архины цагаан солиотой өвчтөнг солиорлын өмнөх үед нь оношилж шаардлагатай арга хэмжээт цаг алдалгүй авч амь насыг нь аврах хэрэгтэй юм. Хоёр жишээ авч үзье.

I. Өвчтон Ш. 45 настай, дээд боловсролтой, архийг 25 настайгаас хэрэглэж эхэлсэн. Сүүлийн 5 жийл архийг их хэмжээгээр удаан хугацаанд хэрэглэх болсон. Хамт олон, эхнэр хүүхэд нь архи уулгахгүй гэж олон янзаар тэмцэн боловч Ш. архийг уусаар байсан Мартын 8-ны оройн архидалтаас хойш нойр нь онгоц болж элдэв янзын аймшигт зүүд зүүдлэн, бие нь тавгүйтэж, үе уе шалтгаангүй айдас төрж түүнээсээ аиж тайван биш байх болсноо мэргэжлийн эмчид оөрөө үзүүлж эмнэлгийн тусlamж авч архинаас гарах эмчилгээ хийлгэж дээрх зовиургүй эдгэжээ. Энэ хүний онош нь: Архины цагаан солионы солиорлын омнө уе байв.

II. Өвчтон Д. 48 настай, бага боловсролтой, архийг 15 жил уусан. Архины эмчилгээ 2 удаа хийлгээн боловч муу үөхдийн нөлөөнд автан архийг дахин ууж ухаангүй эмнэлэгт иржээ. Өвчтөнг үзэхээр ороход өвчтон хөнжлөөрөө толгойгоо ороон палатынхаа буланд хагас суусан байв. Хөнжлийг нь татахад муухай орилон хана туурга руу заан аллаа, намайг аллаа та минь гэж янз бүрийн хамгаалах үйлдэл хийн тасалгаан дотор үсчин, тэр тэр аддуу мал дайрлаа гэж орилон амь тэмцэн хөнжилгэйгээ нөцөлдөно. Өвчтоний хамаг биеийн хөлс гарч, гар хөл нь салгалан чичирч үе үе дальдчин гарч гүйх гэнэ. Эмчилгээний дараа дээрх шинж арилсан.

Цагаан солио өвчний эмчилгээ

Цагаан солио өвчтэй хүмүүст цаг тухайд нь эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэхгүй бол солиорлын эрхээр оөртөө болон нийгэмд аюултай хэрэг үйлдэх, эсвэл тэдний амин чухал эрхтэнүүдийн үйл ажиллагаа алдагдан улмаар нас барж болдог. Иймд цагаан солио өвчтэй хүмүүсийг сэтгэл мэдрэлийн өвчнийг эмчлэх эмнэлэг буюу наркологийн тасагт, хөдөө орон нутагт мэдрэлийн тасагт яаралтай хэвтүүлэн эрчимт эмчилгээ хийх шаардлагатай.

Нийгэмд аюултай хэрэг үйлдэхээс сэргийлж өвчтонийг цаг минут бүр хатуу хяналт, хараанд байлгана.

Цагаан солио өвчний үндсэн эмчилгээ бол амь нас алдахад хүргэдэг амин чухал эрхтэнүүдийн оөрчлөгдсөн үйл ажиллагааг хэвийн болгох, архины хордлогыг тайлах, солиорлын шинж тэмдэг болох сэтгэц эмгэгийн байдлыг арилгахад чиглэгдсэн эм тариануудыг венийн судсанд хийх иж бүрэн эрчимт эмчилгээ байх ёстой.

Цагаан солио өвчний үед өвчтөний зүрх судас, уушги, тархи, элэг бөөрний үйл ажиллагаа алдагддаг учраас амин чухал эрхтэнүүдийн оөрчлөгдсөн үйл ажиллагааг хэвийн болгохол чиглэгдсэн эмчилгээг хамгаас түрүүнд хийх шаардлагатай.

Цагаан солио өвчний үед хамгийн хүнд гэмтдэг эд, эрхтэний нэг бол зүрх-судасны систем юм. Зүрх-судасны оөрчлөгдсөн үйл ажиллагааг хэвийн болгох эмчилгээт сонгож авахад анхаарах зүйл бол arterийн судасны даралтын байдал юм.

Архины хордлогоос ууссан зүрхний булчингийн агших чанар буурах, бие махбодын шингэн алдагдах, судасны хурц дутагдал үүсэх, муужран унах тохиолдлуудад arterийн судасны даралт буурдаг.

Зүрхний үйл ажиллагааны дутагдалтай холбогдсон arter-

рын судасны даралт буурахад зүрхний авианууд будгэрэх, арьсны венийн цусны эргэлт зогсонги байдалд шилжих, судасны цохилт олшрох, захын эрхтэнд цианоз үүсэх шинжүүд илэрнэ. Энэ тохиолдолд строфантин, коргликон зэрэг зүрхний үйл ажиллагааг сайжруулах эм хэрэглэнэ. Бие маҳбодын шингэн алдагдсанаас үүссэн arterийн судасны даралт буурах үед цусны даралт буурах, их хөлрөх, ам цангах, шээс бага ялгарах шинжүүд ажиглагдана. Энэ үед бие маҳбодоор эргэж байгаа цусны хэмжээг ихэсгэхэд чиглэгдсэн эмчилгээ хийнэ. Энэ зорилгоор 5%-ийн глюкозын уусмал болон гемодез эсвэл реополиглюкинг венийн судсандаа дуслаар хийнэ.

Судасны хурц дутагдлаас үүссэн arterийн судасны даралт буурах үед цусны даралт гэнэт буурах, арьс цайх, зүрхний авианууд будгэрэх, судасны цохилт олшрон будэг болох шинжүүд илэрнэ. Ийм тохиолдолд судасны хүчдэлийг ихэсгэх үйлчилгээтэй эм болох 0,1%-ийн 1—2 мл адерналины уусмалыг 5%-ийн 100 мл глюкозын уусмалтай хамт венийн судсандаа минутанд 30—60 дуслын хурдтай хийнэ. Муужран унах үед 0,1%-ийн 0,5 мл адреналины уусмалыг эсвэл 0,2%-ийн 0,5 мл норадренолины уусмалыг венийн судсандаа хийнэ. Муужран унах үед хоногт 50—150 мг преднизолонг венийн судсандаа, эсвэл 75—125 мг гидрокортизонг булчинд хийж болно.

Цагаан солиогийн үед үүсдэг амь насанд аюултай нэг өөрчлөлт бол уушгини хаван юм. Уушгини хавагнах үед хөөсөрхөг цэр ихээр ялгарах, уушгини бүх гадаргаар хэржигнуур сонсогдох шинжүүд илэрнэ. Энэ тохиолдолд зүрхний үйл ажиллагааг сайжруулах эм (страфантин, коргликон) хэрэглэхээс гадна венийн судсандаа 100—150 мг кокорбаксилоз, 10%-ын

10 мл хлорид кальци, 20—30 мл димедрол, 2,4%-ын 5—10 мл эуфиллины уусмал (маш удаанаар), 100—150 мг гидрокортизонг 5%-ын 100 мл глюкозын уусмалын хамт, 30—60 мг преднизолонг тус тус тарина.

Цагаан солиогийн үед илэрдэг, амь алдах аюулд хүргэдэг, яаралтай тусламж шааарддаг өөр нэгэн өөрчлөлт бол тархи хаван юм. Тархи хавагнах үед огиулах, бөөлжих, толгой овдех, ухаан нойрмоглон балартах, нүдний алим чичирхийлэх, амьсгал өөрчлөгдөх, цусны эргэлт хямрах, халуурах зэрэг шинж үүсдэг.

Уушти ба тархи хавагнахын эмгэг жамын үндэс бол цусны осмос даралт буурах, бие маҳбод дахь ус ба ионуудын өөр хоорондын тэнцвэр алдагдах үзэгдэл юм. Иймд уушги ба тархи хавантай тэмцэхийн тулд цусны осмос даралтыг ихэсгэх ба бөөрөнд натрийн ион буцан шимэгдэхийг багасгахад чиглэгдсэн эмчилгээ хийх шаардлагатай.

Цусны осмос даралтыг ихэсгэх зорилгоор 0,85%-иас илүү их концентрацттай уусмалуудаас хэрэглэх хэрэгтэй. Үүний тулд глюкоз, эуфиллин, мочевин, манитол, хүхэр хүчлийн магнезийн уусмалуудаас тариагаар хэрэглэх нь зүйтэй.

Уушгини ба тархи хаванга бууруулахын тулд 2,4%-ын 10 мл, эсвэл 24%-ын 1 мл эуфиллины уусмалыг 40%-ын 20 мл глюкозын уусмалтай холиод венийн судсандаа удаан тарьдаг. Эуфиллин бол зүрхний агшилтыг сайжруулах, цусны даралт бууруулах, судас эргөсгөх, тархи ба бөөрний цусны эргэлтийг сайжруулах, шээс ялгаруулах, хаван багасгах ба тархи хаваны дотоод даралтыг бууруулах үйлчилгээг бие маҳбодод үзүүлдэг зүрх, судасны бүлгийн эм юм.

Бөөрний үйл ажиллагааны өөрчлөлтгүйгээр тархи хавагнасан тохиолдолд биеийн 1 кг

жинд 1 грамм хуурай бодис ногдохдоор бодож 30%-ын мочевины уусмалаас эсвэл 1 кг жинд 1—1,5 грамм хуурай бодисоор бодож 20%-ын маниитолын уусмалаас венийн судсандаа дуслаар хийнэ. Шээний шинжилгээнд өөрчлөлт илэрсэн үед тархины хаванг бууруулах зорилгоор бөөрөнд натрийн ионы буцан шимэгдэхийг багасгаж шээс ялгарахыг ихэсгэдэг үйлчилгээтэй эм болох гипотиазад, лазикс (фурасемид)-ын аль нэгийг алдьостерон гормоны эсрэг нөлөөт эм болох спиролактон (вероширин)-тай хавсран хэрэглэх шаардлагатай. Ингэснээр бие махбод дахь ус-ионы тэнцвэр хадгалагддаг.

Цагаан солиогийн үед элэгний үйл ажиллагаа хямран эдэг томрох ба хөндүүрлэх, биеийн энд тэнд судасны цацраг хэмээх шинж үсэх, алга умайх, арьс ба салст бүрхэвчүүд шарлах, гэдэс ба ходоодны ажиллагаа хямрах, цусанд билирубин ихсэх, протеин бууралт, глобулин ихсэх өөрчлөлтүүд илэрдэг. Элэгний үйл ажиллагаа өөрчлөгдсөн үед концентраци ихтэй глюкозын уусмал (биеийн 1 кг жинд 1 грамм хуурай глюкоз ногдох)-ыг инсулини (4 грамм глюкозд 1 нэгж инсулини оногдох)-тай хамт, мөн түүнчлэн витамин С (5%-ын 20 мл), В-тийн торлийн витаминууд, кокорбаксилоз, метионин (хоногт 0,25—0,5 грамм, 3—4 удаа уух), спирепар (хоногт 2—3 мл, 1 удаа булчинд) преднизолон, гидрокортизон (хоногт биеийн 1 кг жинд 2—4 мг ногдох) хэрэглэдэг.

Цагаан солио өвчий бол нэг талаас архины солилдооны завсрлын хорт бүтээгдэхүүнүүд, ногое талаас архины шалтгаант бие махбодын өөрчлөлт, бодисын солилдооны хямралаас үүссэн хорт бодисуудын нөлөөгөөр бий болсон хордлогын солиорол юм. Иймд цагаан солиог эмчлэх шалтгааны эмчил-

гээ нь бие махбодод үүссэн хордлогыг тайлахад чиглэгддэг. Архины хордлогыг тайлж архины солиорлоос гаргахын тулд шээс ялгаруулах үйлчилгээтэй эмтэй хамт эсвэл бие махбодод үүссэн бодисын солилдооны завсрлын бүтээгдэхүүн ба хорт бодисуудтай химиин урвалд орж тэдгээрийг саармагжуулдаг үйлчилгээтэй эм бэлдмэлүүд болох унитол, метилен хөх, тиосульфат натри, инсулини аль нэгийг, эсвэл бие махбодод үүссэн хорт бодисуудтай холбогдон саармаг нэгдэл болж биеэс гадагшиладаг эмийн бэлдмэл болох гемодезыг, эсвэл биеэс гадагшилах замаар цусан дахь хорт бодисын хэмжээг бууруулах үйлчилгээг бие махбодод үзүүлдэг физиологийн шингэн бүхий олон бодисын найрлагатай уусмал болох Л. В. Штерев, В. М. Неженцев нарын санаачилсан стандарт шингэнг хэрэглэдэг.

Энэ уусмалын найрлаганд физиологийн уусмал 800 мл, 40%-ын глюкоз=150 мл, 1%-ын хлорид кали 50 мл, 10%-ын глюконат кальци 10 мл, кордиамин—2 мл, инсулин—8 ед, 6%-ын витамин В₁—5 мл, 6%-ын витамин В₆—2 мл, витамин С ба РР аль аль нь 5 мл, седуксин 10 мг ордог.

Архины хордлогыг тайлах зорилгоор В. П. Кутин, Г. В. Кутин (1983) нарын санаачилсан физиологийн уусмал бүхий олон бодисын найрлагатай № 1, № 2 уусмалуудын аль нэгийг цагаан солио өвчний үед венийн судсандаа дуслаар хийдэг. Эдгээр уусмалын бүтцийг авч үзье.

Уусмал №—1-ийн найрлаганд физиологийн уусмал 800 мл, 40%-ын глюкозын уусмал 100 мл, 1%-ийн хлорид кали 50 мл, 10%-ийн глюконат кальцийн уусмал 10 мл, кордиамин 2 мл, кокорбаксилоз 100 мг, инсулин 6—8 нэгж;

Уусмал №—2-ын найрлаганд физиологийн уусмал 500 мл,

кокорбаксилоз 100 мг, кордамин 2 мл, 5%-ийн аскорбины хүчил 5—10 мл, 1%-ийн никотины хүчил 5—10 мл, 6%-ийн тиамины уусмал 2,5—5 мл, рибофлавины уусмал 2—3 мл, 5%-ын пиридоксина уусмал 2—5 мл, инсулин 6—8 нэгж тус тус ордог.

Цагаан солио өвчний уед амин чухал эрхтэнүүдийн өөрчлөгдсөн үйл ажиллагааг хэвийн болгох, архины хордлогыг тайлах эмчилгээ хийхээс гадна солиорлын илрэл болох сэтгэц эмгэгийн шинж тэмдгүүдийг арилгах зорилгоор сэтгэц нөлөөт болон бусад эм бэлдмэлийг хэрэглэдэг.

Цагаан солиогийн уед илэрдэг хий үзэгдэл, дэмийрэл, айдас, түгшүүр болон хөдөлгөөний дошгиролыг намдаах байрны өөрчлөлтийг хэвийн болгох зорилгоор тайвшруулах үйлчилгээтэй нейролептикуудаас харэглэдэг.

Цагаан солио өвчний хүнд хэлбэрийн уед амин чухал эрхтэнүүдийн үйл ажиллагаа хүндээр гэмтдэг тул нейролептикийг ялангуяа фенотиазини гаралтай эмуудийг хэрэглэхэд онцгой анхаарах хэрэгтэй. Фенотиазини гаралтай нейролептикууд (аминизан, тизерцин) бол артерийн судасны даралтыг огцом бууруулах, судасны ханын нэвчимтгий чанарыг ихэсгэж тархинд хаван үүсгэх, тархины цусны эргэлтийн өөрчлөлтийг улам гүнзгийрүүлэх үйлчилгээтэйгээс гадна элэгний үйл ажиллагаанд сорог нөлөө үзүүлдэг. Иймд зурх судас, тархи элэгний үйл ажиллагаа зонхилон өөрчлөгддэг. Цагаан солиогийн хүнд хэлбэрүүдийн уед илэрдэг айдас, түгшүүр, хөдөлгөөний дошгирол, нойрны өөрчлөлтийг намдаах зорилгоор фенотиазини гаралтай нейролептик болох аминазин ба тизерцин хэрэглэхийг хориглож оронд нь зурх, судас, тархи элгэнд эмгэг төрүүлэгч нөлөө багатай

эм, бутирофеноны гаралтай нейролептик болох 0,5-ын 1—2 мл галоперидолыг димедролтой хамт 2—4 удаа булчинд эсвэл галоперидолыг булчинд, седуксенг венийн судсанд тарих нь зүйтэй.

Нойр хүрэхгүй болох, цагаан солио өвчний өмнөх үе, цагаан солио өвчний шинж тэмдэг тодрох үе, уналт таталтын шинж тэмдэг бүхий цагаан солио өвчний уед олонтоо хэрэглэдэг эмийн бэлдмэлүүдийн нэг нь Поповын уусмал юм.

Энэ уусмалыг бэлтгэхийн тулд 0,3—0,4 гр нунтаг фенобарбиталыг 96%-ийн 20—40 мл спиртэнд уусгаад 100—150 мл ус нэмдэг. Хэрэв фенобарбитал нь шахмалаар байвал түүнийг сайтар нунтаглах хэрэгтэй. Фенобарбитал (люминал) бол их тархины хөдөлгөөний төвийн сэргийг бууруулах, мэдрэл тайвшруулах, нойрсуулах, булчингийн таталтыг зогсоох нөлөөг бие, мэдрэл, сэтгэцэд үзүүлдэг нойрсуулах бүлгийн эм bogood спиртэнд түргэн уусдаг юм. Поповын уусмалыг бэлдэнгүүг өвчтөнд уулгадаг. Үүнтэй нэгэн зэрэг 2 мл кордиаминг арьсан дор тарина. Энэ уусмал нь архитай ойролцоо бүтэцтэй учир өвчтөн түүнийг дуртай ууж 6—8 цаг бөх унтдаг. Поповын уусмалыг 2—3 одор хэрэглэхэд нойр хүрэхгүй бол оронд нь нойрсуулах үйлчилгээтэй өөр эм хэрэглэх нь зүйтэй.

Цагаан солио өвчний хүнд хэлбэрүүдийн уед эмгэг жамын эмчилгээний зорилгоор витамин В-гийн булэг, витамин С болон бусад витамины их тунгаар хэрэглэдэг.

Цагаан солио өвчнөөр өвчилж байсан архинаас гарах эмчилгээ хийгдээгүй хүмүүсийн ихэнх нь өөрийн өвчинг танин мэдэх чадваргүй, өвчиндээ хандах өөрийн шүүмжлэл алдагдснаас болж архийг давтан хэрэглэж өмнөхөөсөө хүнд хэлбэрийн солиоролд орж, за-

рим нь нас барах тохиолдол байдаг. Архинаас гарах эмчилгээ хийлгэлгүй дахин архины солиоролд автсан хүмүүсийн зарим нь нийгэмд аюултай хэрэг үйлддэг байна.

Иймээс цагаан солио туссан өвчтөнүүдийн эрүүл мэнд болон нийгмийн эрх ашгийн үүднээс солиорлыг эмчилсний дараа үргэлжлүүлэн архинаас гаргах өвөрмөгц эмчилгээг хийх хэрэгтэй.

Архинаас гаргах өвөрмөгц эмчилгээтэй хамт биеийн ерөнхий эсэргүүцлийг сайжруулах, солиорлын дараа үүссэн сульдлын байдлаас гаргах зорилгоор инсулин (бага тунгаар), глютамины хүчил, метионин,

аминалон зэрэг амин хүчлүүд, фосфор, мышъяк, төмрийн бэлдмэлүүд, пантокрин, зуун настын ханд, шилдэг бие зэрэг биологийн стимулятор, седуксен зэрэг сэргээх үйлчилгээ ихтэй транквилизатор-стимулятор хэрэглэнэ.

Архины солио туссан өвчтөнүүдэд архинаас гаргах эмчилгээ хийсний дараа тэднийг сэтгэл мэдрэлийн диспансер буюу наркологийн кабинетын хяналтанд шилжүүлэн батжуулах эмчилгээ хийнэ. Өвчин дахисан тохиолдолд өвчтонг эмнэлэгт яаралтай хэвтүүлэн давтан эмчилгээ хийнэ.

Редакцийн 1975—12—16.

С. ЦООДОЛ. (Эрүүл ахуй, халдварт, иян судлалын улсын институт)

ОНОШИЙН ҮНЭНИЙ АСУУДАЛ, ОНОШЛОГООНЫ АЛДААНЫ ТАНИН МЭДЭХҮЙН ШАЛТГААН

Оношийн үнэний асуудал бол эмчилгээний практикийн хувьд төдийгүй нийгмийн чухал ач холбогдолтой юм.

Оношлогооны чанарыг дээшлүүлэхэд юуны омноо оношийн алдааны хэмжээг бууруулах, үүний тулд алдаа гарахад хүргэж буй шалтгааныг судлах асуудал онолын талаас ч, практикийн талаас ч тэргүүн зөргийн ач холбогдолтой юм. Оношийн алдааны шалтгааныг судлах асуудал эмч эрдэмтдийн анхаарлыг татсаар байгаа боловч түүнийг тодорхойлох нэгдсэн чиг баримтлал тогтоогүй байна. Зарим судлаачид оношлогооны алдааны шалтгааныг өвчнөөс, өвчтөнөөс, эмчээс, гадаад нөхцөл байдлаас гэсэн дөрвөн үндсэн бүлэгт хувааж байгаа боловч үүнийг олонх эрдэмтэд алдааны шалтгааныг түүний гарал үүсэлтэй хольж хутгаж байгаа явдал гэж үзэж байна.

Иймээс оношлогооны алдааг танин мэдэхүйн өргөн дүн шинжилгээгээр авч үзэх асуудал зүй ёсоор дэвшигдэж байна.

Мэдлэгийн үнэн буюу худал болох нь бидний ухамсраас ангид, түүнээс шалтгаалахгүй оршиж байгаа юмс үзэгдлийн жинхэнэ бодит байдал, уг юмс үзэгдлийн бидний тархинд бүрэлдэн тогтсон „хуулбар“ хоёр хоорондоо тохирох эсэх тухай асуудал юм.

Оношлогооны гол зорилгобол ерөнхий утгаараа өвчин, өвчтөний үнэн бодит байдлыг эмч тархи толгойдоо үнэн зөвөөр хуулан буулгах явдал мөн. Иймээс оношлогооны алдааны шалтгааныг судалгааны обьектоос эрж хайх өөрөөр хэлбэл алдааны шалтгааныг овчтөн, түүний өвчинд тохох ямарч үндэсгүй болох нь тодорхой.

— Өвчиний нарийн төвөгтэй шинж тэмдэггүй буюу гажиг

явл, өвчтоний мартамхай, анхааралгүй байдал зэрэг нь оношийг зөв тогтооход бэрхшээл учруулах нь маргаангүй боловч эдгээрийг алдаа гарах шалтгаан гэж үзэж болохгүй.

Алдааны шалтгаан бол танин мэдэх үйл явцын нарийн төвөгтэй, эсрэг тэсрэг шинж, оношлогооны тухайн шатанд танин мэдэхүйн өрөөсгөл хязгаарлагдмаа байдалд оршино гэж үздэг. Орчин үед оношийн алдааны шалтгааныг объектив, субъектив гэж хоёр хувааж байна.

Оношийн алдааны объектив шалтгаан гэдэгт анагаах ухааны хөгжлийн орчин үеийн төвшинд зарим өвчин гүйцэд судлагдаагүй, хүний зарим эрхтэн системийг хурдан хугацаанд шууд үзэж, шинжлэх арга боловсронгүй болоогүйтэй холбоотой байна. Тухайлбал хорт хавдар, сэтгэц гэм судлалын нэлээд өвчиний эрт, зөв оношлох явдал хамгийн туршигатай эмчийн хувьд ч нэн төвогтэй хэвээр байна. Цаашилбал аливаа өвчин хүн бурд онцлог шинж тэмдгээр илрэх олон хувилбар нь онош тогтооход ноцтой бэрхшээл учруулж байна. Гэвч анагаах ухааны хогжил нь эдгээр объектив шалтгааныг улам бур багасгаж цаашид бүрэн арилгах боломжтойг түүхэн туршлага харуулж байна.

Объектив шалтгаан нь алдаанд зайлшгүй хургэх ёстой мэт ойлгож болохгүй. Оношлогоо нь танин мэдэх үйл ажиллагаа болохын хувьд оношийн алдааны танин мэдэхүйн субъектийн үйл ажиллагаагаар зайлшгүй дамжин илрэх учраас дээрх объектив шалтгаан нь алдаа гарахад бололцоо төдий холбогдолт юм.

Иймээс оношийн алдаа гарахад субъектив шалтгаан шийдвэрлэх нөлеөтэй гэж үзэх бөгөөд субъектив шалтгааны дараах хэлбэрүүд байна. Үүнд:

Эмч өвчтонийг анхааралгүй,

яаруу, өнгөц, дутуу үзэж, шинжлэх явдал хамгийн түгээмэл байдал. Үзлэг судалгааг дутуу хийснээс өвчтоний биений байдлын тухай баримт бүрэн бус, өрөөсгөл шичжтэй болох бөгөөд овчний мөн чанарын талаар үнэн зөв дүгнэлт гарах үндэслэл болж чадахгүй, тавьсан онош алдаатай болохад хурдыг байна.

Өвчтонд илэрсэн янз бурийн шинж тэмдгийг буруу үйэлэх, харгалзан үзэхгүй байх, уялдаа холбоог нь эс тооцох нь оношийн алдааны түгээмэл шалтгаан болдогийг туршлататай эмч нар тэмдэглэж байна. Алдаанд хургэж буй эдгээр шалтгааныг гаргахгүй байхын тулд, нэгдүгээрт: өвчтонийг үзэж, шинжлэхдээ тодорхой арга зүй, дэс дараалал, бүх талыг хамрах зарчмыг хатуу баримтлах, хоёрдугаарт: өвчтоний биений байдлын талаарх мэдээ, баримтад бодитой хандах, өвчиний шинж тэмдгийн ач холбогдлыг үнэлэхдээ хийсвэрлэхгүй байх шаардлагага ханах явдал юм.

Өвчтонийг онгөц дутуу үзэж шинжилснээс гарах алдааны зэрэгцээ эмч нарын мэдлэг, дадлага дутагдсанаас шалтгаалан гарах алдаа ихээхэн хувийг эзэлдэг байна. Эмч нарын онолын бэлтгэл, орчин үеийн клиникин мэдлэгийн дулимаг байдал нь оношийн алдааны нэн чухал субъектив шалтгаан юм. Судлаачид үзэхдээ орчин үеийн клиник анагаах ухааны оношлох боломж, түүнийг нийт эмч нарын практикт хэрэгжүүлж байгаа байдлын хооронд ихээхэн зөрөө гарч байна. Тухайлбал эмч нар лабораторийн шинжилгээ, аппарат хэрэгслэлийн тусламжаар авсан мэдээлэлд дүгнэлт эгөх чадвар дутагдалтайгаас тэдгээр нь үр дүнгээ өгөхгүй байна гэж тэмдэглэж байна. Үнтэй холбоотой эмч бэлтгэх, давтан бэлтгэх, сургалтын чанарыг сайжруулах, нийт эмч парт мэргэ-

жилдээ есөх, шинжлэх ухааны ололтыг түргэн эзэмших явдлыг байнгын хэрэгцээ гэж үздэг, хумуужил олгох, эмнэлгийн хамт оны дотор мэргэжлийн хоцрогдол, үхширмэл байдлыг үл тэвчих уур амьстгал, бутээлч эрэл хайгуул хийх, шинжлэх ухааны шинэхэн олслт бүрийг эзэмших эрмэлзэл бий болгох нь онцгой ач холбогдолтой болж байна.

Эмчийн сэтгэлгээний системгүй, эмч журамгүй, чиглэсэн тодорхий зорилгогүй байдал, сэтгэлгээний логик хууль зүйт зөрчих явдал нь оношийн алдааны бас нэгэн чухал субъектив шалтгаан юм. Баримтуудыг яаруу нэгтгэн дүгнэх, тохиолдлын шинжтэй онгоц шинж тэмдэгт тулгуурлан онош тавих зэрэг хэлбэрээр илэрч байна. Энэ алдаанаас сэргийлэхийн тулд юуны өмнө эмч бурт өвчтөнийг үзэх аргачлалыг дадлага зуршил болгон эзэмшүүлэх, өөрийн дүгнэлтэд шүүмжлэлтэй ханддаг чадвар тогтоох нь чухал юм.

Түүнчлэн үйл явдлын болж онгорсон цаг хугацааны дарааллаас шалтгаант холбооны дүгнэлтийг яарч хийх тухайлбал өвчтөн, түүвий төрөл садны ярианд эмч хэт автагдааж хэдийд юу идсэн, ямар өвчнөөр овчилж байсан гэх мэтийг өрөөсгөлоер үнэлэн, өөрийн мэдлэг, үзлэгийн үед илэрсэн бодит баримт зэргийг үл хайран дүгнэлт хийснээс сисийн алдаа гарна.

Энэ хэлбэрийн алдаанаас сэргийлэхийн тулд үзлэгийн үед эмч өөрөө нөхцөл байдлын эзэн байж, өвчтонийг өөрийн толөвлөгөөний дагуу үзэж шинжилж, өвчтонийг уганд анхаарлтай хандах, хэт автагдахгүй байхыг зөв хөсөлж, дүгнэлтийг хүний угээр биш өөрийн мэдлэг дадлага, баримт материалиын бодит байдалд тулгуурлан гаргах, өвчний гажиг хэлбэр, хүп бүрт өвөрмөц байдлаар илрдэгийг тооцон үзэх,

үзэгдэл юмын хоорондын харилцан холбоо, шалтгаацлыг тодорхойлох логикийн энгийн (адилтгах, ялгах) гэх мэт шаардлагыг хэрэглэж чаддаг байх ёстой.

Оношлогооны алдаанд дун шинжилгээ хийж, бодит үнэнд хүрэх замын ямар үе шатанд, яагаад эмчийн сэтгэлгээ хазайхад хүрэв гэдгийг тогтоож арилгахад онош зөв тавигдаж байгаа эсэхийг тогтоох шалггуур боловсруулж практикт хэрэглэх нь нэн чухал юм.

Энэ чиглэлээр орчин үед амбулаторийн оношийг больниц, клиникийн оноштой, килиничийн оношийг эмгэг анатомийн задлан шинжилгээний оноштой тохицуулан шалгаж байгаа бөгөөд энэ нь харьцангуй шинжтэй боловч ихээхэн үр дүнтэй юм. Эмнэлгүүдийн дэргэд эмгэг анатомын алба байгуулж, клиник эмгэг анатомын бага хурал явуулж байгаа нь манай эрүүлийг хамгаалахын нэг олслт юм. Задлан шинжилгээ нь орчин үеийн похдолд оношийн үнэнийг хэмжих хамгийн найдвартай арга боловч цорын ганц хэмжүүр гэж үзэж болохгүй.

Цаашилбал оношийн үнэн зөвийг өвчтоний эмчилгээний үр дүнгээр хэмжих санал дэвшигдэж байна. Эмнэлгийн байгууллагын ажлын чанарын хэмжүүр нь хүн амд үзүүлж буй эмчлэн сэргийлэх тусламжийн үр ашгийн дээшлэлт мөн боловч ерөнхий утгаар авч үзвэл оношлогооны чанар сайжирсныг эмнэлгийн үйлчилгээний хангамж дээшилж, эмчилгээний шинэ арга нэвтрэх эргээс гарч буй үр дүнгээс ялан салгахад бэрхшээлтэй болох юм. Оношийг зөв тавьсан эсэхээс эмчилгээний үр дун нь харьцангуй хамаарах төдийгүй зарим өвчнийг гүйцэд оношлосон боловч эмчилгээ аваходаа муу байдаг зэргийг харгалзан үзвэл эмчилгээний үр дүнт дан ганц онцлоготой холбон үзэх

нь учир дутагдалтай. Иймээс энэ хэмжүүрийг туйлын өвөрмоц эмчилгээ шаардах болон мэс заслын өвчинүүдийн үед хэрэглэх нь тохиromжтой юм. Түүчинлэн өвчтөний эмгэгийн динамик хөгжилд эмнэл зүйн ажиглалт хийх аргаар анхны оношийн үнэн зөвийг үнэлэх нэг шалгуур болгон үзэж байна.

Ийнхүү оношлогооны үнэн

зөвийг хэмжих төгс боловсрон-гүй хэмжүүр бий болоогүй хэдий боловч дээрх практик шалгугуруудын аль нэгийг тохиromжтой хэлбэрээр нь сонгон авч оношлогооны чанарыг үнэлж дүгнэж байх нь оношийн алдааг бууруулах, эмчилгээний чанар үр дүнг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Редакцид ирсэн 1986—1—28

Г. ЭНХДОЛГОР, В. КОРДАЧ, П. МАРТАСЕК

ПОРФИРИНЫ ӨВЧНИЙ ОНОШЛОГОО ЭМЧИЛГЭЭ

Порфири бол гемийн синтезд оролцдот ферментүүдийн sogo-гоос шалтгаалж үүсдэг өвчин. Энэ sogog нь ихэвчлэн төрөлхийн байдаг бөгөөд хамгийн олон тохиолдох (*Porphyruria cutanea tarda*) хэлбэр нь ихэвчлэн одмомл байдаг.

Порфиринууд нь гем болон B_{12} витамин, цитохром, хлорофил зэргийн найрлагад ордог амьдралын нэн чухал хэрэгцээт бодис юм. Порфирины солицдоо нь бие махбодод үйлчилдэг хүчилтөрөгчийн солицдоотой шууд холбоотой явагдах учраас амьдралын үндсэн нөхцөлийн нэг болдог. Хэвийн нөхцөлд бие махбодод порфирины нийлэгжилт маш нарийн зохицуулагдаж маш бага хэмжээгээр ялгаран гарч байдаг. Харин порфири өвчний үед порфиринууд нэлээд их хэмжээгээр хуримтлагдан ялгардаг (6, 8). Порфири өвчнийг синтезийн буюу хуримтлалын гол төвүүдийнх нь дагуу эритропоэтийн, эритрогепаталийн, гепаталийн гэж гурав ангилна. Үнээс эхний хоёр хэлбэр нь ховор тохиолдоно. Гепаталийн хэлбэр нь харьцаангуй элбэг тохиолдох бөгөөд дотор нь почмог, архаг гэж ангилж болно (5).

1. Бодисын солицдооны тэрэлхийн архаг гажиг клиникийн шинж тэмдгээр илрэхийг цочмог порфири гэнэ. Өвчин цочмог илрэхэд дараах хүчин зүйл нөлөөлне. Үүнд: сэтгэл санааны болон биеийн хүчиний хямрал, халдварт өвчнөөр овчлөх, мэс засал хийлгэх, жирэмслэх зэрэг болно. Порфири өвчин үүсгэх бодис цөөнгүй. Тухайлбал: согтууруулах ундаа, сульфонамидын бүлгийн эмүүд, барбитуратууд, хлордиазепоксид, глутетимиid, гризоофулловин, хидантониол, мепробамат, эстрогенууд, жирэмслэлтээс хамгаалах эмүүд, хүнд металл мөнгө, тугалга, цайр, алколоид карга гэх мэт.

Цочмог порфири ихэвчлэн 20—30 насны хүмүүст (ялангуяа эмэгтэйчүүдэд) олонтаа тохиолдоно. Өвчин маш одон янзын эмнэл зүйн шинж тэмдэг, тэдгээрийн олон төрлийн хослолоор илэрдэг учраас оношийг буруу тавих гол шалтгаан болдог. Цочмог порфири, өвчний илрэх үндсэн шинж тэмдгүүдийг хэдэн бүлэг болгоно.

— Хэвлэлий хүчтэй өвдөх, дотор муухайрах, бөөлжих, отгон хатах буюу хааяа шингэрнэ. Хэвлэлийн өвдөлт нь цочмог буюу байнга хүчтэй өвдөж улмаар хэдэн цаг, өдрөөр ч үргэлжилнэ.

Саа, саажилт байдлаар ходолгөөний өөрчлөлт тэнцвэр алдагдах, улаан хоолой зангирах, юм хоёр харагдах, дуугүй болох, нүүрний мэдрэл саажих, отгон, шингэн задгайрах гэх мэтийн мэдрэлийн өвчний шинж тэмдгүүд нь заавал хэвлэйн өвдөлттэй хавсран илрдэг.

Зүрхний цохилт олшрох, цусны даралт ихсэх, зүрхны давхарын өөрчлөлтүүд зүрхний цахилгаан бичлэгт илрэх зэргээр зурх судасны тогтолцооны талаас согог илэрнэ.

Сэтгэцийн зарим өөрчлөлт тухайлбал нойр хулжих, сэтгэл санаа тогтвортгүй, тайван бус, гутранги буюу хөөрөнги байдалтай болох, ухаан самуурах, ухаан балартах явдал ч гарна (2,4).

Эмчилгээ:

— Эмнэлэгт хэвтүүлж хэвтрийн дэглэмд байлагах

— Порфири өвчин үүсгэгч шалтгаан байж болзошгүй бүхий л нөхцөлийг өөрчлөх

— Шинж тэмдгийн эмчилгээ хийх. Үүнд: Гухайн өвчтоний би-еийн байдалд тохируулан 10% глюкозын уусмалыг их хэмжээгээр венийн судсаар хийх, өвчин намдаах промедол, морфин зэргээр эмчилиэ.

— Гэдэсний саажилт үүссэн буюу удаан хугацаагаар отгөн хатахад неостигмин, прозерин хэрэглэнэ.

— Цусны даралт бууруулах зүрх судасны талаас гарсан со-гогт β-блокаторууд, индерал зэргийг огнэ.

— Сэтгэцийн согот—аминазин, электролитуудын солилцоог хэвийн болгох, шингэн алдагдахын эсрэг эмчилгээ хийнэ (1).

II. Элэгний архаг порфири буюу (*porphyria cutanea tarda*) өвчний шинж тэмдэг нь харьцангуй хөнгөн хэлбэрээр илэрнэ. Порфиринууд нь гэрлийн энергийг их хэмжээгээр шингээдэг бодис юм. Иймээс өвчтоний арьсанд нэлээд хэмжээгээр хуримтлагдсан порфирийн гэрлийн энергийг ихээр шингээнээс болж иммунологийн болон бусад олон өөрчлөлт үүсч арьсиг гэмтээнэ.

Үүнд: цэврүүтэх, арьсны ил хэсэгт нөсөөжилт ихсэх, арьс амархан шалбараах, гуужих зэрэг шинж тэмдэг илэрнэ. Энэ нь бодисын солилцооны өөрчлөлтөнд элэг гүнзгий нэрвэгдсэний зөвхөн гадаад илрэл юм. Порфиринууд элгэнд хуримтлагдан исэлдэж хорт бодис болж хувирах бөгөөд элгийг гэмтээдэг.

БНСЧСУ-ын Карлын их сургуулийн эрдэмтэн доктор, профессор В. Кордачийн хийсэн судалгаанаас узэхэд порфири өвчноор өвчлөөд эмчилгээ хийлгээгүй нас барсан өвчтөнүүдийн 64% нь элэгний хатангиралтай, 47,2% нь элэгний хавдар, хатангирал хоссон байжээ.

Пэрфири өвчин нь даамжирч элэгний хатангирал, ялангуяа элэгний анхдагч хорт хавдартай болсон өвчтонийг эмчлэхэд төвөгтэй бөгөөд заримдаа эмчилгээ авдаггүй.

Тийм ч учраас порфири өвчтэй хүмүүст цирроз буюу элэгний хорт хавдраас урьдчилан сэргийлэх эмчилгээ хийх нь чухал юм (5).

Эмчилгээ: — Юуны өмне соитууруулах ундаа хэрэглэхийг хориглох.

— Өөх, тос багатай, халуун ногоо холиогүй, шарж, хайраан гүй хоол идэх.

— Биеийн ил хэсгийг нарнаас хамгаалах

— Элэгний үйл ажиллагааг сайжруулах эмчилгээ хийх.

B_6 , B_{12} , PP зэрэг витамин өгөх.

— Карболен их хэмжээгээр өгөх

— Цус авч эмчлэх (500 мл цусыг долсо хоногт 1 удаа) бүгд 4 удаа, 14 хоногийн завсарлагатай 2 удаа, сарын дараа нэг удаа

авах (3). Цус авч байгаа үед NaCl, темодез зэрэг шингэн хийх зэрэг болно.

Дээрх курс эмчилгээ хийсний дараа хлорохиний бүлгийн эмийг бага хэмжээгээр өгөхөд үр дүн сайтай байдаг. Тухайлбал Делагил 125 мг-аар долоо хоногт хоёр удаа 10—12 сарын туршид өгнө.

Эмч нарын олонх нь порфири овчнийг ховор тохиолддог, гэж үздэг төдийгүй энэ өвчнийг оношлоход лабораторийн нарийн шинжилгээ, тусгай багаж хэрэгсэл шаардлагатай мэт буруу ойлгодог тал ч бий. Архаг порфири (*porphyria cutanea tarda*) болон цочмог порфирийг орон нутгийн нөхцөлд ч оношлож болно. Даравах шинжилгээ нь хялбар бөгөөд оношлогооны онцгой ач холбогдолтой.

Талькт сорилоор шээсэнд порфириин тодорхойлох

Хуруу шилэнд 10 мл өлөн шээс хийгээд 2—3 дусал цууны ханасан хүчлээр исэлдүүлнэ. Халбаганы үзүүрээр бага зэрэг тальк нэмж сэгсэрээ. Ингэхэд тальканд порфириин шингэдэг. Галькийг тундасжсаны дараа шээсийг асгаж үлдсэн талькан дээрээ 10 мл 5% давсны хүчил хийж сэгсрээд тавина. Уусмал тундасжсаны дараа харанхуй өрөөнд ультра ягаан гэрлийн тяянд харагад:

- Хөх ногоон өнгөтэй байвал-урвал сөрөг
- ягаан онгийг-бага зэргийн эерэг (500—800 микрограмм порфирийнг 24 цагт ялгаруулж байна)
- улаан өнгөтэй байвал-нэн эерэг (800 микрограммаас илүү порфирийн ялгарч байна гэж үздэг) (6).

Цочмог порфиритэй өвчтоний шээсийг гэрэлд тавихад өнгө нь харладаг. Энэ үзэгдэл өвчтоний шээсэнд хүчил холиход улам тодорхой болно. Цочмог порфирийн үед шээсээр их хэмжээний порфобилиноген ялгардаг бөгөөд үүнийг шээсэнд порфобилиноген тодорхойлох C. Watson, S. Schwartz нарын аргаар мэдэж болно. Үүнд: 1 мл шээсэнд 1 мл эрлихийн уусмал (2% парадиметиламинонензоладенид; 20% давсны хүчлийн уусмалтай) 2 мл ханасан CH₃COONa хийхэд ягаанаас улаан ягаан өнгөтэй болж байвал уг урвал эерэг гэнэ. Гэхдээ уробилиноген мөн ийм өнгө огдог бөгөөд ялгахын тулд ойролцоогоор 2 мл хлороформ нэмж сэгсрэхэд уг уусмалууд холилдох байвал уробилиноген, хэрвээ холилдохгүй тус тусдаа ялгарч байвал порфобилиноген байна гэж үзнэ. Энэ хялбар шинжилгээний дүнд цочмог порфири өвчнийг оношлож болохоос гадна архаг порфиритэй хүн хэвлэлийн хурц өвчин хүрсэн тохиолдолд цочмог порфири өвчинөөс ялган таньж болно.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

- Л. И. Идельсон—„Нарушения порфиринового обмена в клинике“ 1963.
- Н. П. Кузнецова, Б. С. Панков и др. „Порфирии“ 1981,
- Б. Рагчаа—Порфирийн солилцоо алдагдах өвчиний эмчилгээний асуудалд. УБ. 1931.
- V. Kordav. P. Martasek—Akutni jaterni porphyrie vaz lek vez 33. 1984 (1009—1014).
- V. Kordac—Porphyrie v klinicke praki. 1978.
- A. Kappas, S. Sassa, K. E. Anderson—The porphyrias in: J. B. Wyngaarden, J. B. Stanbury, D.S. Fredrickson, J. L. Goldstein Brown MS eds. The metabolic basis of inherited disease. 5 th ed Nen yicik Me. grar—Hill. 1983. 1301—84
- L. Malina, A. Chlumsky, A. Chlumska—Porphyria cutanea tarda. 1974.
- R. N. Pimstone—Porphyria Cutanea Farda Sem. Hv. Dis. 2. 1982. 132—142.

Г. ОРОСОО, Г. НАВЧСАН (Эх нялхсыг хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэн)

Д. БАТЧУЛУУН (Эрүүл ахуй, халдварт, иян судлалын улсын институт)

ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ

Социалист эрүүлийг хамгаалахын үндсэн гол онцлог бол урьдчилан сэргийлэх чиглэл мөн. Ялангуяа хүүхдийн эрүүл мэндийг хамгаалахад урьдчилан сэргийлэх ажил маш чухал ач холбогдолтой.

Эрүүл хүүхдийн пасны онцлогийг мэдэхгүй, хүүхдийн бие маходын хөгжлийн зүй тогтолыг ойлгохгүй, тэдэнд нөлөөлөх гадаад орчны хүчин зүйл, пасны онцлогт тохирсон хоол, бусад дэглэм хүмүүжлийн арга хэмжээ зэргийг харгалзахгүйгээр аливаа өвчнооес урьдчилан сэргийлэх ажлыг оновчтой зохион явуулж болохгүй юм.

Мөн хүүхдийн насын анатом физиологийн онцлогийг мэдэхгүйгээр аливаа өвчин эмгэгийт оношилох, тухайн өвчин төгс эдгэсэн эсэхийг гүйцэд тогтоогоогүй болон зарим эмнэлэг урьдчилан сэргийлэх байгууллагын зохион байгуулалт боловсронгуй биш, хүүхдийг диспансерийн хяналтанд хамруулах ажил хангальт өүй зэрэг дутагдууд байна.

Хүүхэд эрүүл байхдаа л эмч, эрдэм шилжилгээний байгууллагын байнгын хяналтанд байх ёстой (3). Зөвлөлтийн хүүхдийн нэрт эмч, академич Г. Н. Сперанский "Физиологи бол амьдрал, хэвийн амьдрал билээ. Эрүүл хүүхдийн тоо, өвчтэй хүүхдийн тооноос хавьгүй олон гэдэг нь хэнд ч мэдээж. Ганц энэ баримт нь эмч нар физиолоийг судлахын чухлыг харуулж байна. Учир нь физиологи нь эмгэгийг ойлгоход тусалж, тэр ойлголт нь физиологийн зүй тогтлын мэдлэгийг гүнзгийрүүлнэ" гэж хэлсэн нь одоо ч ач холбогдоо алдаагүй байна (5).

Хүүхдийн осолт хөгжилт, гадаад орчинд дасан зохицох, түүнтэй харилцан үйлчлэх, бодисын солилцоо, дархдаа, биеийн эсэртгүүцэл зэрэг нь насанд хүрэгчдийнхээс чанарын ялгаатай байдаг учир хүүхдийн бие маход хөгжлийн тодорхой нэгэн үе шаттай байдаг.

Сүүлийн жилүүдэд хүүхдийн тэргүүний байгууллагын үйл ажиллагааг "Эрүүл мэндийн-индекс" буюу нэг ой хуртлээ нэг чөвчлөөгүй хүүхдийн тоогоор үнэлэх болж байна.

Бидний үзэж байгаагаар бол "Эрүүл мэндийн индекс"-д хүүхэд зөвхөн өвчлөөгүй байхаас гадна тэдний бие бялдар мэдрэл сэтгэхүйн хөгжилтийг нэгэн адил авч үзэх нь зүйтэй.

Дэлхийн эрүүлийг хамгаалах байгууллага "Эрүүл гэж зөвхөн өвчин согоггүй байх төдийгүй нийгэм, бие бялдар, оюун санааны өв тэгш байхыг хэлнэ" гэж тодорхойлж байна.

Эрүүл гэдэг ойлголт нь байгалийн шинжлэх ухааны "хэвийн байдал" гэдэг категорийн нэлээд дүйх юм. Гэтэл хүний ялангуяа хүүхдийн хэвийн байдлын хязгаарыг тогтооход төвөгтэй юм (4).

Эмч нар өдөр тутмынхаа үйл ажиллагаанд оргөн ашигладаг үзүүлэлтүүдийн нэг бол эрүүл хүний бие маходын бүтэц үйл ажиллагааны үзүүлэлт болох хэвийн хэмжээ юм. Энэ нь эрүүлийг эмгэгээс ялгах хэмжүүрийн нэг болно.

Альч үеийн эмч нар хүний эрүүл үеийн бүтэц үйл ажиллагааны тухай өөрийн гэсэн ойлголттой байж чухам үүн дээрээ тулгуурлаж өвчин эмгэгийг оношилон таньдаг байсан боловч хэвийн хэмжээ гэж юу болох, бүтэц үйл ажиллагааны чухам ямар

үзүүлэлтийг хэвийн гэж үзэх талаар онолын нэгдсэн дүгнэлтэнд хүрэхэд санал зөрдөг аж. Үүний учир нь уг ухагдахууны агуулга нь хүн төрөлхтөний мэдлэгийн түвшинтэй уялдан байнга баяжин, өөрчлөгдөн шинэчлэгдэж байдагт оршино. Тиймээс одоо ч гэсэн уг ухагдахууны нийтээр зөвшөөрсөн тодорхойлолт байхгүй байна.

Хэвийн хэмжээ гэдэг ухагдахууныг зөв тодорхойлохиin тулд аялгуугаараа ялгаатай боловч олон тохиолдолд адил утгаар хэргэлдэг хэвийн байдал (норм), хэвийн хэмжээ (норматив) гэдэг хоёр ухагдахууныг ялган салгах хэрэгтэй.

Хүүхдийн бие махбодын үйл ажиллагааны хэвийн байдал нь тэдний нас хүйс, удамшил, яс угсаа болон бусад олон хүчин зүйлээс шалтгаалж харилцаан адилгүй байх ба физиологийн, биохимийн нийгмийн зэрэг олон хэлбэртэй байж болно (4).

Эрүүл гэдэг сийлголт нь нэлээд өөрчлөлт бүхий хэлбэлзэлтэй байх боловч бие махбодод чанарын өөрчлөлт гарагчийг гэсэн уг юм.

Осон хөгжиж буй хүүхдийн хувьд бол эрүүл гэдэг нь физиологийн үйл ажиллагаа насандаа тохирч байхыг хэлиэ гэж Ю. Ф. Змановский бичсэн нь нэлээд тохиромжтой дүгнэлт болжээ.

Хэвийн байдлын хэлбэлзэл нь ямар нэг өвчний эхлэл, осон хөгжиж буй бие махбодын дасан зохицохын өөрчлөлт зөргийг харуулах учир нэгэнт тогтоосон хэвийн байдал, хэмжээний хэмблэлзэл бүрийг эмгэг гэж үзэж болохгүй (5).

Хэвийн байдал, эмгэг хазайлт, хувийн ба "хэцүү" хүүхэд, дасан зохицолт ба үл зохицолт, бүтцийн ба үйл ажиллагааны өөрчлөлт эрүүл ба өвчтэй зэрэг категориудын хоорондын зааг тогтооход төвөгтэй хэвээр байна.

Хүүхдийн бие махбодын дотоод орчин гадаад орчинтойгоо харьцах онцлог "Зааг байдал" үүсэх нохцолийг бурдүүлдэг.

Бие махбодын дотоод орчиноо тэнцвэржүүлэх чадвар их, тэр нь гадаад орчны нөлөөн дор байнга хувьсан өөрчлөгдэж байдаг учир туйлын хэвийн байдал гэж байдаггүй.

Хүүхдийн өвчин судлалын практикт "зааг байдал" гэж өвчний шинж тэмдгүүд тод илрээгүй, идэвхтэй өврмөц эмчилгээ шаардахааргүй өөрчлөлтүүдийг хамруулан үзэж байна. Зааг байдал маш олон янз байх ба тодорхий ангиалал одоогоор байхгүй байна.

Зааг байдал бүхий хүүхдийг диспансерийн хяналтаанд авч эмчилгээ, оношилгооны дараах онцлогуудыг анхаарах хэрэгтэй.

1. Эмнэл зүй, лаборатори, өвчтөний зовиур шаналгааг динамиктай ажиглаж эмчилгээ оношлогоонд болгоомжтой хандах.

2. Оношийг хэтрүүлэн тавьж яаран эмнэлэгт хэвтүүлж эмчлэхээс болгоомжлох.

3. "Зааг байдал"-тай хүүхдийг нарийвчлан үзэж "өртөмтгий" байдлын бүлэг тогтоох.

4. Бие махбодын өөрийн нь нооц чадварыг дайчлахад ихээхэн анхаарч антибиотик эмчилгээг аль болох хойшлуулах.

5. Урьдчилан сэргийлэх тарилга, ясли цэцэрлэгт өгөх эсэхийг зөв анхааралтай шийдэх хэрэгтэй (3).

Мөн орчин үед хүүхдийн эрүүл мэндийн бүлэг тогтоож байна.

С. М. Грамбах (1965) хүүхэд архаг өвчтэй эсэх, эрхтэн системийн үйл ажиллагааны байдал, бие махбодын эсэргүүцэл дархлаа, урвал чанар, бие бялдар мэдрэл сэтгэхүйн хөгжилт зэрэг шалгуур шинж тэмдгүүдийг харгалзан хүүхдийн эрүүл мэндийн бүлэг тогтоож болно гэж бичжээ.

ЗХУ хүүхдийн эмчлэн сэргийлэх байгууллагуудын үйл ажиллагаанд судалгаа хийж эрүүл мэндийн 5 бүлэг тогтоожээ.

Нэгдүгээр бүлэг

Ажиглалтын хугацаанд өвчлөөгүй буюу 1—2 удаа хөнгөн өвчилсөн, хүүхдийн эрүүл мэндэд нөлөөгүй жижиг гаж хөгжилтэй, тухайн үед ямар нэг өвчин эмгэгийн шинж тэмдэг илрээгүй хүүхдүүд орно.

Хоёрдугаар бүлэг

Нийгэм, биологи удамшлын сорог нолоөлөлгүй, жилд олон дахин буюу удаан өвчилсон, өвчин архагшиж мағадгүй хүүхдүүд багтана.

Дараах заалтыг харгалзан эрүүл мэндийн хоёрдугаар бүлэг тогтоожээ.

- Жирэмслэлт, төрөхтэй холбоо бүхий эмгэг
- Эцэг эх нь өвчтэй, архи уудаг, хагас буюу бүтэн ончин, „эцэг“-гүй хүүхэд зэрэг гэр бүлийн тааламжгүй байдал.
- Сульдаагийн нэгдүгээр зэрэг, эхлэл буюу үлдэцийн үе
- Биенгийн эхийн ехдэх, багадаын нэгдүгээр зэрэг
- Шүүдэст эмзэгшил, хоол болон эмэнд харшилтай байх
- Мэс заслын эмчилгээ шаардахааргүй төрөлхийн гаж хөгжлийд
- Хавтгай тавхайтай (ултай) буюу төрөх үед зулай том бага буюу битүүрсэн байх зэрэг гажгууд
- Зүрх судасны системийн үйл ажиллагааны оорчлолт, цусны дараалт ихсэх, багасгах хандлага, ачааллын үед гарах оорчлолт их байх.
- Гүйлсэн булчирхайн томролт хоёрдугаар зэрэг, хамрын таславч муруйсан байх, уушгины үрэвсэл, вирусын гаралтай хурц өвчинөөр олон өвчлөх.
- Цусны геомоглобин багасах.
- Сэрээ булчирхай томрох
- Мэс заслын эмчилгээ шаардлагатай шүдний гаж хөгжлийд, шүдний зуулт оорчлолгүй, 6—8 шүд хорхойтох.
- Мэдрэл сэтгэцчийн хөгжилт хоцронго байх, дультраа байх, мэдрэлийн өвчинүүд.
- Хоодонд дургүй, үе бөөлжиж гүйлгэх, хэвлэйгээр өвдөх
- Хялар, ойрын хараа муудах
- Сүрьеэгийн сорил эргэлзээтэй байх
- Удаан ургэлжилсэн халдварт ба халдварт гүйлгээний эдгарэлтийн үе.

Гуравдугаар бүлэг

Цөөн дахидал архаг өвчтэй, ээнэгшилийн үедээ байгаа төрөлхийн гажгууд, хавсарсан өвчинөөр жилд 4-оос дээш өвчилсон хүүхдийн биеийн байдалд онц нөлөөгүй архаг өвчтэй хүүхдүүд орно.

Ээнэгшилийн байдлыг зөвхөн өвчилсон, эрхтэний талаас гарах үйл ажиллагааны оорчлолттай, бусад эрхтэй системийн талаас оорчлолтгүй байдлаар тогтооно.

Дөрөвдүгээр бүлэг

Ээнэгшил алдагдах үедээ орсон архаг өвчин, олдмол гажгууд, бие бялдрын хөгжилт хоцронго байх, үндсэн өвчний дахилт хүнд биш боловч дахилтын дараа хүүхдийн биеийн байдал оорчлолгүй, хавсарсан өвчинүүд удаан эдгэх зэргийг харгалзан тогтооно. Ээнэгшил алдагдах шатанд зөвхөн өвчилсон эрхтэний талаас тохижгүй бусад эрхтэй системийн үйл ажиллагааны хямрал илрэнэ.

Тавдугаар бүлэг

Хүнд архаг өвчтэй буюу ээнэгшил алдагдсан төрөлхийн гажгууд оороор хэлбэл хүүхдийг тахир дутуу болгоход хүргэсэн өвчинүүд орно. Хүүхдийн эрүүл мэндийн бүлгийг хамгийн хүнд явцтай өвчиний байдлаар тогтооно (2).

Манай орны байгаль, цаг уур, хүн амын амьдралын өвөрмөц байдалтай холбон юуны омно хүүхдийн насы онцлогийг оордийн орны нөхцөлд судлаан эрхтэн системийн хэвийн байдал, хэмжээг тогтоох шаардлагатай байна. Улмаар бүх насын хүүхдийн онцлогийг тэдний хүрээлэн буй орчин гэр бүл, ясли цэцэрлэг сургууль, сургуулийн дотуур байрны үйл ажиллагаа, зохион байгуулалттай уялдуулан судлах хэрэгтэй байна.

Эдгээрийн үндсэн дээр хүүхдийн эрүүл мэндийн бүлэг тогтоож тэдний эрүүл мэндийг үнэлж хүүхдийг 100 хувь диспансерийн хяналтанд байлгах нь зүйтэй юм.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. К. Н. Дорожнова—Роль социальных и биологических факторов в развитии ребенка. М. Медицина, 1983, 160.
2. М. П. Матвеев, А. В. Чебуркин—Пограничные состояния у детей. Педиатрия, 1981, 12, 8—12.
3. А. Ф. Тур—Изучение возрастных особенностей здоровых детей несобходимое условие дальнейших успехов. Педиатрия, 1958, 6, 3—7.
4. М. Я. Студеникин, Л. К. Скорнякова и М. Н. Никитина—Медицинские проблемы роста и развития детей. Педиатрия, 1871, 6, 5—9
5. Медицинские проблемы роста и развития здорового ребенка—ведущее направление программы научных исследований в педиатрии. Педиатрия, 1983, 4, 3—6.
6. Г. Даашэвэг, П. Нямдаваа, Ц. Эрдэнэсамбуу—Хүний биений бүтэц, үйл ажиллагааны хэвийн хэмжээ. 1980.

Редакцийд ирсэн 1986—01—12.

Д. ЖОДОВ (Анагаах ухааны дээд сургууль)

ПЕРИТОНИТЫН АНГИЛЛЫН ЗАРИМ АСУУДАЛ

Яаралтай мэс засал шаарддаг хэвлийн хөндийн цочмог өвчнүүдийн дотор перитонит дунджаар 16—20%-ийг эзэлдэг болохыг зарим эрдэмтдийн судалгаа харуулж байна (5, 6, 10).

Хэвлийн хөндийд хийх мэс заслын тоо слыширч арга нь улам нарийн төвөгтэй болсноос мэс заслын дараагаар үүсэх перитонит ихсэж, өвчтөн эндэх явдал буурахгүй байгаа тухай эрдэмтэд тэмдэглэсэн байна (1, 7). Перитонитгээ цаг алдаглгүй оношилж, эмчилгээний тактикийг зөв зохистой боловсруулхад доорх ангилаал чухал үүрэгтэй.

Перитонитын ангилаал дотроос үрэвсэл хэвлийн хөндийгөөр тархан байрлах тухай асуудал нэг мөр болоогүй байна.

В. С. Савельев (5), В. И. Стручков (6) зэрэг судлаачид перитонитыг хэсгийн (местный), өөр хэсэг рүү шилжсэн тархмал (разлитой) гэж үндсэн хоёр ангид хуваадаг. Хэсгийн перитонитгээ гэр үүсгэсэн буглаа маягийн хязгаарлагдмал (осумкованный), болон тархах хандлага бүхий задгай гэж хоёр хуваана.

В. Д. Федоров (10), В. Д. Савчук (7), В. И. Казанский (2), В. С. Маят (3), Г. Л. Ратнер (4) З. А. Топчашеили (8) зэрэг олон судлаачид хэвлийн хөндий дэх идээт голомтоос үүссэн хэсгийн перитонит нэвчин (диффузный) тархаж улмаар түгээмэл (общий) перитонит болон хувирдаг гэж үздэг.

Тархмал, нэвчсэн, тархан нэвчсэн гэх мэтээр өөр хооронд нь салгах нарийн зэаггүй нэр томьёог хэрэглэсэн байдаг. Жишээ нь:

В. Н. Тонковын хэвлийн урд ханыг 9 хэсэг болгож хувааснаар В. Д. Савчук (7) тэр 9 хэсгийн 2—5 хэсэгт перитонит үүсвэл түүнийг нэвчмэл перитонит гэж нэрлэсэн байдаг. Хэвлийн хөндийд байгаа үрэвслийг ханаар нь мэдэж оношлох бололцоогүй учир үүнийг практикийн ач холбогдол багатай гэж үздэг байна.

В. Д. Федоров (10) хэвлийн хөндийн олон зайнуудын аль нэгний үрэвслийг хэсгийн перитонит гэж үзээд хөндлөн бүдүүн гэдсээр хоёр хуваагддаг хэвлийн хөндийн дээд, доод хэсгийн аль нэг нь үрэвссэн байвал тархмал, хэвлийн хөндий нийтээр үрэвссэн байвал түгээмэл перитонит гэж нэрлэжээ.

А.А. Шалимов (11) зэрэг судлаачид перитонитыг анхдагч хэсгийн хязгаарлагдмал, түүнээсээ нэвчин тархаж түгээмэл шинжийг олдог, мөн хоёрдогч хязгаарлагдмал байдаг гэж ангилсан байна. В. П. Петров (9) перитонитыг хэвлийн хөндийн зайд завсраар гэр үүсгэн хязгаарлагдсан буюу өсвэл хязгаарлагдаагүй (хэсгийн, тархмал, түгээмэл) гэж үндсэн хоёр ангитай ангилал зохиожээ.

Эдгээр ангилал нь перитонитыг хязгаарлагдсан байдлаар хураангуйлан ойлгоход хялбар болгосон бөгөөд үрэвслийн голомтонд байгаа хэсгийн перитонит аажмаар нэвчин тархсаар түгээмэл болдог энэхүү өвчиний дэс дарааллыг ихэд анхаарсан байна.

Бид перитонитын талаар дээр өгүүлсэн олон тооны, аңгиллын дагуу өөрсдний дагаж мөрддөг ангиллын хувилбарыг баяжуулж, эмч нарын өдөр тутмын практикт хэрэглэдэг байдлаар нь танилцуулав.

Перитонитыг хэсгийн ба тархмал гэж ангилдаг бөгөөд хэсгийнхийг нь гадуураа гэр бүхий буглаа хэлбэрийн, өсвэл үрэвслийнхээ голомт тойроод байгаа гэр үүсгээгүй задгай гэж хоёр хуваадаг. Хэсгийн перитонитын үед өвчтөний биеийн байдал хөнгөн, шинжтэмдэг нь үндсэн өвчинөөр илрэх ба мэс засал хийхдээ идээт голомтыг арилгаад ором руу нь гуурс тавина. Хэсгийн перитонит голомтоосоо хальж өөр хэсэг руу нэвчиж шүүрч орсон бол тархмал перитонит гэнэ. Хязгаарлагдсан байгаа ийм тархмал перитонитыг бид хязгаарлагдсан тархмал перитонит гэж нэрлэв. Энэ үед өвчтөний биеийн байдал хүндэвтэр, хордлогын гүхны шинжүүд илэрч эхлэх ба хэвлийн хөндийн голомтот үрэвслийн шинж тархмал байдалтай болно. Эмчилгээ нь; Голомт г арилгаж ором руу нь гуурс шургуулах ба үрэвсэл шилжсэн хэсэг руу нэмэлт зүслэгээр хэвлийн хөндийд, угтуулсан хоёрдох гуурсыг тавина.

Хязгаарлагдсан тархмал перитонит цаашдаа зогсолтгүй нэвчин тархсаар хэвлийн хөндийн дөрөвний гурваас илүү зайд хамарсан буюу аарцгийн ёроолоос өрцний хүнхрийг хүртэлх зайд хамарсан бол түүнийг түгээмэл тархсан перитонит гэж нэрлэнэ. Энэ үед өвчтөний биеийн байдал маш хүнд байх бөгөөд хордлого ч түгээмэл шинжтэй илэрнэ.

Түгээмэл тархсан перитонитыг эмчлэхдээ голомт хаана байгааг үл харгалзан аюулхайгаас умдаг хүртэл хэвлийн гол шугамаар хагалгаа хийж голомтыг арилган хэвлийн хөндийг асептикийн дэглэмийн дагуу цэвэрлэнэ. Дараа нь хүйсний баруун, зүүн, дээр, доор нэмж зүсээд тэдгээрээр гуурс хийж мэс заслын дараах угаалга, диализ зэрэг эмчилгээ хийнэ.

Иймээс үрэвслийн эзлэх талбай өвчиний явцаас үүдэн гарсан бидний баримталж байгаа энэ ангиллаас эмчлэх арга нь өөр байдаг.

Ходоод, гэдэс цоорох, цул, эрхтэн хагарч цус алдсанаас үүсэх, сүрьеэ, шалтгаан нь тодорхойгүй цочмог түгээмэл перитонит энэ ангиллын хэлбэрт хамаарахгүй.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. А. И. Древина, Н. И. Конолова-Вестн. хир, 1977, 8, 16—21
2. В. И. Казанский -В кн.: Многотомное руководство по хирургии. М., 1960, 648—702
3. В. С. Маят, В. Д. Федоров, Т. М. Никитин-Хирургия, 1970, 10, 155—156
4. Г. Л. Ратнер, Г.И. Демидов, А.Ю. Саножков. Клин хир 1980; 4, 21—24,
5. В. С. Савельев, -В кн: Всероссийская конференция хирургов. М., 1970.
6. В. И. Стручков, В. А. Сахаров. В кн; Функциональные методы исследования при хронических заболеваниях и травмах органов грудной и бр' полости. М. 1980, 38, 78—80
7. В. Д. Савчук-Гнойный перитонит. М., 1979.
8. З. И. Тончашвили, В. Л. Кассиль, Н. М. Янюшин и др Хирургия, 1970, 2 3—6
9. В. П. Петров-Хирургия, 1932. 11, 98.
10. В. Д. Федоров Лечение перитонита. М. 1974.
11. А. А. Шалимов, В. И. Шаношников, М. П. Пинчук-Острый перитонит. М. 1981, 3—14.

Редакцид ирсээн 1985—01—08.

Б. ОЧИР. (Анагаах ухааны дээд сургууль)

ГЭДЭСНИЙ ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ГОЛОМТЫГ ДҮН БҮРТГЭЛИЙН АРГААР СУДЛАХ НЬ

Халдварт өвчтэй хүн, нян тээгчийн оршин буй орон сууц, эд юмс, өвчтонеөс ялгарсан нянгаар бохирдсон байж болох бүх хүмүүс болон объектыг халдварт өвчний эпидемийн голомт гэнэ. Зарим уед эпидемийн голомт нь ажлын газартай холбоо бүхий өргөн хүрээтэй байж болно.

Гэдэсний халдварт өвчний эпидемийн голомтыг тооны байдлаар нэг өвчлөлтэй, олон өвчлөлтэй гэж хуваана.

Нэг өвчлөлтэй голомтын уед халдвартыг дамжуулах хүчин зүйл нь голдуу гэр орны хавьтал, ахуйн зам байдаг.

Олон өвчлөлтэй голомтууд нь үүсч байгаа шинжээрээ харилцан адилгүй.

1. Улаан суулга өвчин нууц үедээ нэг айлын хэд хэдэн хүнийг өвчлүүлж болно. Ийм голомтыг нэг зэрэг үүссэн олон өвчлөлтэй голомт гэнэ. Халдвартыг дамжуулагч хүчин зүйл нь голдуу ус ба хоол хүнсний зүйл байдаг.

2. Улаан суулга өвчинеөр нэг айлын нэг хүн өвчилиж нууц үе онгорсний дараа дахин шинээр хүн өвчилиж болно. Ийм голомтыг хоёр дахь өвчлөлтэй голомт гэнэ. Хоёрдахь өвчлөлтэй голомт үүсэх нь анхдагч голомтод сэргийлэх арга хэмжээ хангалтгүй хийснээс болно.

Дээрхээс үзэхэд олон өвчлөлтэй голомтын үүсч байгаа шинж чанар ялгаатай нь халдварт дамжсан хүчин зүйлүүд харилцан адилгүйгээс хамаарна.

Гэдэсний халдварт өвчний тархалтад нөлоөлж байгаа дамжуулагч хүчин зүйлийг тодорхойлоходо голомт бурийг судалсан материалыг нэгтгэн боловсруулж судлахаас гадна голомтуудын үүсч байгаа шинж байдлын үзүүлэлтийг сар, улирлаар гаргах нь ач холбогдолтой юм.

Голомтын үүсч байгаа шинж байдлыг доорх үзүүлэлтээр тодорхойлно. Үүнд:

- Голомтын ерөнхий үзүүлэлт
- Нэг зэрэг үүссэн олон овчлөлтэй голомтын үзүүлэлт
- Хоёр дахь овчлөлтэй голомтын үзүүлэлт
- Голомтын үргэлжлэх бодит хугацааны дундаж үзүүлэлт зэрэг болно.

Голомтын ерөнхий үзүүлэлтийг гаргахдаа тодорхой хугацаанд гарсан бүх овчтон, нян тээгчийн тоог хамрагдсан голомтын тоонд хуваана.

Тухайлбал 7-р сард улаан суулга өвчинеэр 50 хүн өвчилиж 20 нян тээгч иларсэн, эдгээр нь 48 голомтод байжээ

$$\text{Голомтын ерөнхий үзүүлэлт нь: } \frac{50+20}{48} = \frac{70}{58} = 1,8$$

Голомтын ерөнхий үзүүлэлт нь нэгээс их болох тутам олон овчлөлтэй голомт олширч байгааг илтгэнэ. Нэг зэрэг үүссэн олон овчлөлтэй голомтын үзүүлэлтийг гаргахдаа нууц үеийн дотор үүссэн уг голомтонд хамрагдсан овчтон ба няа тээгчдийн тоог хамрагдсан голомтын тоонд хуваана.

Тухайлбал: 7-р сард нэг зэрэг үүссэн олон овчлолтэй голомт 9 гарсан ба түүнд 21 овчтон хамрагджээ.

$$\text{Нэг зэрэг үүссэн олон овчлөлтэй голомтын үзүүлэлт нь: } \frac{21}{9} = 2,3$$

Нэг зэрэг үүссэн олон овчлөлтэй голомтын үзүүлэлт 2-оос баага байх ёсгүй. Хоёроос их болох тутам дамжуулагч нийтлэг хүчин зүйл илэрч байгаа нь харагдана.

Хоёрдахь овчлолтэй голомтын үзүүлэлтийг гаргахдаа уг голомтонд байгаа өвчтоний тоог хамрагдсан голомтын тоонд хуваана.

Тухайлбал: 7-р сард улаан суулга өвчиний хоёрдахь овчлолтэй голомт 8 гарсан ба түүнд 12 өвчтон хамрагджээ.

$$\text{Хоёрдахь овчлөлтэй голомтын үзүүлэлт нь: } \frac{12}{8} = 1,5$$

Энэ үзүүлэлт нэгээс их болох тутам анх илэрсэн голомтонд авсан саргийлах арга хэмжээ хангалтгүйг харуулах ба халдварт нь голдуу хавьтал ахуйн замаар дамжсан байна.

Голомтын үргэлжлэх бодит хугацааны дунджийг голомт бүрийн үргэлжилсэн хугацааг нэг бүрчлэн бодож тодорхойлно.

Нэг голомтын үргэлжлэх бодит хугацааг өвчин эхэлсэн одроос төгсгөлийн халдвартгүйтгэл хийсэн одор хүртэлх хоногоор гаргана.

Тухайлбал: 1985 оны 3-р сарын 1-нд өвчин эхэлсэн Са мөн сарын 3-нд эмчид үзүүлж тэр одортой эмнэлэгт хэвтэж, төгсгөлийн халдвартгүйтгэл хийлгэв. Үүнээс хойш гээ толомтоос дахин өвчин гараагүй.

Голомтын үргэлжлэх бодит хугацаа 3-р сарын 1-нээс 3 хүртэл бүгд 3 хоног болно. Хэрвээ энэ голомтоос 3-р сарын 9-нд дахин хүн өвчлөх буюу нян тээгч илэрсэн бол голомтын үргэлжлэх бодит хугацаа 3-р сарын 1-нээс 9 хүртэл бүгд 9 хоног гэж үзнэ.

Нян тээгчийн хувьд голомтын үргэлжлэх бодит хугацааг тодорхойлоходоо шинжилгээний материал авсан одроос эмнэлэгт хэвтүүлж төгсгөлийн халдвартгүйтгэл хийсэн одор хүртэлх хугацааг авна.

Хэрвээ өвчтон эмнэлэгт хэвтээгүй бол өвчин эхэлсэн одроос голомтонд байнгын халдвартгүйтгэл хийж эхэлсэн одор хүртэлх хугацааг авна.

Голомтын үргэлжлэх бодит хугацааны дундаж үзүүлэлтийг гаргахдаа голомт пэг бүрийн үргэлжилсэн бодит хоногийг голом-

туудын тоогоор үржүүлж гарсан тооны нийлбэрийг бүх голомтын тоонд хуваана.

$$\text{Бодох томъёо: } M = \frac{\Sigma V \cdot P}{n}$$

M—голомтын үргэлжлэх бодит хугацааны дундаж

V—голомтын үргэлжилсэн бодит хугацаа

P—голомтын тоо

n—бүх голомтын тоо

Σ —нийлбэр

Тухайлбал: 7-р сард улаан суулга овчний 48 голомт үүсжээ.

Эдгээр голомтуудын үргэлжилсэн бодит хугацаа харицсан адилгүй байв. З хоног үргэлжилсэн голомт 20, 4 хоног үргэлжилсэн голомт 16 гэх мэт. Үүнийг доорх хүснэгтээр үзүүлье.

Хүснэгт 1

V	P	V·P
3 хоног	20 голомт	$3 \times 20 = 60$
4	16	$4 \times 16 = 64$
8	8	$8 \times 8 = 64$
10	2	$10 \times 2 = 20$
12	1	$12 \times 1 = 12$
20	1	$20 \times 1 = 20$
48		240

$$M = \frac{240}{48} = 5$$

Энэ үзүүлэлт нь халдварын нууц үеэс бага болох тутам халдварт дамжуулах хүчин зүйлүүд олширч байгааг харуулах ба нууц үеэс их болох тутам оноштолт, хэвтүүлэлт хожуу, голомтанд авсан сэргийлэх арга хэмжээ хангалтгүйг илэрхийлийн.

Голомтуудын үргэлжлэх бодит хугацааны дундаж үзүүлэлт богинооч, голомтын ерөнхий үзүүлэлтүүд ихсэх нь гэдэсний халдварт өвчний дамжуулагч хүчин зүйлүүд олширч нийтлэг замтай (ус, хоол, хүнс) болж байгаагийн дохио болно.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

- Н. И. Абрамова — Очаговости кишечных инфекции. 1974.
- И. И. Елкин — Эпидемиология. 1979
- В. М. Жданов — Общая эпидемиология. 1959

Редакцийд ирсэн 1985—04—15

Ш. ЖАДАМБА (Анагаах ухааны дээд сургууль)

КЛИНИК ЛАБОРАТОРИЙН СУДАЛГААНД ИЖИЛСГЭСЭН АРГУУДЫГ НАРИЙСГАХ АСУУДАЛД

1940-өөд оноос клиник (эмнэлгийн) шинжилгээний аргыг нарийсгах шинжилгээний чанарыг сайжруулахад ихээхэн анхаарах болсон байна.

Орчин үед эмнэлэгт сонгомол арга зүйг хэрэглэх нь онцгой ач холбогдолтой бөгөөд үр дүн нь аль ч лабораторт ижил байвал уг арга зүйн шинжилгээний алдаа нэг ижил байдаггүй. Алдаа тохиолдлын, тогтмол гэсэн хоёр янз байна.

— Тохиолдлын алдаа нэлээд тохиолддог ба жингийн болон эзэлхүүний хэмжилт, бодисыг халаах явц, цаг хугацаа зэргээс хамааран гардаг учраас шинжилгээнд хэрэглэж байгаа шимүүр, эзэлхүүн бүхий савууд нэг төрлийн байхаас гадна түүнд засвар хийсэн байх шаардлагатай. Бодисуудыг тодорхой градуст халаахдаа аль болох жигд халаах, явагдаж буй урвалын цаг хугацааг нарийн баримтлах, хэрэглэх дээжүүдийг зөв бэлтгэх нь чухал юм.

Тогтмол алдааг тохиолдлын алдаан дээр нэмсэн алдаа гэж үзэх үндэстэй бөгөөд хэрэглэж байгаа стандарт, жиших муурийг байгуулсан байдал, багаж төхөөрөмж, урвалж бодисуудын чанар зэргээс хамааран илэрдэг. Стандартаас гарсан алдаа тохиолдлын ч байж болох талтай, Хоёр лабораторт өөр өөр стандарт хэрэглэж байвал дүн зөрөөтэй гарч болох тул стандартын хувь, концентрацийг шалгаж байхын гадна, хийж байгаа шинжилгээний их багаас хамаарах боловч стандартын нэлээд хэмжээгээр авч хэрэглэх нь алдааг багасгана. Жиших муурийг 1—4 стандарт уусмалаар (харьцуулах журмаар) босгох нь үр дүн сайтай болно. Тэхдээ маш болгоомжтой, удаан, нямбай хийх ёстой.

Урвалжуудаас уусмал бэлтгэх, уусмалा�ас уусмал бэлтгэхдээ хэмжээ, эзэлхүүн ихтэй бэлтгэж, уусмалын орчин (rh)-ыг (ялангуяа комплекс нэгдэл үүсгэх процесс, ферментэн урвалд) анхаарах нь чухал. Ер нь тохиолдлын, тогтмол аль ч алдаа байлаа гэсэн алдаа гарсан шалгааныг дор нь илрүүлж зогсоох хэрэгтэй. Тохиолдлын алдаа уг арга зүйн үр дүнг, тогтмол алдаа түүний зөвийг тодорхойлдог. Тохиолдлын алдааг тогтмол алдаанаас ялгахад шинжилгээний маш нарийн арга зүйгээр шалган харьцуулж олон давталттай тодорхойлтоор үнэлгээ өгнө. Энэ ажлын гол зорилго нь үндсэндээ арга зүйн үр дүнгийн шинжилгээ юм. Өөрөөр ажиглагдаж буй шинжилгээний алдааг гарч болох тогтоогдсон хязгаартай (математикийн боловсруулалт хийсэн үр дүнгийн хэлбэлзлийн хязгаар) харьцуулж уг арга зүйг хэрэглэх эсэхийг шийдэж болох юм.

Дээрх хязгаарын тодорхойлогдох аргууд янз бүр боловч үндсэнд нь:

1. Клиникийн шаардлагад чиглэсэн

2. Мэргэжлийн нэлээд клиник-оношлолын лабораторийн гаргасан үр дүнгийн зөвд чиглэсэн гэж хоёр хэсэгт хуваана. Энэ алдааны хязгаар нь арга зүй тус бурд тодорхойлогдох ёстой. Эмнэлгийн гарч болох алдааны хязгаарыг тогтоох зарчмуудын талаар олон санал байдаг боловч арга зүйн алдааны хэмжээ нь хяналтын материалын судалгааны давтамжаар гарган авсан дүнгийн 2 дундаж квадратын хэлбэлзлэл ($2S$)-ээр үнэлэгдэнэ. Иймд гарч болох алдааны хязгаар өөрчлөлтийн коэффициент (коэффициент вариации) -ээр илэрнэ гэж ойлгож болох юм.

Алдааг хянах нэг хүчин зүйл бол лабораторид дотоод, гадаад гэсэн хяналт тавих шаардлагатай. Үүний тулд дээр бичигдсэн бүх аргууд, алдаа гарах хүчин зүйлүүдээс аль болох болгоомжлон шинжилгээнд авч буй тухайн ийлдэст бүх үзүүлэлтийг тодорхойлж тооны боловсруулалт хийж, үр дүнг харьцуулан тооцох хэрэгтэй Жишээ нь: Цусны ийлдэст сахар (глюкоз)-ын хэмжээг орто-толуидины аргаар тодорхойлоход математикийн дундаж $M = 100\text{mg\%}$ дундаж квадратын хэлбэлзлэл (S) ± 8 гарлаа гэж үзвэл $M \pm 2S$ буюу 100 ± 16 ; болох учир сахарын хэмжээ $84 - 116\text{mg\%}$ байна. Үүнээс өөрчлөлтийн коэффициентийг гаргавал:

$$\frac{S \cdot 100}{M} = \frac{8 \cdot 100}{100} = 8\%$$

Гарч байгаа коэффициент 5% гарвал үр дүн нэлээд сайн гэж үзэж болох юм. Хэрэглэж байгаа арга зүйн нарийвчлал (үр дүн)-ыг шалгахын тулд мөн дээжинд уг аргаар өөр лабораторт шалгуулах, өөр улсад хийсэн шинжилгээний дүнтэй харьцуулах зэргээр гадаад хяналт тавих хэрэгтэй. Харин өөрийн лабораторт хяналт тавихын тулд шинжилгээний карт хөтлүүлж алдааг хянах нь тохиromжтой байдаг.

Карт хөтлөхөд онцгой анхаарах зүйл бол карт дээр өөр арга зүйгээр гаргасан үр дүнг хөтөлж болохгүй. Тодорхой арга зүй хэрэглэж гарсан үр дүнгийн зөв эсэхээс клиник лабораторийн шинжилгээний чанар хамаараад зогсохгүй оношлогоо, эмчилгээний цаашдын явц шууд хамаарах учраас клиник лабораториудад хамгийн сонгомол, хялбар нэг төрлийн арга зүйг хэрэглэх нь тухайн шинжилгээний үр дүнг болон оношлогоо эмчилгээний асуудлыг зөв шийдэхэд ихээхэн ач холбогдолтой юм.

Редакцид ирсэн 1985—10—25.

ЭЛЕКТРОКАРДИОГРАММД ЗҮРХНИЙ ЦАХИЛГААН ТЭНХЛЭГИЙГ ТОДОРХОЙЛОХЫН ОНОШИЙН ХОЛБОГДОЛ

Зүрхний булчингийн сэрлийн үед үүсэх цахилгаан хөдөлгөгч хүчиний векторуудын дундаж чиглэлийг зүрхний цахилгаан тэнхлэг (ЗЦТ) гэж нэрлэх ба хэвийн нөхцөлд энэ нь зүрхний сууриас орой тийш чиглэсэн уртааш тэнхлэгтэй тохирч байдаг. Энэ тэнхлэг нь стандарт I-р холболтын буюу зүүн тийш хандсан хэвтээ тэнхлэгтэй өнцөг үүсгэснийг альфа өнцөг гэнэ. Практикт ЗЦТ-ийг альфа өнцгөөр илэрхийлэх ба эрүүл хүнд $+40^\circ - +70^\circ$ гэж үзэх боловч 0° -аас $+90^\circ$ -ын хооронд хэлбэлзлэлтэй байж болно. Альфа өнцөг үүсгэлтээр нь ЗЦТ-ийн $0^\circ - +40^\circ$ -ыг хэвтээ, хагас хэвтээ, $+40^\circ - +70^\circ$ -ыг үндсэн, $+70^\circ - +90^\circ$ -ыг хагас босоо, босоо байрлал гэж үзэхээс гадна $0^\circ - -30^\circ$ байвал зүүн хазайлт, -30° -аас бага (-90° хүртэл) бол хэт зүүн хазайлттай, $+90^\circ - +120^\circ$ байвал баруун хазайлт, $+120^\circ$ -аас их (180° хүртэл) бол хэт баруун хазайлттай байрлал гэж тодорхойлдог. ЗЦТ нь зүрхний булчингийн зөвхөн электрофизиологийн процессын тусгал учраас оношийн холбогдлын үүднээс авч үзэхдээ цээжний хөндийд байрлаж байгаа зүрхний анатомийн байрлалтай адилтгаж болохгүй.

Орон зайн хувьд фронталь хавтгайд тусгал нь илрэх стандарт болон мөчний хүч нэмэгдүүлсэн нэг туйлт холболтуудад ЗЦТ-ийг тодорхойлох үйлдэл хийнэ. Ингэхдээ тосгуурын сэрлийн тусгал P шүд, ховдлын сэрлийн тусгал QRS , ховдлын реполяризацийн тусгал T шүд тус бүрийн цахилгаан тэнхлэгийг тодорхойлох боловч ховдлын иж бүрдлийн тэнхлэгээр ЗЦТ-ийг тогтооно. ЗЦТ-ийн үндсэн байрлалын үед ховдлын иж бүрдлийн R шүдний амплитудын харьцаа $R_{II} > R_I > R_{III}$, баруун хазайлтын үед $R_{III} > R_{II} > R_I$, зүүн хазайлтын үед $R_I > R_{II} > R_{III}$ байна.

ЗЦТ-ийн байрлал ба хазайлтыг дурдсан холболтуудын тусгалын R , S шүдний амплитудын хэмжээ, харьцааг үндэслэн хүснэгтээс харж тодорхойлохоос гадна ЭКГ дээр нүдээр харж шууд тодорхойлж болох зарим байрлал байдаг. Альфа өнцөг $+90^\circ$ буюу ЗЦТ эгц босоо байрлалын үед $R_{II} = R_{III} > R_I$, $R_I = S_I$ байх ба aVL тусгал дээр rS , aVF тусгалд R шүд өндөр бичигдэнэ. Альфа өнцөг $+60^\circ$ байрлалтай үед R шүдний харьцаа $R_{II} > R_I > R_{III}$ байхаас гадна таних гол үзүүлэлт нь aVL тусгалд $R = S$ байна. ЗЦТ $+30^\circ$ -ын байрлалын үед $R_I = R_{II} > R_{III}$, $R_{III} = S(Q)_{III}$ байна. Альфа өнцөг 0° -тай тэнцүү үед $R_I > R_{II} > R_{III}$, $S_{III} > R_{III}$ байх ба таних гол үзүүлэлт нь aVF тусгалд $R = S$ байна. Альфа өнцөг -30° -тай тэнцүү үед $R_I > R_{II} > R_{III}$, $S_{III} > R_{III}$, aVL тусгалд өндөр R , aVF тусгалд $S > R$ байхаас гадна таних гол үзүүлэлт нь $R_{II} = S_{II}$ гэх мэтчилэн байна.

Үүнээс гадна зүрхний байрлалаас шалтгаалж альфа өнцгөөр илэрхийлэгдэхгүй ЗЦТ байдаг. Тухайлбал стандарт гурван холболтын тусгалуудад тод гүнзгий S шүд бичигдэхийг $S_I S_{II} S_{III}$ хэлбэрийн байрлал гэж тодорхойло ба энэ нь зүрхний орой ар тийш эргэлттэйг харуулна. $S_I S_{II} S_{III}$ хэлбэрийн байрлал нь ихэвчлэн уушгины өвчнүүд (эмфизем, пневмосклероз, уушгины зүрх зэрэг), баруун ховдлын гипертрекси үед тохиолдохос гадна эрүүл хүнд

ялангуяа астеник галбиртай хүмүүст бичигдэж болно. Зарим тохиолдолд ЗЦТ-ийн $Q_1 Q_{II} Q_{III}$ хэлбэрийн байрлал байж болох бөгөөд энэ нь зүрхний орой урагш эргэлттэйг харуулна.

Эрүүл хүмүүст үндсэн байрлалаас гадна зүүн ба баруун хазайлт тодорхойлогдож болно. Гиперстеник бие галбиртай болон таргалсаанаас өрц өргөгдсөн эрүүл хүмүүст ЭКГ-ийн бусад өөрчлөлтгүйгээр бага зэргийн зүүн хазайлт бичигдэж болно.

Бага настын хүүхэд болон астеник бие галбиртай хүмүүст бага зэргийн баруун хазайлт бичигдэх нь элбэг байна. Иймд ЗЦТ-ийн дан баруун ба зүүн хазайлтыг зүрхний булчингийн эмгэг өөрчлөлтийн шинж гэж үзэхгүй боловч ЭКГ-ийн бусад өөрчлөлтийг харгалзах хэрэгтэй.

ЗЦТ-ийн босоо байрлал, баруун хазайлт нь баруун ховдлын гипертрофи, Гисийн багцны баруун хөлийн хоригийг үүсгэж болох өвчинүүд тухайлбал бага эргэлтэд даралт ихэсгэх уушгины архаг өвчинүүд, зүрхний митраль хавхлагийн нарийсал гажиг, ховдол хоорондын таславчийн цоорхой, тосгуурын таславчийн цоорхой, уушгины артеријн нарийсал, Фаллогийн дөрвөл зэрэг зарим гажгуудын үед тодорхойлогдоо гадна кардиосклероз, зүрхний шигдээс, цусны даралт ихсэх өвчиний үед тодорхойлогдож болно. Харин хэт баруун хазайлт нь баруун ховдлын гипертрофи, Гисийн багцны баруун хөлийн хоригийг харуулах тод шинж тэр бэлгон болж чадахгүй.

ЗЦТ-ийн хэвтээ байрлал, зүүн хазайлт нь зүүн ховдлын гипертрофи, Гисийн багцны зүүн хөлийн хориг үүсгэх өвчинүүд тухайлбал зүрхний булчингийн ялангуяа зүүн ховдлын булчингийн үрэвсэлт болон хатуурал бүхий эмгэг өвчинүүд, шигдээс, даралт ихсэх өвчин, митраль хавхлагийн дутагдал, аортын хавхлагийн гажигууд зэргийн үед тодорхойлогдоно. ЗЦТ-ийн хэт зүүн хазайлт нь зүүн ховдлын гипергрэфи, Гисийн багцны зүүн хөлийн хоригийг харуулах тод шинж биш болно.

ЗЦТ-ийн хэт зүүн ба баруун хазайлт нь ихэвчлэн Гисийн багцны хөлийн салаанудын хоригийн үед тодорхойлогдоно. Тухайлбал альфа өнцөг -60° ба үүнээс бага байх нь Гисийн багцны зүүн хөлийн урд салааны хоригийг илэрхийлэх тод шинж юм. Энэ үед ЭКГ-ийн шүднүүдийн харьцаа $R_I > R_{II} > R_{III}$, $S_{III} > R_{III}$, $S_{II} > R_{II}$, $R_{aVR} \geq Q(S)_{aVR}$ байна. Гисийн багцны зүүн хөлийн урд салааны хориг нь зүрхний цус тасалдах архаг өвчин, ялангуяа зүүн ховдлын урд хана, ховдол хоорондын таславчийг хамарсан кардиосклероз, шигдээс, зүрхний булчингийн үрэвсэлт өвчинүүдийн үед тохиолдоно. Мөн зүүн ховдлын тэлэгдэл томролтод хүргэх өвчинүүд болон дамжуулах системийн склероз, кальциноз өвчиний үед бичигдэж болно.

ЗЦТ-ийн хэт баруун хазайлт буюу альфа өнцөг $+120^\circ$ -аас их байх нь Гисийн багцны зүүн хөлийн хойт салааны хоригийг илэрхийлэх тод шинж юм. Энэ үед ЭКГ-ийн шүднүүдийн харьцаа $R_{III} > R_{II} > R_I$, $S_I > R_I$, $R_{aVR} \geq Q(S)_{aVR}$ байна. Гисийн багцны зүүн хөлийн хойт салааны хориг нь ихэвчлэн зүрхний цус тасалдах архаг өвчин, зүүн ховдлын арын ханын шигдээс, дамжуулах системийн склероз, кальциноз өвчиний үед тодорхойлогдоо гадна уушгины архаг өвчиний улмаас нөхцөлдөх баруун ховдлын гипертрофи, зүрхний босоо байрлал, декстрокарди, Вольфа-Паркинсон-Уайтийн хам шинжийн үед бичигдэж болохыг анхаарах хэрэгтэй.

ЕРӨНХИЙ МЭДЭЭ АЛДУУЛАХ

О. СҮХБААТАР (Анагаах ухааны хүрээлэн)

Шинжлэх ухаан техникийн дэвилийн эрин үед анагаах ухааны нарийн мэргэжлийн шинэ салбарууд хөгжиж, эмнэлгийн практикт орчин үеийн оношлогоо, эмчилгээний шинэ арга, багаж хэрэгслүүд нэвтэрч байна. Үүний нэг нь мэдээ алдуулах аргыг хэрэглэн дэлхийн хүн амын ихэнхэд нь тохиолдож байгаа зүрх судасны өвчинүүд, төрөлхийн ба одномл гажгийг засах нарийн төвөгтэй хагалгаа хийж олон хүний амь насыг эдгэшгүй өвчинеос аварч байгаа явдал юм.

Эрт дээр үеэс хүн төрөлхтөн "Мөнхийн усны" тухай мөрөдөн өвчдөлтгүй болгох, ухсэн хүнийг сэхээн амьдруулах аргыг эрэн сурвалжиж байжээ. Тийм мөрөдөл оюун ухаантны сэтгэл санааг эртиээс өзэмдсээр танин мэдэхүйн материалыст диалектик судалгааны аргын үр дүнд шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоогдож анагаах ухааны шинэ салбар мэдээ алдуулах сэхээн амьдруулах (Аnestезиология-реаниматология) шинжлэх ухаан болон хөгжиж байгаа билээ. Амид бие махбодын амьдралын үйл ажиллагаа нь хүрээлэн байгаа орчны харилцан үйлчлэлийн дор явагддаг. Гэтэл аливаа шалтгаанаар гэмтэл учрах физик-химийн хучин зүйлүүд болсны яз бүрийн өвчин бие махбодод хортойгоор үйлчилснээс өвддэг. Хэрэв өвдехийг зогсоохгүй бол амь насандааюултай хүндрах нь цеенгүй билээ. Өвдехийг ялах гэдэг нь эмгэг процессыг ялна гэсэн үг юм гэж тун оновчтой тодорхойлсон байдаг. Хагалгаа хийх үед мэдээ алдуулах нь анагаах ухааны чухал асуудлын нэг болж байна. Хагалгаа нь өвчинийг мэс заслын аргаар эмчлийн өвчтөнийг өвчинеос ангижруулдаг хэдий боловч хагалгааны өвдехийг дараахгүй бол бие махбодод гажуу нөлөө үзүүлж хүндрэлийн шалтгаан болох нь цөөнгүй.

Манай си тоослос 5—5 мянган жилийн өмнө Эберсийн мууту цаасанд опий мандрагор, белладоныг шингээж хэрэглээд өвчингүй болгосон тухай мэдээлсэн байдаг. Анх Кордус хүхрийн хучин ба архинаас эфирийг синтезээр гарган авч, 1540 онд Парацельс өфир нь өвчин дарах шинж чанартай болохыг тогтоосон байна.

Английн эрдэмтэн Гикмана азотын дутуу ислийн өвчин намдаах, сэтгэл сэргээх үйлчилгээг илрүүлэн "Хөгжөөгч хий" гэж нэрлэжээ. 1844 онд Х. Уэлса азотын ислийн өвчингүй болгох чанарыг өөртөө түршин шүдээ авч байсан бол эрдэмтэн Тамос Мортон 1846 онд анх нийтийн өмнө эфириэр мэдээ алдуулан хавдарт хагалгаа хийснээр ерөнхий мэдээ алдуулах эх үндсийг тавьжээ.

1847 онд оросын алдарт мэс засалч эрдэмтэн Н. И. Пирогов Эфирийн мэдээ алдуулах аргыг дайны талбарт хэрэглэж мэдээ алдуулах үеийн клиникийн сицлогийг шинжлэх ухааны үндэслэлтэй судлан тогтоогоод аппарат хэрэгслийг зохион бүтээж эфирийн мэдээ алдуулах аргыг хэрэглэн ихээхэн амжилт олжээ. Ийнхүү мэдээ алдуулах алба үүсэж улмаар хөгжин хүний амь нас аврах найдвартай шинэ салбарын нэг болжээ. С. К. Кликович, Эндрюс нар 1868 онд хүчилтерөгчийг анх мэдээ алдуулахад хэрэглэж Тренделенбург мэдээ алдуулан могоөрсөн хоолойд гууре тавих аргыг клиникийн практикт нэвтрүүлсэн нь хагалгааны үед хийн

солилцоог хэвийн байдалд байлгах хүчилтөрөгчийн дутагдлаас урьдчилан сэргийлэх, өвчтөний ямар ч байрлалд хагалгаа хийх боломжийг олгоход онцгой ач холбогдолтой болсноос гадна анестезиологийн шинжлэх ухааныг цаашид хөгжүүлэхэд чухлаар нелөөлөв.

1902 онд Н. П. Кравков, С. П. Федоров нар гедонаалыг венийн судсаар хийж амьсгалын бус замын мэдээ алдуулах аргыг эхлэн хийжээ. Хагалгааны үед мэдээ алдуулахыг удирдан явуулах, эрхтэн системийн үйл ажиллагааг хэвийн байдалд байлгах ба хянах, мэдээ алдуулах бодисын тун хэмжээг нарийн тооцоогох, хагалгааны үед гарсан эмгэг өөрчлөлтийг илрүүлэн засах хүндрэлээс урьдчилан сэргийлэх өвчтөний биед аюулгүй байдлыг хангаж хагалгаа хийх бүрэн тохиromжтой нөхцлийг мэс засалчдад бүрдүүлж өгөх хариуцлагатай үүргийг өндөр мэргэжлийн анестезиологч нар гүйцэтгэж байна.

Орчин үеийн ерөнхий мэдээ алдуулах нь амьдралын амин чухал эрхтэнүүдийг шилжүүлэн суулгах, зүрхний булчингийн зарим хэсэг, хавхлага, гол судсыг нийлэг өдээр орлуулах, мэдрэлийн мэс засал, жирэмсэн эхчүүдийг өвдөлтгүй торуулэхийг шийдвэрлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна.

Манай оронд 1956 он хүртэл бүх төрлийн хагалгааг А. В. Вишневскийн хэсгийн мэдээ алдуулах аргаар амжилттай хийж байсан боловч энэ арга хагалгааны үед өвчтөний биед аюулгүй байдлыг бүрэн хангаж чадахгүй байснаас хүндрэл гарах нь цөөнгүй байжээ. Тэр үед ЗХУ болон бусад оронд хөгжиж байсан ерөнхий мэдээ алдуулах аргыг өөрийн орны нөхцөлд хэрэглэх, хөгжүүлэх талаар санаачлага гарган ажилласан хумуусийн нэг нь академич Т. Шагдарсурэн юм.

Мэдээ алдуулах бодисыг клиникийн практикт хэрэглэх, ЗХУ-ын болон бусад орны мэргэжилтэн урьж ирүүлэх, тэднээс суралцах, үндэсний мэргэжилтэн бэлтгэх ажлыг уйгагүй хийж 1959 оноос ерөнхий мэдээ алдуулах аргыг өргөн хэрэглэдэг болжээ.

Уушги, улаан хоолойн янз бүрийн хагалгаанаас гадна Академич Т. Шагдарсурэн 1960 онд өвчтөн "Н"-д ерөнхий мэдээ алдуулах аргаар зүрхний 2 хаваст хавхлагын нарийсалтыг тэлж зурхний анхны хагалгааг хийсэн нь тус оронд зурхний мэс засал хийх боломжийг нээсэн юм.

Сүүлийн 10 гаруй жилд манай оронд зүрх судасны мэс засал амжилттай хөгжиж төрөлхийн ба олдмол гажгийг мэс заслын аргаар эмчилж анагаах ухааны хөгжилд зохих хувь нэмрээ оруулж байна.

Ямар нэг шалтгаанаар хүний цусны эргэлт зогсоход юуны түрүүнд уураг тархины эс үхдэг ба энэ нь 5 минутаас дээш хугацаагаар үргэлжилбэл өвчтөн үхэхэд хүрнэ.

Эрдэмтдийн судалгаа шинжилгээнээс үзэхэд бага температурт бие махбодын бодисын солилцоо удааширч хүчилтөрөгчийн хэрэгцээ буурдаг байна. Биеийн температурыг зохиомлоор 30 градус хүртэл буулгахад цусны эргэлт 8—10 минут зогсож болох бөгөөд уураг тархины эд эс ба амь насанд аюулгүй байдаг нь нотлогджээ.

Анагаах ухааны практикт бага температурын энэ нөлөөг ашиглан зарим овчнийг эмчлэх, зурхний таславч хоорондын цоорхойг оёх ба нөхөх, хавхлагын нарийслийг тэлэх зэрэг хагалгааг цусны эргэлтийг түр зогсоон "нээлттэй" зурхэнд хийж байна.

Зурх, уушги, мэдрэл, бусад нарийн төвөгтэй хагалгаа хийхэд мэдээ алдуулах тохиromжтой онцлог нөхцөлийг урьдаас бүрдүүлэх, хагалгааны дараа эрхтний үйл ажиллагааг хэвийн байдалд

шилжүүлж тэнцвэртэй болгох, өвчтоний амь насыг аврахад анестезиологи-реаниматологи шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж байна.

Одоо манай улсад өрөнхий мэдээ алдуулах нь шинжлэх ухааны хөгжлийн орчин үеийн түвшинд хийгдэж байгаа пь анагаах ухааны шилдэг ололт амжилтуудын нэг болов.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. Б. Дэмбэрэл, М. А. Ибрагимов — Очерки по истории развития здравоохранения МНР М., Медицина., 1977.
2. И. С. Жоров — Общее обезболевание. М., 1964.
3. Е. Н. Мешалкин, В. П. Смольников — Современный ингаляционный норкоз. М., 1959
4. Т. Шагдарсүрэн — Зүрхний зарим төрөлхийн гажгийн клиник, онош эмчилгээ, УБ., 1970.
5. Т. Шагдарсүрэн, Ж. Моондой — Мэс заслын өвчинүүд. УБ., 1980.

Редакцийд ирсэн 1985. 03. 10.

ТУРШЛАГА СОЛИЛЦЬЁ

ТЭРГҮҮН ТУРШЛАГА НЭВТРҮҮЛЭХ АСУУДАЛД

Хүн амын эрүүл мэндэд нөлоөлдог биологи, анагаах ухааны хүчин зүйлийг гүнзгий судалж, орчин үеийн ололт, нээлтийг эмнэлэг, үйлчилгээний ажилд түштэй нэвтрүүлэх нь бидний чухал зорилт мөн.

ЗХУ болон социалист бусад орны эх нялхас, эмнэлгийн байгууллагын тэргүүн туршлагыг бүтээлчээр эзэмших нь эмчилгээ үйлчилгээнд ондөр амжилт гаргахын нэг үндэс юм.

Эрүүлийг хамгаалахад нэвтэрч байгаа тэргүүн туршлага, шинжлэх ухаан-техникийн ололтын зонхилох нь аливаа овчлелээс урьдчилан сэргийлэх, эмчлэх, оношлох аргыг боловсронгуй болгох, чанарыг сайжруулах, үр дунг нэмэгдүүлэхэд чиглэгддэг. Сүүлийн жилүүдэд эмчилгээ,, онцшлогоонд илүү ашигтай, үр дүнтэй арга цөөнгүй нэвтэрч байна. 1981 оноос ургийн усыг шинжлэн бүтэлтийг эрт оношлох, хүүхдийн байрлалыг зов тодорхойлох, хүүхдийн зарим эмгэг, цул эрхтэний өвчнийг эрт оношлоход хэт дуун авиан шинжилгээг хэрэглэж байна. Эдгээр нь цус алдах, хүүхдийг төрөхийн аливаа гэмтлээс сэргийлэхээс гадна төрөхийн хүндрэлийг бууруулахад сайн үр дүнтэй юм.

Хүүхдийн боөрний өвчнийг илрүүлэх „хурдавчилсан“ аргыг практикт нэвтрүүлэв. Үүний үр дунд уг өвчнийг эрт оношилж, хүндрэлээс сэргийлэх боломжийг нэмэгдүүлж цаг, хүч хэмнэж байна.

Улсын хүүхдийн клиникийн тов эмнэлэгт хүүхдийн уушгины стафилококт үрэвслийг оношлох эмчилгээний бурдмэл арга, сонсогол муутай хүүхдийн хэл яриаг засах, цэцэрлэгийн наслын хүүхдийн сонсоголын гажгийг эмчлэх аргуудыг нэвтрүүлж байгаа нь үр дүнгээ өгч байна.

Гэмтэл согогийн эмнэлэгт ЗХУ-ын профессор А. Г. Илизаровын нээлт, туршлагыг судалж хугарсан ясьг эвлүүлэн эмчлэх аргыг ажилдаа түштэй нэвтрүүлснээр эмнэлэгт өвчтон хэвтэх, эдгэрэх хугацааг эрс богиносгов.

Манай эмч нар тархинд цус хурах өвчнийг мэс заслын аргаар эмчлэх, тархи, нугасанд мэс засал хийх үед цус тогтоох, гавлын ясны гэмтлийг засах, нөхөх зэрэг 20 гаруй шинэ арга хэрэглэж чаддаг болов. Хавдар судлалын нэгдсэн төвд улаан хоолой болон бусад эрхтэний зарим хавдрыг завсарлагаатай шарах аргыг практикт нэвтрүүлэв.

Хүүхдийн зурхний төрөлхийн гажиг, насанд хүрэгчийн зурхний хавхлагын олдмол гажгийг оншдох, „нээлттэй“, „хуурай“, зурхэнд хагалгаа хийх үед цусны зохиомол эргэлт бий болгох, бисийг хоргөх аргыг хэрэглэж байна.

Орон нутгийн болон байгалийн нөөц бололцоог ашиглаж элэг, цөсний өвчнийг анагаахад „бэрхэсазин“, цус тогтоох үйлчилгээтэй „алтан утас“, аржирмин шарх анагаах „алюметкатин“ зурхний эмгэгийг эмчлэх „алтан хундаа“ биеийн тэнхээ тамирыг сайжруулж сэргээх үйлчилгээний „дендронизид“ зэрэг 10 гаруй шинэ эм, хуурай сийвэн, альбумин, антистафилококкин гаммаглобулин үйлдвэрлэн, эмчилгээний практикт үр ашигтай хэрэглэж байна.

Анагаах ухааны удамшил зүйн шинэ салбар амжилттай хөгжиж, хүний хромосомыг хялбар аргаар тодорхойлдог болсон нь, удамшин дамжих өвчнөөс сэргийлэхэд нэндээ холбогдолтой юм. Мөн радио изотопын аргаар цул эрхтэний байдлыг тогтоох, зүрх, тархины цэхилгаан бичлэг, зүрх сэтгүүрдэх, хөндий эрхтэн дурандах ходоодны шүүсийг хаймсургуйгээр авах зэрэг оношлох аргыг олон эмнэлэгт хэрэглэх болов.

Үлсын клиникин төв эмнэлэгт даралттай хүчилтөргөөр эмчлэх барокамерын тасаг, нүдний өвчнийг лазери түяагаар эмчлэх, хэвлэлийн хөндийн эрхтэнүүдийн эмгэг, судасны төрөл бурийн өвчний оношлох кабинетуудыг байгуулах ажил үндсэндээ хангалттай болов. Энэ нь орчин үеийн ангаах ухааны ололтыг өөрийн орны эмнэлгийн практикт нэвтрүүлэхэд том алхам болж байгаа юм. Люменесценцийн микроскоц, спектрофотометр дархан түяарлалт бичил харуурын аргаар эсрэг бие илрүүлэх зэрэг аппарат багаж, шинжилгээний арга хэрэгслийг өргөн нэвтрүүлснээр шинжилгээний чанар дээшилж, оношлогоо сайжрав. Үүний зэрэгцээ бөөр орлох, хөндий эрхтэн дурандах, эс молекулын түвшинд оношдох лабораторийн аргууд нэвтрэв. Жил бүр шинэ бүтээл оновчтой саналын үзэсгэлэн гаргаж өөрийн орны эрүүлийг хамгаалах байгууллагын тэргүүний хамт олон, хүмүүсийн туршлагыг нэвтрүүлж байгаагийн зэрэгцээ гадаад орнуудад явж туршлага судалсан хүмүүсийн ажилдаа хэрэглэсэн, санаачилсан зүйлээр үзэсгэлэн байгуулж, улмаар нийтийн хүртээл болгож байна.

Эмнэлгийн практикт орчин үеийн ангаах ухааны нээлт, ололтын зэрэгцээгээр биологи, физик, хими зэрэг шинжлэх ухааны ололт нэвтэрч байх ёстой.

Тэргүүн туршлага бүх нийтийн хөдөлгөөн болон хөгжих нь нийгмийн хөгжлийн зүй тогтол юм. Зарим үед тэргүүн туршлага, ажлын тэргүүний арга хэлбэрийг нэг түвшинд тавьж „тэргүүн туршлага“ гэж тайлан мэдээ гэрвэх хандлага байна. Тэргүүн туршлага нэвтрүүлэх ажлыг дутуу үнэлэх, түүнд ёс төдий ханддах, хашин хойрго байх, хоосон яриа болгож төлөвлөгөө, жагсаалт гаргаснаар ажлаа хязгаарладаг дутагдал бол тэргүүн туршлагын ач холбогдол, үр ашгийг бүрэн сайн ухамсарлаж ойлгоогүйтэй холбоотой юм.

Эмч, эмнэлгийн ажилтан, ажилчдын хөдөлмөрийг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулахад ЗХУ болон социалист бусад орны эмнэлгийн байгууллагын туршлага, ололтыг уламжлуй нэвтрүүлэх хэрэгтэй байна.

Тэргүүн туршлага нэвтрүүлэх ажлыг дараах үе шаттайгаар нэвтрүүлэх нь зүйтэй юм. Үнд:

[a/үе шат]

[б/үе шат бүрт зохиох ажлын чиглэл]

олж илрүүлэх ба мэдээлэх

—туршлагаа сонгох
—нэвтрүүлэх объектöö тогтоох
—сонгож авсан туршлагад хувийн хэрэг нээх.
—сонин хэвлэл, суртал нэвтрүүлгийн олон хэлбэрийг ашиглаж мэдээлэх.

судлах

— нэвтрүүлэх объект дээр нь хичээл заах
— үзүүлэх сургууль хийх
— холбогдох материал ном, хэвлэл ашиглах

төлөвлөх

- нэвтрүүлэх аргаа сонгон тогтоох
- нэвтрүүлэх объектын нөхцөл бололцоог судлах
- материалын ба зардлын тооцоо хийх
- аргачлалаа боловсруулж төлөвлөгөөг батлах

Бэлтгэлийг
хангах

- туршлага эзэмших хүмүүст туршлагын ач холбогдлыг сайтар ойлгуулах
- социалист уралдаанд үүрэг авахуулах
- туршлага эзэмших хүмүүст бүтээлч ба тодорхой даалгавар өгүүлэх.
- эд материалын болон оюун санааны шаардлагатай туслацаа үзүүлж урьдчилсан нөхцөлөөр хангах

Зохион байгуулж
ур дүнг сурталч-
лах

- туршлага эзэмших хугацаа дараалал тогтоох
- үр ашгийг тооцож мэдээлэх
- байнгын хяналт тавьж туслах
- явц, үр дүнг төв, орон нутгийн сонин хэвлэлд бичих.

зэрэг ажлуудыг зохион явуулах нь зүйтэй юм.

В.И. Лениний хэлснээр „..: манай гол зорилтыг биелүүлгэхийн тулд практик дээр туршиж, нэгэнт олсон үр дүнгээр шамгагдсан ажил хэрэгч арга хэмжээ арга барил, заалтуудыг аль "боловхор их болгох" тийм зарчмыг баримталж, тэргүүн туршлагыг судалж, дэлгэрүүлэх ажлыг зохиох явдал эмнэлэг урьдчилан сэргийлэх байгууллагын гол зорилт болж байна.

Дэд эрдэмтэн Н. Цэнд.
Их эмч Ч. Чулуунбаатар

Редакц ид ирсэн 1986—04—30

ХОВОР ТОХИОЛДОЛ

Т. ЭРХЭМБААТАР. (Клиникийн 1 амаржих газар)

УМАЙН ГАДУУРХИ ЖИРЭМСНИЙ НЭГЭН ХОВОР ТОХИОЛДОЛ

Хөврөл умайн дайврууд болон хэвллийн хөндийн ямар нэгэн эрхтэнд байрлаан хөгжихийг умайн гадуурхи жирэмсэн гэдэг. Умайн гадуурхи жирэмсэн гол төлөв умайн үрийн хоолойд байрлах боловч хааян хэвллийн хөндийн ямар нэгэн эрхтэнд байрлах тохиолдол байдаг. Үүнийг хэвллийн жирэмсэн гэнэ.

Хэвллийн жирэмсэн ховор тохиолдох боловч эхийн эрүүл мэндэд аюултай хүндэрэл болдог. Хэвллийн жирэмсэнг анхдагч, хоёрдогч гэж хуваана. Хэвллийн хөндийн ямар нэгэн, эрхтэнд хөврөл анхлан бэхлэгдэн байрлавал анхдагч хэвллийн жирэмсэн, хэвллийн хөндийд хөөгдөн байрлавал хоёрдогч хэвллийн жирэмсэн гэнэ.

Хэвллийн хөндийн жирэмсэн зарим үед хугацаа гүйцсэн жирэмсний хэмжээнд хүрч болно.

Умайн гадуурхи жирэмсний дотроос нэн ховор тохиолддог хэвллийн жирэмсний тухай товч огуульье.

Л.Ш. 55 настай, овчний түүх №0055. 1986 оны 1-р сарын 14-ны 22 цаг 15 минутанд клиникийн 1 амаржих газрын өмэгтэйчүүдийн 1 тасагт хөдөөнөөс шилжин ирж хэвтсэн. Хэвтэх үедээ тэмир тэнхээ муу, ам их хатна, хэвллийн доод хэсгээр хөндүүрлэж өвдөнө, шээсний сувээр хатгаж өвдөнө, шээс мэдээгүй гарна гэсэн зовиуртай байв.

Өвчтөний огүүлснээр 34 жилийн өмнө жирэмсэлж, жирэмсний хугацаа 9 сартай болсон боловч торөөгүй, яваандаа хүүхэд нь хөдлөхөө больж хэвллийн хэмжээ аажмаар багасжээ.

1985 оны 12-р сарын 10-наас эхлэн хэвллийн доод хэсгээр өвдөж, шээс мэдээгүй гардаг болсон учир сумын эмнэлэгт 19 хоног аймгийн нэгдсэн эмнэлэгт 4 хоног хэвтэж өмчлүүлээд сайжраагүй тул Улаанбаатар хотод шилжүүлжээ.

Өвчтөний биеийн байдал ядрангүй, арьс салст цайвар өнгөтэй, зүрхний авна тод жигд, судасны цохилт 1 минутанд 86 удаа, хүчдэл дүүрэлт сайн, уушгинд цүлцангийн амьсгалтай, хэвдийн зөөлөн; гялтан хальсны цочмог урэвслийн шинж тэмдэг тод илрэхгүй боловч хэл цайвар өнгөтэй, ял imgүй хуурайвтар байв.

Утрээний үзлэгээр гадна бэлэг эрхтэний хөгжил хэвийн, утрээ уужим, умайн хүзүү хаалттай, умай тодорхой тэмтрэгдэхгүй, бага аарцгийн хөндийд 20 долоо хоногийн жирэмсний хэртэй тэгш биш гадаргуутай ирмэгүүдтэй үүсвэр тэмтрэгдэж байв. Шээсний сув, хөшиногоор ургийн ясны хэлтэрхий мэт зүйл гарч байв. Бор саарал өнгийн эхэстэй тэстэй зүйл шээсний сувээс цухуйж харагдана. Толиор шинжлэхэд умайн хүзүү цэвэр, ялгадасгүй байлаа.

Эмч нарын хамтарсан үзлэг хийж өвчтоний өгүүлэл, бодит үзлэгт илэрсэн байдлыг үндэслэн хэвллийн хөндийн жирэмслэлт, давсаг-хэвллий-шулууун гэдэсний доорол, хордлого, цус багадалт гэж оношилж хагалгаа яаралтай хийхээр шийдвэрлэв.

1986—1—16-нд өрөнхий мэдээ алдуулж хэвллийн хөндийг нээхэд давсагчын арын хана, шулуун гэдэсний урд ханатай нягт наалдсан, бага аарцгийн хондий дэх үүсвэрт ургийн яс болон бусад хэсэг тэмтрэгдэж байлаа. Уг үүсвэрийн бүх талаас бүдүүн гэдэс, сэмж, давсаг тойрч бүрхэн гэр маягтайгаар хучиж наалджээ.

Давсаг бүдүүн гэдэсний хананы наалдцыг хүрц аргаар салгаж, бага аарцгийн хондийг нээхэд борсаарал онгийн шингэн, ургийн ясныүүд, эхэстэй төст зүйлс байсныг авлаа. Ургийн ясны байдлаас үзэхэд 9 сартай (36 долоо хоногтой) ураг байжээ гэж үзэх үндэстэй байв. Давсагны арын хананд 8 см хэмжээний, мөн S хэлбэрийн гэдсэнд 10 см цоорол тус тус үүссэн байв. Давсагны цоорхойг битүүлэн оёж, харин S хэлбэрийн гэдсэнд өөрчлөлт нэвчдэл ихтэй байсан учраас түүнийг тайрч дээд, доод талын төгсгөлийг хэвллийн зүүн хажууд нь гаргаж тус тусад нь бэхлэн оёлоо. Умайн ондгөөчинд уйланхайцаар байсныг авлაа.

Ийнхүү өвчтөнд эхлэж тавьсан онош хагалгаагаар бүрэн нотлогдов. Өвчтон хагалгааны дараа 22 хоног эмчлүүлээд Улсын клиникин тоз замнэлэгт дараах шатны эмчилгээг үргэлжлүүлэхээр шилжив.

Хэвллийн жирэмслэлт хааяа тохиолдох боловч иймэрхүү хүндэрсэн тохиолдол нэп ховор тохиолддог билээ.

Энэ байдлаас үндэслэн эх барих-эмэгтэйчүүдийн эмч нар хэвлийн жирэмсээг зөв оношлож, холбогдох эмчилгээг цаг алдалгүй хийх шаардлагатай байна.

Редакцид ирсэн 1986—02—28.

ЭРДЭМТДИЙН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

С. МАНЛАЙ (Хүүхдийн клиникийн төв эмнэлэг)

БНМАУ-ЫН СУРГУУЛИЙН СУРАГЧДЫН ХАРААНЫ БАЙДАЛД ХИЙСЭН ЭМНЭЛ ЗҮЙ, ЭРҮҮЛ АХУЙН СУДАЛГААНЫ ЗАРИМ АСУУДАЛ

ДҮГНЭЛТ: 1. Сурагчдын хараа муу байгаатийн гол шалтгааныг нүдний гэрэл хугарлын төрөл бүрийн гажиг (20,2%) эзэлж байна. Судалгаанд хамрагдсан бүх хүүхдийн дотор тохиолдлоороо ойрын хараа хугарал (миопи) 8,3%, зоруу хугарал (астигматизм) 6,5%, холын хараат хугарал (гипермерон) 5,5% тус тус эзэлж байна. Хугарлын гажгийн дотор ойр хараа 41,3%, зоруу хараа 32,4%, хол хараа 26,3%-ийг эзэлж байна.

2. Хүүхдийн анги ахих тутам хугарлын гажгийн үндсэн хэлбэр болох ойр хараат хугарал нь нэмэгдэж, хол хараат хугарал нь багасаж байгаа нь зүй тогтлын дагуу гэж үзэж байна.

3. Ойр хараат хугарлын хуч 3,0 Д хүртэлх хенгэн хэлбэрээр тохиолдож (биологийн вариант) 89,6% эзэлж байна. Харин (—) 6,0 Д-с дээш хүнд хэлбэр 2 хувийг эзэлж байна.

4. Хугарлын гажигтай хүүхдийн дотор 62,5%-ийг охид эзэлж байгаа бөгөөд энэ нь ойр хараат гажиг зонхицж байна. Хол хараат гажигт нас хүйсний ялгаа ажиглагдсангүй.

5. Хүүхдийн нас ахих тутам ойр хараат гажиг ихсэж байгаа нь аль ч хүйсэнд тохиолдох ерөнхий зүй тогтол боловч охидод хөвгүүдээс 1—2 насаар эрт илэрч байна.

6. Газар нутгийн байршилтаар авч үзэхэд хугарлын гажиг ялангуяа „ойр хараат хугарал“ Улаанбаатарт 1000 хүүхэд 109,2, аймагт 62,3, суманд 36,1 тохиолдож байгаа нь нүдний энэ гажиг хот суурин газар хөдөөгөөс 1,8 дахин их байгааг харуулж байна.

7. Судалгаанд хамрагдсан хот хөдөогийн сургуулиудад байгалийн гэрэлтуүлэг сайн байлаа.

8. Судалгаанд хамрагдсан 2—3 ээлжтэй ихэнх сургуулиудад чухал шаардлагатай байдаг зохиомол гэрэлтуүлгийн хэмжээ эрүүл ахуйн нормативтэй тохицохгүй байна.

9. Сурагчдын ажиллаж амьдардаг гэр орон, сууцанд байгалийн ба зохиомол гэрэлтуүлгийн хэмжээ нормативт хэмжээнээс бага байна.

10. Ойр хараат хугарал нь гэрэлтуүлэгтэй шууд холбоотой нь тогтоогдоогүй боловч гэрэлтуүлэг хараанд нөлөөлөхгүй гэсэн дүргэлт биш билээ.

11. Сурагчдын дунд асуултын аргаар судалгаа хийж үзэхэд сурагчдын одрийн дэглэм сахих, үншиж бичих, телевизор үзэх зэрэгт эрүүл ахуйн хамгийн энгийн дэглэм алдагдсан байна. Судалгаанаас үзэхэд хүүхдүүдийн 11 хувь нь халдварт овчинеэр өвчилж байсан, 35 хувь нь сийрын төрөл байв.

ЗӨВЛӨМЖ: 1. Хүүхдийн хараа хамгаалахад авах арга хэмжээний талаар нэгдсэн толөвлөгөө хийж хүүхдийн нүдний тусламжийн норматив боловсруулах;

2. Улаанбаатар хотод хүүхдийн хараа хамгаалах бүх асуудлыг хамарсан улсын хэмжээний зохион байгуулалт-аргаачлалын төвийн үүрэг гүйцэтгэхүйц хараа хамгаалах тусгай кабинетыг байгуулан ажиллуулах;

3. Хүүхдийн харааны шилний шаардлага ба хэрэгцээ хангамжийг цаашид судлах нь зүйтэй байна.

Редакцид ирсэн 1985—05—04.

Г. БАТМӨНХ (Анагаах ухааны дээд сургууль)

БНМАУ-ЫН ӨНДӨР УУЛЫН БҮСЭД ОРШИН СУУГЧ НУТГИЙН ХҮМҮҮСИЙН ЗҮРХ СУДАСНЫ СИСТЕМИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТИЙН ОНЦЛОГ

ДҮГНЭЛТ: БНМАУ-ын цаг уур, газар зүйн өөр өөр бүсд оршин суугч нутгийн хүмүүсийн зүрх судасны системийн физиологийн зарим үзүүлэлтийг судлахдаа нам уулын бүсээс Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хотыг, бэсрэг уулын бүсээс Улаанбаатар хотыг, өндөр уулын бүсээс Говь-Алтай аймгийн Алтай хот, Архангай аймгийн Хангай сумыг тус тус төлөөлүүлэн авч нутгийн 20—70 насны 3174 хүний артер, венийн даралт, хялгасан судасны ханааны нэвтрэх чанар, судасны цохилтын тоо, зүрхний цахилгаан бичлэгийн зарим онцлогийг судлан хэвийн хэмжээний зааг ба дундаж хэмжээг тогтоож, зүрх судасны системийн үйл ажиллагааны зарим онцлогийг илрүүлэн түүнийгээ П. К. Анохины үйл ажиллагааны системийн онолын үндсэн дээр биологи, анагаах ухаан дахь дэвшилтээ шинэ чиглэл болох системт хандлагын байр сууринаас үнэлж дараах дүгнэлт хийв.

1. БНМАУ-ын бэсрэг ба нам уулын бүсд оршин суугч нутгийн хүмүүсийн судасны цохилтын дундаж хэмжээ минутад $72 \pm 0,62$ байна.

2. Өндөр уулын бүсд оршин суугч нутгийн хүмүүсийн судасны цохилтын дундаж тоо минутад $75 \pm 0,52$ байна. БНМАУ-ын өндөр уулын бүсд оршин суугчдад судасны цохилтын тоо харьцаангуй олон байдаг бололтой.

3. Судалгаа хийсэн гурван бүсийн оршин суугчдын arterийн цусны их, бага даралт эрэгтэйд 89—163/57—103 мм, эмэгтэйд 85—165/55—103 мм мөнгөн усны баганатай тэнцүү байна.

4. БНМАУ-ын цаг уур газар зүйн онцлогийг бодолцон 20—70 насны хүний arterийн цусны их, бага даралтын хэвийн заагийг ($M \pm 2\sigma$) тогтоовол:

а) Нам уулын бүсд оршин суудаг эрэгтэйд 93—157/55—101 мм, эмэгтэйд 91—159/56—92 мм мөнгөн усны багана

б) Өндөр уулын бүсд оршин суудаг эрэгтэйд 88—166/57—105 мм, эмэгтэйд 85—169/58—104 мм мөнгөн усны багана,

в) Бэсрэг уулын бүсд оршин суудаг эрэгтэйд 88—162/58—100 мм, эмэгтэйд 85—163/53—103 мм мөнгөн усны баганатай тус тус тэнцүү байна.

5. Өндөр ба бэсрэг уулын бүсд оршин суугчдыг бодвол нам уулын бүсд оршин суугч, нутгийн хүмүүс arterийн цусны их, бага даралтын даралт багасалт статистикийн үнэн магадлалтай ($P < 0,01$) тогтоогдов. Arterийн цусны даралтын даралт ихсэх нь өн-

дер ба бэсрэг уулынханд нас хүйс харгалзахгүйгээр үнэн магадлалтай ($P<0,001$) илрэв.

6. Артерийн цусны их, бага дараалтын нягт дундаж хэмжээ ($M \pm \sigma$) нам уулын бүсийнханд $125 \pm 16,7 / 77 \pm 11,1$ мм, бэсрэг уулын бүсийнхэнд $125 \pm 19,1 / 79 \pm 11,4$ мм, ондөр уулын бүсийнхэнд $127 \pm 20,4 / 81 \pm 11,8$ мм судалгаа хийсэн турван бүсийн хүмүүст $126 \pm 18,9 / 79 \pm 11,8$ мм мөнгөн усны баганы түвшинтэй тус тус тэнцүү байна.

7. Ондөр уулын бүсийн нутгийн хүмүүсийн arterийн дараалтын дундаж хэмжээг бэсрэг ба нам уулынхантай харьцуулбал их байгаа нь үнэн магадлалтай ($P<0,05$) байв.

8. Венийн дараалтын нягт дундаж хэмжээ нам уулын бүсийнхэнд $80 \pm 2,5$ мм, бэсрэг уулын бүсийнхэнд $84 \pm 1,5$ мм, ондор уулын бүсийнхэнд $102 \pm 1,8$ мм, бүх турван бүсийнхэнд $90 \pm 3,8$ мм мөнгөн усны баганы ондортай тэнцүү байв.

Судлагдсан турван бүсийн хүний венийн дараалтын дундаж хэмжээ нийтээр хүлээн зөвшөөрсөн хэвийн хэмжээний дээд заагт (венийн дараалт 50—120 мм усны багана) байгаа ба газрын ондөр нэмэгдэх тутам венийн дараалтын дундаж хэмжээ нэмэгддэг нь үнэн магдлалтай ($P<0,001$) байв.

9. Хялгасан судасны хананы нэвтрэх чанарын дундаж хэмжээ нам уулын бүсийнхэнд шингэн $4,36 \pm 0,03$ мл, уураг $7,08 \pm 0,05\%$, дунд уулын бүсийнхэнд шингэн $4 \pm 26—0,01$ мл, уураг $6,34 \pm 0,03\%$, ондор уулын бүсийнхэнд шингэн $4,04 \pm 0,01$ мл, уураг $5,17 \pm 0,03\%$, судалгаа хийсэн бүх турван бүсийн хүмүүсийн шингэн $4,22 \pm 0,02$ мл, уураг $6,19 \pm 0,04\%$ байв.

Иймд БНМАУ-ын цаг уур, газар зүйн турван бүсийн нутгийн хүмүүсийн хялгасан судасны хананы нэвтрэх чанар нийтээр хүлээн зөвшөөрсөн хэмжээний дээд заагаар байна.

10. Нам, бэсрэг ба ондөр уулын нутгийн хүмүүсийн зурхний цахилгаан бичлэгийг судлахад зурхний баруун хэсэгт ачаалал ихэссэнийг тусган илтгэх зурхний цахилгаан тэнхлэгийн баруун тийш хазайлтыг тодорхойлон харуулж байгаа зурхний цахилгаан бичлэгийн үзүүлэлтүүдийн оөрчлөлтүүд нэлээд олон тохиолдов. Зурхний цахилгаан тэнхлэгийн баруун тийш хазайнсиг дундаж, хэмжээгээр тогтоовол:

- а) нам уул бүсийнхэнд α онцог $59,3^\circ \pm 1,4^\circ$
- б) бэсрэг уулын бүсийнхэнд α онцог $62,1^\circ \pm 1,6^\circ$
- в) ондөр уулын бүсийнхэнд α онцог $79,8^\circ \pm 1,6^\circ$
- г) бүх турван бүсийнхэнд α онцог $66,2^\circ \pm 0,9^\circ$ -тай тус тус тэнцүү байна.

11. Судлагдсан турван бүсийн нутгийн хүмүүсийн зурхний цахилгаан бичлэгийг оөр хооронд нь харьцуулан судалж үзвэл газрын ондөр нэмэгдэх тутам зурхний цахилгаан тэнхлэгийн баруун тийш хазайлтын тохиолдол нэмэгдэх хандлагатай нь илрэв.

12. БНМАУ-ын нам, бэсрэг ба ондөр уулын бүсд оршин суугч нутгийн хүмүүст бидний илрүүлж тогтоосон зүрх судасны системийн онцлогуудыг тухайн газрын цаг уур, газар зүйн тодорхой нөхцөлд явагдах дасан зохицох механизмын үр дүн гэж үзэх эрэгтэй.

13. БНМАУ-ын нам, бэсрэг ба ондөр уулын бүсд оршин суугч нутгийн хүмүүсийн зурх судасны системийн нэлээд хэдэн физиологийн үзүүлэлтээр гаргасан дээрх хэмжээнүүдийг эмч нар практикийн ба эрдэм судлалын ажилд хэрэглэх боломжтой гэж үзэж байна.

Редакцид ирсэн 1986—05—04.

И. С. МАРКОВ. Э. ПУРЭВДАВАА

ДАРХЛАЛЫН ОЛДМОЛ ДУТАГДЛЫН ХАМ ШИНЖ

Сүүлийн уед барууны орнуудад хүдэн мянган хүний амь насыг нэгэнт бүрэлгэж амжсан энэ нууцлагдмал овчиний „AJDS-ийн довтолгоон“ „ХХ зууны тарваган тахал“ „Шинэ цар тахал“, „Эмчилгээгүй овчин“ гэх зэргээр нэрлэн ихэд шуугиж, „Штерн“ „Лайф“ „Кеик“ гэх мат сэтгүүлийн хавтаснаа энэ овчиний золиос болж, одоо нэгэнт үгүй болсон хүмүүсийн зургийг хүртэл тавьж байна. Энэ овчин бүртгэгдэж байгаа орнуудад (ДЭХБ-ын мэдээгээр АНУ, Канад, ХБНГУ, Англи, Франц, Дани, Бельгий, Голланд, Норвег, болон Ази, Африк, Латин америкийн 40 гаруй оронд овчлол бүртгэгдээд байна) тарваган тахал, проказын адил үзэж байгаа бөгөөд ялгаа нь гэвэл хогжилтэй орнуудад тарваган тахал бараг бүрэн устсан байхад энэ овчин босгон дээр тулж проэд байгаад хэргийн учир оршиж байгаа аж.

Айх сандрах явдал газар авч, уг овчиноор овчилсан хүнийг улс орноос албадан зайлзуулах нэн хатуу дэглэмд тусгаарлахыг засаг захиргаанаасаа шаардаж, янз янзын санал тавьж байгаа нь цаашид ч нэлээд хугацаанд үргэлжлэх төловтэй байна.

AJDS-гэж нэрлэгдсэн, нууцыг нь одоогоор бүрэн тайлж чадаагүй байгаа энэ аюултай зүйл чинь чухам юу вэ?

Мэргэжилтийн үзэж байгаагаар (ЗХУ-д энэ асуудлаар профессор М. С. Балаян, халдварт судлалын эрдэм шинжилгээний төв институтын захирад академич В. И. Покровский, Дархлал судлалын эрдэм шинжилгээний институтын орлогч захирад Р. М. Хайтав нарын саналыг анхааран үзэж байна) ходөлбөргүй тогтоогдсэн баримт сэлт түүнчлэн олон янзын таамаглалаас энэ овчиний үнэн „нүүр царай будаг бадаг, бүрэн тодорхой биш байна. AJDS (Acquired Immune Deficiency Syndrome) буюу дархлалын олдмол дутагдлын хам шинж (ДОДХШ) гэж ЗХУ, (усад гарим сронд нэрлэж байгаа энэ овчин бол дархлалын системийг давуутай хамран гэмтээдэг, шинэ хурц халдварт овчин юм. Хүний бие маҳбод нь халдварт овчинийг үүсгэгч болон бусад харийн шинжтэй элдэв бодисын өсрэг дархлалыг (иммунитет) бий болгож, тэдгээр овчиноор овчлөхгүй байх, эдгэрэх, ерөөс амьдрах бололцоогоо хамгаалж чаддаг гайхамшигтай чанартай.

Дархлал хамгааллын онцлог, механизмыг судалж тогтоосон орчин үеийн ололтоос үзэхэд энэ тогс боловсронгуй системийн зүйл ажиллагаа хямарч өөрчлөгдөх нь ревматизм, рак, элэгний цирроз, чихрийн шижин, гломерулонефрит зэрэг оргон тархсан, хүнд овчинүүд үүсэхэд шууд нөлөөлдог болох нь тогтоогдоод байна. Түүнчлэн уушгины хатгалгаа, ангин, мухар олгойн үрэвсал, гепатит зэрэг овчиний явц, төгсгөл ямар байх нь ч дархлалын системийн байдлаас ихэхэн шалтгаалж байна. Гэтэл ДОДХШ энэ овчин чухамхүү бие маҳбодыг овчин үүсгэгч гаднын элдэв хүчин зүйлээс хамгаалдаг гол „эзвсэг“ болсон дархлалын системийг сонгон гэмтээдэг байна. Ийм нөхцөлд архаг овчинүүд хурцдаж, явц нь хүнд рээд зотсохгүй олонтоо тохиолддог хенгэн явцтай халдварт овч-

нүүд болох амьсгалын дээд замын халдварт өвчин, томуу, гэдэсний савханцаараар үүсгэгдсэн өвчин зэрэг нь ч нэн хүнд явцтай болж, олонхи тохиолдолд үхлээр төгсөж байна. АНУ-ын харшилын ба халдварт өвчний хүрээлэнгээс „Ю. С. Ньюс энд Уорлд рипорт“ сэтгүүлд хэвлүүлсэн илтгэлдээ дархалын олдмол дутагдлын хам шинж (ДОДХШ)-ээр өвчилсөн хүмүүсийн 50 хувь нь ухэж байгааг тэмдэглэжээ. Өөрөөр хэлбэл дээрх өвчнүүдийн уед тохиолдож байгаа үхлийн хувь нь урвах тахал, янз бүрийн балнад энцефалит зэргээс мэдэгдэхүйц давж байна. ДОДХШ-ны тахал байдлаар тархаж байсан нь түүнийг халдварт өвчин байж болох талаар анхны таамаглал нь 1983 онд АНУ-ын хавдар судлалын улсын институтын Роберт Галло, Парисын Пастерын нэрэмжит институтын эрдэмтэн Люк Монтагнер нарын судалгаагаар бүрэн батлагджээ. Үүнд энэ өвчний үүсгэгч нь урьд нь судлагдаж мэдэгдээгүй, өвчин үүсгэх чадвар маш ондортай, хүний III хэв шинжийн ретровирус (HTLV-III) байсан байна. Энэ вирус нь бие маход бодааан хугацааны туршид, далд байдлаар үржин есөж, хуримтлагдаж байдаг „удаан“ вирусын бүлэгт хамарагдана. ДОДХШ-ийн нууц үеийн хугацаа нь халдвартлагдсан механизмаас хамааран 3—9 сар цаашилбал 5 жил хүртэл үргэлжиж болно гэж үзэж байна.

Энэ өвчний уед халдварт нь арье, салст бүрхүүлийн гэмтсэн хэсгээр дамжих бөгөөд хоол боловсруулах болон амьсгалын замаар дамжсан тухай баримт одоогоор байхгүй байна. Өвчний үүсгэгч, түүний хэсгүүд нь шүлс нуулимс, нугасны ус, отгон шингэнээс олдож байгаа боловч үүсгэгчийг дамжуулагч үндсэн хүчин зүйл нь цус, цусны бэлдмэлүүд гэж үзэж байна. Бэлгийн замаар халдах явдал давамгай тохиолдож байгаа бөгөөд ийм ч учраас уг өвчний анхны тохиолдолууд нь бэлгийн харьцааны гаж буруу, садар самруун явдал үйлдэгчдийн дунд илэрсэн байна.

Үүнтэй холбоотой эхний уед AIDS-өвчнийг зан суртахууны ялзралын үр дагавар гэж үзэж байлаа. Хэсэгт хугацааны дараа энэ өвчин хар тамхичдын дунд ариун бус шприцээр дамжин тархаж байгаа талаар мэдээлж эхлэв.

Дараа нь цус, цусны бэлдмэлүүдийг байнга хийлгэдэг гемофиль болон цусны бусад өвчинеөр өвчилсөн хүмүүст цусаар дамжин халдвартлаж байгаа нь тогтоогдов. Түүнчлэн нярай хүүхэд эхээс нь ихсээр дамжин халдвартласан ДОДХШ оношлогдсоны дараал сая В хэлбэрийн вируст гепатиттай адил төсөөтэй өвчин болох нь тодорхой боллоо. Гепаднавирусын язгуурын В гепатитын вирус нь 20 гаруй жилийн өмнө нээгдсэн боловч одоо болтол чаг вирусын элэгний эсэнд үржиж өсөх сицгой чанарт нэлдэөлж чадах арга, хэрэгсэл бүтээж чадаагүй хэвээр байна.

Үүнтэй холбоотой В гепатититаар өвчлөгсдийн 5 хувьд өвчин архаг гепатит болон элэгний циррозод шилжиж байна. В гепатитын вирус нь мөн „аажим“ вирусын бүлэгт хамарагдах ба элэгний цирроз үүсэх нь далд хэлбэртэй, шинж тэмдгийн онцлог илрэлгүйгээр 10—15 жил цаашилбал 20 жил хүртэл хугацаанд үргэлжилдэг байна. ДОДХШ өвчилсөн хүмүүсийн 90 хувьд нь В гепатитын вирус илэрч байгаа нь эдгээр өвчний хооронд харилцан холбоо, уялдаа байж болзошгүйг харуулж байна. Ингэж үзвэл одоо дэлхий дээр ДЭХБ-ын мэдээгээр 120 сая хүн В гепатитын вирус агуулж байгаагаас зөвхөн АНУ-д 100—150 мянган хүн-вирус агуулагч байгаа нь ДОДХШ-ийн халдвартын эх уурхай болж байж болзошгүй юм гэсэн таамаглал байна. HTLV-III вирусын бие маход бодох халдах явдлыг судалсан судалгааны урьдчилсан дүнгээс

үзэхэд энэ вирусын „довтолгоонд“ юуны өмнө дархлал үүсэх механизмд туслах зохицуулах үүргийг гүйцэтгэдэг лимфоцит (Т-хелпер) өртдөг байна.

ДОДХШ-ийг үүсгэгч вирусээр халдвартлагдсанаар хэдэн мянган жилийн туршид боловсорч ирсэн дархлалын хэвийн ажиллагаа алддагддаг болох нь тодорхой. Энэ вирусын нөлөөгөөр гэмтсэн Т-лимфоцит нь өөрийн дархлалын үйл ажиллагааг зохицуулах чадвараа алдаж, олон тоогоор мөхдөг байна. Үнийн зэрэгцээ HTLV-III нь гранулоцит зэрэг цусны цагаан цогцосны бусад хэлбэр, тархины эд эсэд амьдарч, уржиж байгаа нь тогтоогдов. Дээрх байдлаас үндэслэн зарим тохиолдолд ДОДХШ-ийг Т-хелперийн өвчин гэж нэрлэж байна.

Дархлалын хамгаалалтаа алдсан бие мохбодод урьд нь арьс, салст бүрхүүл, хобл боловсруулах замын эрхтэнд гэм хоргуйгээр, оршиж байсан вирус, нян, мөөгөнцөр зэрэг нь ямар ч хяналт, саадгүйгээр их хэмжээгээр уржиж эхлэдэг байна. Онцгой ихээр уржиж өссөн тэдгээр бичил биетнууд нь ихээхэн хүнд явцтай бөгөөд эмчилгээний аргад бараг дарагдаггүй халдварт өвчинүүдийг үүсгэдэг байна. Бие махбодын эрүүл, хэвийн иехцөлд янз бүрийн эд эрхтэнд генетикийн мутацийн үр дүнд одор бүхэн үүсэх боловч тэр даруйдаа бие махбодын хамгаалах урвалын нөлөөгөөр үхэж, сарнидаг хавдар үүсгэгч вирус нь саад, хаалтгүйгээр үржиж оссеноос өмөн үү болон хавдарын бусад хэлбэрийн өвчинүүд үүсэх зам нээгддэг байна.

Энэ мэт байдлаас шалтгаалан хэдийгээр ДОДХШ өөрөө үхлийн шууд шалтгаан болохгүй боловч түүгээр халдвартлагдсанасаас хойш 2 жилийн дотор гэхэд өвчилсон хүмүүсийн тал хувь нь нас бардаг ажээ. АНУ-д судлаачид, ойрын үед ДОДХШ-ийн өвчиний үхлийн шалтгааны дотор зүрх судасны болон хорт хавдрыг гүйцэж түрүүлэн эхний байранд гарч ирэх хандлагатай байгааг тэмдэглэж байна.

ДОДХШ-ийн өмнэл зүйн илрэл нь олон янз бөгөөд чухам энэ өвчиний үед зайлшгүй илэрч байдал шинж тэмдэг гэж ялган гаргаж чадахгүй байна. ДЭХБ-ын мэдээгээр (1983 он) онош тогтооход бүрэн хүрэлцээтэй үндэслэл болж чадахгүй боловч биеийн ерөнхий байдал муудах, даамжирсан сулралт болох, анхаарал, ажлын чадвар буурах, лимфийн буячирхайнууд нэлэнхүйдээ томрох шалтгаангүйгээр удаан хугацаагар халуурах, шөнийн цагт их хөлрөх, өтгөн тогтвортгүй болох, биеийн жин мэдэгдэхүйц (7—10 кг-аар) буурах, улаан цогцосны түнхэд хугацаа хурдах зэрэг ерөнхий шинж тэмдгүүд энэ өвчиний үед илэрдэг болохыг тогтоожээ.

Цаашид хэсэг хугацааны дараа уушгины хөндийт үрэвсэл буюу Каношийн хавдар гэж нэрлэгддэг хагас хорт хавдар үүсдэг байна.

Дархлалын систем хэвийн, эрүүл хүмүүст ховор тохиолддог энэ өвчин ДОДХШ-ээр өвчилсон хүмүүсийн 9/10-д тохиолдож байгаа бөгөөд цаашдаа өвчлөгсдийн 75%-д нь үхлийн шалтгаан нь болдог. Өвчлөгсдийн 30%-д нь тархины эдийн буглаа, тархины судасны гэмтэл, тархины лимфийн хавдар, мөөгөнцөрийн шалтгаантай менингит зэрэг төв мэдрэлийн системийн эмгэгүүд илэрнэ.

ДЭХБ-ын дүгнэлтээр ДОДХШ- нь архаг буюу дахих явцтай халдварт өвчнөөр өвчилсон хүмүүст олонтаа илэрч байгаа нь энэ өвчиний үед эсийн дархлалын механизмыг гэмтдэг болохыг харуулж байна.

Гэхдээ гадна байдлаас үзвэл уг өвчин байж болзошгүй шинж тэмдэг илрэх нь оношийн алдаа гарахад хүргэж болох юм. Өөрөөр хэлбэл хүн амын анагаах ухааны мэдлэг эрс дээшилсэнтэй холбоо-

той. ДОДХШ нь чухамдаа огт байхгүй „газарт“ илэрч болох талтайг судлаачид анхааруулж байна.

Цаашилбал хүний амьдралын янз бүрийн үе шатанд бие махбодын биологийн хэмнэлтийн үечлэлтэй холбоотой, эсвэл даарах, өлсөх, цацраг туяаны нөлөөлөлд орох, хэт ядрах, сэтгэл санааны хямралд автагдах зэрэг гадаад орчны тохиromжгүй нөлөөллийн дор эсийн дархлалын системийн түр зуурын дутагдал буюу дархлалын хоёрдогч дутагдал үүсч болдог. Ийм үед халдварт овчний явц нь ужиг буюу үе үе сэдрэх байдлаар явагдах нь олонтой тохиолддог.

Бидний судалгаагаар (1983 он) вируст гепатитын хурцдах, дахих нь гол төмөр Т-лемфоцитийн үйл ажиллагааны идэвх хямарсан өвчтөнүүдэд тохиолдож байгаа нь ажиглагдлаа. Дархлалын хоёрдогч дутагдлын гол ялгаа нь богино хугацаанд хэвийн байдалдаа эргэж орох зарим үед физиологийн ерийн хэлбэлзэл шинжтэй байдагт оршино. Гэтэл ДОДХШ бүрэн оношлогдсон нэг ч тохиолдолд дархлалын үйл ажиллагааны алдагдал өөрөө аяндаа буюу эмчилгээний үр дүнд хэвийн байдалдаа эргэж орсон нь тэмдэглэгдээгүй бөгөөд эмгэг байдал нь эргэлт буцалтгүй шинжтэй болдог байна.

ДОДХШ-ийг лабораторийн аргаар оношлох явдал эхлэлийн төдий шатандаа байна. Оношигт хөдөлбөргүй батлах арга нь өвчтөний цусанд HTLV-III вирусын эсрэг овормоц эсрэг биенийг илрүүлэх явдал мон.

Үүнд шаардагдах лабораторийн шинжилгээний оношлуурыг урьд В гепатитын радио ба энзимо-иммуны аргаар оношлоход хэрэглэдэг оношлуурыг гаргаж нэrd гарсан „Органон“ „Эббот“, зэрэг пүүсүүд бага хэмжээгээр үйлдвэрлэж байна.

Дархлалын системийн үйл ажиллагааг бүхэлд нь шинжлэн үзэх замаар ДОДХШ-ийг тойруу замаар оношлож болох юм.

Бүх тохиолдолд Т-эс юуны өмнө Т-хелпер сонгомлоор багасгантай холбоотой лифопения болно.

(1 мм³ цусанд 400 хүртэл буурна) Т-супрессор эсийн индекс нэг хүртэл буурах нь өвөрмөц оцлог шинж болно.

Дархлалын В системд өөрчлөлт бараг гаражгүй боловч арьсанд эсрэг торөгчөөр харшил судлал (туберкулин г. м) тавихад мэдрэг бус болох нь оцлог байдалтай.

ДОДХШ-ийг эмчлэх үр дүнтэй арга одоогоор байхгүй байна. Дархлалын системийн Т эсийн үйл ажиллагааг идэвхжүүлдэг сэргээхэд хэлбэрийн булчирхайндын гормон, осолтийн гормон, Левамизол, цэврээр ялгасан лимфоцит, интерферон зэргийг хэрэглэсэн үед түр зуурын нааштай байдал ажиглагддаг байна.

Нилээд бэлдмэлүүдийг туршиж байгаа боловч одоогоор тодорхой үр дүнд хүрч чадаагүй байна. Зарим оронд генийн инжирчлэлийн аргаар HTLV-III вирусын дарангуйлах нөлөөллоос Т лимфоцитыг хамгаалах чадвартай синтетик вакцин гарган авах оролдлого хийж байна.

В гепатитын эсрэг вакцинаар тариулсан хүмүүэт ДОДХШ ховор тохиолдож байгаа баримт анхаарал татаж байна. ДОДХШ-ээр өвчилсон хүнтэй хавьталь болсон үед В гепатитаас сэргийлэхэд чиглэсэн дэглэмийг баримтлах нь зүйтэй боловч энэ өвчний нууц үеийн хугацаа маш удаан үргэлжилдэг учраас хамгаалах дэглэмийн арга хэмжээ үр дүн өгөх нь эргэлзээтэй байна.

Анагаах ухааны дээд эрдэмтэн И. С. Марковын бич-сэнийг орчуулсан С. Цоодол

МАХН-ЫН XIX ИХ ХУРЛЫН ШИЙДЗЭР
АМЬДРАЛД

ШИНЭ ЗОРИЛТ, ШИНЭ АРГА БАРИЛ,
ШИНЭ ҮР ДҮН

МАХН-ЫН XIX ИХ ХУРАЛ ХУРАЛДАЖ ДУУССАНЫ ДАРААХАН ХОТ, ХӨДООД НИЙТ ЭРҮҮЛИЙГ ХАМГААЛАХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ БАЙГУУЛЛАГУУДЫН ЭМЧ, МЭРГЭЖИЛТЭН АЖИЛЧИД ЦУГЛААН ХИЙЖ, НАМААС ЭМНЭЛГИЙН АЖИЛЧДЫН ОМНЭ ДЭВШҮҮЛЭН ТАВСАН ШИНЭ, ПУХАЦТАЙ ЗОРПЛТЫГ ХАЛУУНААР ХҮЛЭЭП АВЧ ОНОСТИЙН АЖЛЫНХАА БАЙДАЛД ДҮН ШИНЖИЛГЭХ ХИЙЖ, ХОЙШИД ХЭРХЭН АЖИЛЛАХ ТАЛААР ТОДОРХОЙ ШҮҮМЖЛЭН ЯРИЛЦЛАА.

Улаанбаатар хотын эрүүлийг хамгаалах байгууллагын удирдах ажилтны цуглаан дээр Эрүүлийг хамгаалах яамны сайд Ч. Цэрэннадмыд эрүүлийг хамгаалах байгууллагын ажилд оршиж байгаа дутагдал, догоолдлын шалтгааныг шинжлэн дүгнээд, шинэ сэтгэлтээ цоо шинэ арга барилаар уйтагчай ажиллаж байж, хэвшиж тогтсон үзэс генгэрөосен сэтгэхүй, ажлын арга барилаас салж чадна гэж онцлон тэмдэглэв.

Эмч, мэргэжилтэн нар овчтөнд мэргэжлийн дээд түвшинд онош тавьж, эмчилгээ хийж байгаа нь тодорхой билээ.

Гэвч тэдний удирдаж байгаа эмнэлэг, тасаг, кабинетын эмч, сувилагч, асралч нар овчтөнийг асрах эмчилж сувилах, халамжлах нь жигд бус байдаг нь нууд биш зүйл юм. Эрүүлийг хамгаалах байгууллага нь хамгийн олон эрдэмтэнтэй салбарын нэг. Гэтэл ходеөгийн эмнэлэг, урьдчилан сэргийлэх аль нэг салбарт үр бүтээлтэй ажиллаж байгаа эрдэмтэд одрийн од шиг доохөн байгааг эмч, мэргэжилтнүүд зүйл ёсоор шүүмжлэв.

„Ходеөгийн хүн амд зориулсан эмнэлгийн үйлчилгээг оргөтгөн сайжруулахад ойрын жилүүдэд гоц анхаарал тавих нь зүйтэй“ гэж МАХН-ЫН XIX ИХ ХУРЛААС ЗААСАН ЧУХАЛ ЗААЛТЫГ БИЕЛҮҮЛЭХЭД ЭН ТЭРГҮҮН НАРИЙН МЭРГЭЖЛИЙН ЭМЧ, ЭРДЭМТЭН НЭН ЧУХАЛ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭХ ЁСТОЙГ ЦУГЛААНД ОРОЛЦСОН ОЛООН ХҮН ЯРИВ,

Урьдчилан сэргийлэх ажлын зохион байгуулалтыг олон талаас нь бууртай бодож хот, ходеөгийн амбулатори, поликлиникийн үйлчилгээг оргөтгөх, эмийн бус эмчилгээний тасаг, кабинет олноор байгуулах, эмч, овчтөний аль алиных нь „Сайн эмээр туушандах“ эмчилгээний сэтгэхүйг даван туулах зэрэг ажилд Эрүүлийг хамгаалах яамны хариуцсан газар, хэлтэс, тасгүүд цаг алдалгүй зоригтой шамдан орох нь зүйтэй байна гэж цуглаанд оролцгчид ярилаа.

Энэ таван жилээс эхлээн цааш үргэлжлэх эх нялхсын эрүүл мэндийг сайжруулах томоохон программд зориулсан хөрөнгийг оновчтой ашиглаж эцсийн үр дүн болох эх нялхсын эрүүл мэндийн гол үзүүлэлтүүд сайжирсан байх маш хариуцлагатай ажил Эрүүлийг хамгаалах яамны онцлон анхаарах ажлын нэг болиж байна.

Зарим овчнийг тодорхой хэмжээгээр бууруулах арга замын талаар эрдэм шинжилгээний байгууллагын хийж байгаа ажил удаашралтай, хамгийн гол нь практикт нэвтэрсэн онцлогогоо эмчилгээ-

ний дорвийтой бүтээл бараг байхгүй байгааг эмч, мэргэжилтэн нар шүүмжиллээ.

Ходолмөрчдөөс зүй ёсоор гарч байгаа гомдол, шаардлагын дагуу эмнэлгийн хамт олон эмч, сувилагч, асрагч нар дүгнэлт хийж, алхам тутамдаа хянамгай, боловсон, шуурхай ажиллах арга ажиллагааг эзэмших цаг болжээ гэдгийг олон хүн тэмдэглэлээ.

Зарим эмнэлгийн хаалга хананд „нэг ч хүний гомдоохгүй үйлчилье“ гэсэн уриа лоозон хадсан байдаг мортлөө, үйлчилгээ тийм сайнгүй байдаг зэрэг хэлбэрдсэн зүйл их байгааг бас шүүжлэн ярилцав.

Ялангуяа эмч, эмнэлгийн ажилчдын хүнтэй харьцах хандлага, ёс суртахууны хүмүүжилд эрс өөрчлөлт гаргах нь зүйтэй байна гэж хот, хөдоогийн цуглаанд оролцогсод үзлээ.

Эрүүлийг хамгаалах байгууллагын тулгамдсан эдгээр зорилтыг биелүүлэхэд орон нутгийн нам, улсын байгууллагууд шинэ арга барилаар яв цав тохирсон ажил өрнүүлэх нь зүйтэй байна.

III. Ванчаарай

ХУРАЛДААН БОЛОВ

1986 оны 4 дүгээр сард Энэтхэг улсын Шинэ Дели хотноо Дэлхийн Эрүүлийг Хамгаалах Байгууллагын Зүүн өмнөд азийн бүсийн Анагаах ухааны эрдэм шинжилгээний зөвлөх хорооны 12 дугаар хуралдаан болж, ДЭХБ-ын Зүүн өмнөд азийн бүсийн хорооноос анагаах ухааны эрдэм шинжилгээний ажлыг хөгжүүлэх талаар хийж буй ажил, ДЭХБ-ын Төв Штабын Анагаах ухааны эрдэм шинжилгээний зөвлөх хорооны 27 дугаар хуралдааны дүн, эрүүлийг хамгаалахын холбоо долтой дэвшилтээ шинэ технологийг хөгжингүй орнуудаас хөгжин буй орнуудад шилжүүлэн авах тухай, эрүүл аж төрөх дадал заншлын тухай, эрүүлийг хамгаалах системийн судалгаа, эрүүлийг хамгаалахын эдийн засгийн судалгаа, халдварт бус овчинтэй тэмцэх чиглэлд бүсийн хэмжээнд баримтлах чиглэл, гишүүн орнуудын эрдэм шинжилгээний хүчин чадлыг бэхжүүлэх тухай зэрэг асуудлыг хэлэлдэж зөвлөмж гаргав.

Уг хорооны ээлжит 13 дугаар хуралдааныг БНМАУ-ын засгийн газрын урилгаар 1987 оны 6 дугаар сард Улаанбаатар хотноо хийхээр тогтов.

П. Нямдаваа

Ухамсартай сахилга хүний захирч удирдана

ХАРИУЦЛАГА БОЛ УХАМСАРТАЙ САХИЛГЫН ХЭМЖҮҮР МӨН

Эмч хүн бол ард түмний аз жаргал, эрүүл энхийн төлөө хэзээд бэлэн байдаг дайчин байлдагчид юм. Эмчлэх үйлс бол шинжлэх ухаан бас урлаг мен гэж эрдэмтэд үздэг. Эмчийн ажил нь ухаанаар хийх ажил болохоос биш зовхөн дадлагаар хийдэг ажил биш. Нэр хүндтэй олондоо алдартай сайн эмч больё гэвэл хүний

сайхан чанар бүгдийг эзэмшсэн байх хэрэгтэй. Эмч хүн хөдөлмөрчин олон, ард түмэндээ үргэлж хүндлүүлэн хайрлагдах учиртай. Иймээс ч бид нам засаг, ард түмэн, эх орныхоо өмнө тангараг өргөсөн юм. Өвчтон, түүний ар гэрийнхэн эмч бид наарт хамаг итгэлээ хүлээлгэдэг. Ер нь олны хүндэтгэл тэдэг чинь орчлонд ховор шигнал юм.

Өвчтоний ариун сайхан санааг эмч хүн хөсөрдүүлэхгүйн тулд тогс хүмүүжилтэй, хүний занчаны хамгийн сайн сайхнаар биеө чимсэн, цуцашгүй хөдөлмөрч, харьшгүй хатан зоригтой, энэрэнгүй зөөлөн өровч сэтгэлтэй эмч л өвчтоний амь амьдралыг нь зөв шийддэг билээ. Эмч өвчтонийг хүлээн авангутаа оношийг нь зөв тогтоож эмчилнэ гэдэг тийм ч хялбар зүйл бишээ. Оношийг зөв тогтооход мэргэжлийн чадвараас гадна өвчтонд тавих хайр халамж хамгаас чухал юм.

Өвчтонийг ямар ч нөхцөлд үсвэн тааж барагцаалах, бусдаас дуулж сонссон мэдээллээр хам хум үнэлэлт өгөх, үл тоомсорлох, хайнга байдлаар хандаж болохгүй. Хүний хамгийн сайхан сэтгэл ондөр дээд чанар нь бусдад хүргэж байгаа тусаар илэрдэг. Авсан тус багаддаггүй, өгсөн тус ихэддэггүй. Хүн бур хүч гаргаж уйтгүй зүтгэж, идэвхтэй тэмцэж ажилласнаар амжилтанд хурдэг билээ.

Даяар дуурсагдах алдар цууг эмч хүнд юу өгдөг вэ? гэвэл ухамсарт, бүтээлч, ариун цагаан хөдөлмөр өгнө. Нийгэм, хамт олныхоо өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхэд нь тэр хүнд ямар туслацаа хэрэгтэй байна вэ? гэдгийг яг цаг хугацааг нь олж тусальjal үр дүн өгдөг. Хүнтэй ажиллахад тэр хүний зан араншин бодол санааг сайн судалж ямар аргаар ажиллавал таарах вэ гэдгийг ойлгоход л эмч ажилтнууд байнга анхаарах нь чухал. Өөртөө ондөр шаардлага тавьж, шинийг бодож сэдэж ажилд бүтээлчээр хандах нь эмч бидний анхаарвал зохих зүйл мөн. Ажилдаа тааруу хүнтэй ажиллахад учир шалтгаан нөхцөлийг нь судалж үзэхгүйгээр уурлаж зандчих, тэгэх ингэх ёстой гэж мэдэмхийрэхгүй, зелдэг даруу, энгийн ягуухан сургаж зөвлөх нь чухал байдаг. Өнөө үед аливаа ажил асуудалд намаас тавьж байгаа шаардлагын хэмжээгээр хандахгүй бол ажлыг зохион байгуулах арга ажиллагaa маань олон түмэнд гологдож хамт олны анхаарал, санаа бодлыг татааж чадахгүйд хүрнэ.

Өөрөөр хэлбэл хуучин арга барилаар амжилт гаргаж чадахгүй болж олны итгэлийг алдагдуулахад хүргэж болно. Ийм учраас хөдөлмөрчин олон түмний улс төр, хөдөлмөрийн идэвх ухамсар их ессөн түвшингөөс ажлынхаа арга барилыг байнга цэгнэн үзэж дүгнэлт хийж байх нь чухал юм. Хүн оорийн ажлын арга барил Үр дүнд сэтгэл тайвширч шүүмжлэл дүгнэлтгүй хандвал алдаа гарахад хүрнэ. Эмнэлгийн ажил бол хүнтэй ажиллах шинжлэх ухаац гэж хэлж болно. Энэ ажлын эцсийн зорилго нь хүнийг өрүүлэнх, урт удаан наслуулж нийгэмд хүн бүрийн гүйцэтгэх үүрэг эзлэх байрыг нь тодорхойлж тэр залуу ажил хөдөлмөрөө хийж үр бүтээлтэй ажиллахад оршино.

Эмч мэргэжилтэн жилээс жилд олширч төрөл бүрийн нарийн мэргэжил эзэмшигч олноор төрөн гарч үйлчлэх хүрээ өргөжин эмч нарын эгнээ залуужсаар байна.

Залуу хүнд өорт нь ашиглагдахгүй байгаа нөөц асар их байна. Сэггэл зүтгэлийн нөөц, сэтгэлгээ оюуны нөөц, цаг завын нөөц, санаачлага идэвхжлийн нөөц, энэ их хэмжээлшгүй нөөцийг хэрхэн зохистой ашиглаж байгаа байдал, чин ариун сэтгэл, ган халуун эрмэлзлэл, бие хайргүй хөдөлмөр бүхэн тэр цагтаа тодийгүй он жилүүдийн урсгалд тодордог. Энэ их нөөцөө ашиглахгүй, аж

лаа хөнгөн байлгахыг бодож бие бие рүүгээ өвчтонийг дамжуулан чирэгдүүлэх явдал гаргаж болохгүй. Хамгийн их хариуцлагатай ажиллахыг шаардаж байгаа өнөөгүйд өвчтонийг хамтран үзэж зөвхөн оношийг ботино хугацаанд зөв тогтоо боломж бүрэн байна. Эмчийн хөдөлмөр их эмзэг хүнд хөдөлмөр, ямагт хичээл зүтгэлтэй байхгүй бол ямар ч цаг мөчид алдаж болно.

Үүнд эмч бүхэн шүүмжлэлээр нөхрөө хийж, сурлагаар хания хийж буураал ахмадуудын сургаалийг үргэлж сонсож оорийнхөө сурсныг бусдад мэдүүлж байх зорилготой байх ёстой. Эдүгээ эмч нарын ихэнх алдаа мэргэжил мэдлэггүйдээ биш, гол нь өвчтонийгээ энэрэн хайрлах сэтгэл дутаж, тэднийг хүндэлж үнэн санаанаасаа эмчлэхээр хүч нөөцөө дайчлаагүйгээс гарч байгаа нь харамсалтай.

Эмнэлгийн ажилчин гэдэг уг ондөр хариуцлага энэрэнгүй сэтгэл гүн хүндэтгэлийг илэрхийлнэ. Өвчин эмгэгийн уй гашуунд нэрвэгдсэн хэн бүхэн юуны өмнө эмнэлтийн тусламж эриэ. Эрүүл саруул/болж зовлонгоос ангижирсан хэн бүхэн эмчээ дурсан санаж хайрлаж явах нь лавтай.

Эрүүлийг хүссэн хэн бүхэн эмчээс асууж лавлах зүйл их байдаг. Энэ бүхэн эцсийн эцэст эмч хүний нандин чанар ёс суртахууны онцлогийг илэрхийлнэ. Үнэхээр ч эмнэлгийн ажилтан хүн, хүний амьдралд гүнзгийг нэвтэрч амь насыг нь хариуцан эрүүл мэндийг нь хамгаалдаг онцлог мэргэжил эзэмшигээний хувьд ёс суртахууны овермоц хэм хэмжээтэй байдаг. Эмчийн овормоц ёс суртахууны хэм хэмжээнд үндэслэгдэж, түүний нийгэмтэйтгээ харьцах харилцаа эмч сувилгачдын хоорондын харилцаа эмч нар хоорондоо харьцах харилцаагаар тодорхойлоғдоно. Эмч хүн үнэхээр сэтгэл зовж ажиллавал хүч хүрэхгүй алдах нь ховор байдаг.

Өнгөрснийг дурдахад би оюутны ширээний араас 1941 онд Өмнөговь аймгийн Луус суманд очоод бүтэн жил ажиллаж, дараа нь ардын хувьсгалт цэргийн албанад татагдаж байсан маань он жил улиран өнгөрөвч огт мартагдаггүй юм.

1945 онд милитарист японыг бут цохииж, тэр тусмаа тэмцлийн фронтод ахан дүү шиг нөхөрлон дасаж эх орон, ард түмнээ гэсэн нэгэн санаа зоригийг зүрхэндээ тээж явсан бидний оргилуун залуу явсан минь тэртээ 40 жилийн өмнө билээ. Зөвлөлтийн улаан армийн дайчдын хамт мөр зэрэгцэн аагим халуун, элсэн манхан ээрэм тал, аадар бороо, зэрэг байгалийн түмэн бархшээл, дайсны эсэргүүцэл, агаарын олон удаагийн дайралтыг сорен туулсан олон мөч тулгарч байсныг бидний дайчин нохөд сайн мэднэ. Тэр үеийн идэр залуу дайчин бид өнөө 60 гарсан буурлууд болжээ. Гэхдээ эх орныхоо энхийн бүтээн байгуулалтын энэ хөгжлийн түргэн алхаатай хөл нийлүүлэн, хөдөлморийн талбарт хүч чадлаа сорьж ирлээ.

Эмнэлгийн ажлыг 45 жил хийж, зөвлөлтийн мэргэжилтэн нөхөтэй хамт ажиллаж тэдний ажлын арга туршлагаас оөртөө шингээж авах юмсан гэж дагаж ажилладаг байлаа. Зөвлөлтийн хүмүүс ондор соёлтой, орөвч сэтгэлтэй, хүмүүс байдаг.

Бид тэдний тэр сайхан чанарыг эзэмшинэ гэдэг нэр торийн хэрэг ээ. Бидний үеийхэн тэднийг дууриаж ажиллахыг их хичээдэг байлаа.

Ахмад бид аз жаргал, баяр цэнгэл, алдар хүндэтгэлийг бишгүйдээ сонсож нас ахивч сэтгэл итгэл улам залуугаараа байна.

Насны наран хэлбийн чадал буурлаа гэж сэтгэл мохолгүй идэрийн золбоогоор явдаг нь манай настан буурлуудын бахархалтай сайхан чанар билээ.

Ер нь эмч хүнд анхаарууштай зүйл байдаг. Үүнд: мэдлэг мэр-гэжлээ байнга дээшилүүлж ном хэвлэлийг байнга уншдаг зуршил-тай болсон байх хэрэгтэй. Өөртөө үзүүлэхээр ирсэн өвчтонийг ямар ч өвчтон байлаа гэсэн үзүүлэх ёстой тусlamжийг үзүүлиж байж, дараа нь мэргэжлийн эмчид шилжүүлэх хэрэгтэй. Эмч хүнд нэрэлхэх, бие тоох, явцуу ашиг сонирхлыг урьдал болгох хаягаа манаах, хал балгүй хялбар арга хайх, нүд хуурах, хүнд суртал гаргах, хэлбэрдэх, асуудлыг дээш доош нь идэвхгүй дамжуулах зэрэг буруу явдал хэзээ ч гаргаж болохгүй.

Эмч өөрөө шийдэж мэдэхгүй зүйлийг ноходтэйгээ заавал зөвлөж, хамтран шийдэж байх нь чухал.

Эмч өвчтонд халуун дотно сэтгэлээр тусалж, цаг, биеэ хайлалгүй үйлчлэх хэрэгтэй.

Эмч хүн бол ёс суртахууны ондөр соёлтой, улс төр, хуулийн мэдлэгтэй, ажлын хариуцлага сайтай, зарчимч байх ёстой.

Эмч хүн шинэ нохцөл шаардлагатай уялдуулан шинээр сэтгэл, хэвшмэл байдлыг алс хэтийн ондор үр дүнд хургэх эрмэлзэлэлийн ууднээс зоригтой халан оорчилж, идэвхтэй санаачлах явдал намын бодлого, ард түмний хүсэлд гүнээ нийцэх нь эргэлзээгүй юм.

Эмч хүн ололтонд зорижиж, дутагдалд хатуужиж, шүүмжлэлд урагшлах ёстой.

Хүнд бэрх цаг үед нам улс, эх орныхоо үүрэг даалгаврыг нэр төртэй биелүүлж хүчин зүтгэж явсан ахмад эмч бидний усэнд монгөн сор сууж, нас сүүдэр ондөр боллоо ч гэсэн нам засаг биднийг халамжилж залуу хойч уе маань гүн хүндэтгэж байдагт бид сэтгэл зурхнээсээ баярлаж, мэдэх чадах бүхнээ өрүүлийг хамгаалах, эх орон, нам засаг залгамж хойч үедээ зориулах хүсэл эрмэлзлэл дүүрэн байна.

*Цэргийн дугаар ангийн бага
эмч П. Бямбажав*

ЭМНЭЛГИЙН ХЭВЛЭЛИЙН НЭГДСЭН РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ

Ж. Раднаабазар (Эрхлэгч) Л. Буджав, Ш. Ванчаарай (Хариуцлагатай нарийн бичгийн дарга) Б. Гоош, Б. Дэмбэрэл, Г. Дашээвэг, Ч. Долгор, Ш. Жигжидсүрэн, Т. Зориг, Ж. Купул, Э. Лувсандагава, П. Нямдаваа, Б. Рагчаа, Г. Цагаанхүү, Б. Шижирбаатар, Н. Шура

Техник редактор Б. Болат Хянагч Д. Ундармаа

Өрөлтөнд 1986 оны 6 сарын 20-нд орж 2248 ш хэвлэв
Цаасны хэмжээ 70 X 108 1/16. Хэвлэлийн хуудас 6,0
х. н. х. 8,4 Зах № С—113

Д. Сүхбаатарын нэрэмжит Улсын хэвлэлийн комбинатад
хэвлэв. Д. Сүхбаатарын талбай—6

ШИНЭ ЭМ



ВОЛЬТАРЕН (Диклофенак—натрий)

Фармакологийн үйлдэл. Бэлдмэлд агуулагдах нестероид бүтэц бүхий биологийн идэвхт бодис нь үрэвслийн эсрэг, өвдөлт намдаах, халуун бууруулах үйлчилгээтэй.

Хэрэглэх заалт: Цонилог хэрх өвчин, хэрхийн артрит, Бехтеревийн өвчин (анкилозирующие спондилоартрит), артроз, спондилоартроз, үеийн бус хэрх, хүчтэй өвдөлт бүхий хэрхийн бус үрэвслүүд, бэргэлтийн дараах үрэвсэл ба хаван зэрэгт хэрэглэн.

Хэрэглэх арга, тун: Мөхөг нь гадуураа бурхүүлтэй тул ходоодны шүүний нөлөөнд задардаггүй. Мөхлөгийг хоолны дараа зажлахгүй залгина. Насанд хүргэгчийн хоногийн тун өвчиний байдлаас шалтгаалан 75—150 мг (3—6 мөхлөг). Удаан хугацаатай эмчилгээний үед хоногийн тун 75—100 мг байхад хангалтай, 6-аас дээш насны хүүхдэд биений 1 кг жинд өдөрт 2—3 мг ногдохор тооцоолон тунг тогтооно. Хоногийн тунг 2—3 хувааж хэрэглэнэ. Тарилын усмынлыг голдуу үрэвсэлтэй буюу дегенэрац өөрчлөлттэй хэрх өвчиний эхний үед мөн хүчтэй өвдөлт бүхий хэрхийн бус үрэвсрац луудийн үед хэрэглэнэ.


Хориглох үе: Ходоод ба 12 хуруу гэдэсний шархлаа, бронхийн багтраа цомцог ринит, крапивниц өвчтэй хүмүүс, жирэмсний эхний 3 сард хэрэглэхийг хориглоно. Мөн ходоод, гэдэс, элэг бөөрний өвчтэй хүмүүст болгоомжтой хэрэглэн.

Гаж нөлөө: Вольтарен ерөнхийдөө зохижк сайтай боловч зарим хүмүүст өрцөн дор өвдөх, гүлгих, бөөлжих, суулгах, заримдаа толгой өвдөх эргэх зэрэг гаж нөлөөн тай.

Эдгээр нь голдуу аяндаа арийна. Хаяя харшилын шинж илэрдэг.

Эмийн хэлбэр, савлах: 0,025 г-ын мөхлөгийг 20 ба 100, 0,05 г-ын лааг 10 ба 50, ширхэгээр г-ын лааг 10 ба 50, 0,05 г-ын мөхлөгийг 20 ба 100, 0,05 г-ын лааг 10 ба 50, ширхэгээр 0,1-ийн лааг 5 ба 50, 75 мг бодис бүхий 3 мл (2,5) 3 мл ампулыг 5 ба 50, 400 ширхэгээр савлана.

Улсын эм хангамж үйлдвэрлэлийн газрын мэдээлэл технологийн тасаг



Я. ДОНДОГ — Зүрх судасны тогтолцоог багажаар хэмжихүй

Зүрх судасны өвчин хамгийн их түгээмэл өвчиний нэг учир түүний судлах арга техник, багаж төхөөрөмжийн тоо олширч, өдөр тутмын практик ажиллагаанд нэвтрэх байна.

Тэдгээр багажийг эзэмших явцад багагүй гардаг бэрхшээлийг хөнгөвчлөх арга замын тухай энэ номонд бичжээ.

Манай эмнэлгийн практикт бүрэн нэвтэрсэн электрокардиограмм, фонокардиограмм, поликардиограмм, сфиغمограмм, реокардиограмм, рееноэнцефалограмм, реогепотограмм, реовазограмм, реопульмограмм, апискардиограмм, эхокардиограмм зэрэг шинжилгээний төрөл бүрийн арга, уул шинжилгээний дүнг эрүүл, өвчтэй хүмүүст харьцуулах сорилт хийх аргаар шалгасан байдлыг багтаан бичжээ.

Г. ЗОРИГ — Байгаль орчин эрүүл эхийн өлгий

Энэ товхимолд хүрээлэн байгаа байгаль орчин, хүний эрүүл мэндэд хэрхэн үйлчилж нөлөөлдгийг шинжилгэх ухааны хялбарчилсан хэлбэрээр бичижээ.

Түүнчлэн байгалийн хүчин зүйлс хүний бие махбодын нөөц бололцоо, хүч чадлыг дайчлан хэрхэн эрүүлжүүлж, тэсвэр хатуужилтай болгодог, байгалийн шавхагдаж баялаг, амьтан ургамлын нөөцийг хүний эрүүл мэндийн тусын тулд хэрхэн бүрэн төгс ашиглах талаар тодорхой өгүүлжээ.